Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт, зохицуулалтын газрын даргын
зөвлөлийн №30 хурлын шийдвэр

**ШИЙДВЭРЛЭСЭН НЬ:**

1. Эрүүл мэндийн яамнаас 2025 оны 12 дугаар сарын 11-ний өдрийн “Тайлан ирүүлэх тухай” 9/5903 дугаар албан бичгийн дагуу Эрүүл мэндийн салбарт үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам батлах тухай Эрүүл мэндийн сайдын 2022 оны А/346 дугаар тушаалаар батлагдсан журмын дагуу байгууллагын үйл ажиллагааны 2025 онд хамаарах тайлангуудыг Эрүүл мэндийн яаманд хүргүүлэхээр шийдвэрлэв.
2. Байгууллагын 2025 оны үйл ажиллагаанд хийсэн хяналт-шинжилгээний зөвлөмжийн хэрэгжилтийг хангаж, тайлангуудад дутуу биелэлттэй ажлуудыг 2026 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгаж, төлөвлөлтийг зөв хийж ажиллахыг газар хэлтсийн дарга нарт үүрэг болгов.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ П.АЛТАНЦЭЦЭГ

# 2025 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНД ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ ХИЙСЭН АЖЛЫН ТАЙЛАН

УЛААНБААТАР ХОТ
2025 ОН

АГУУЛГА

НЭГ. ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ЗОРИЛГО

ХОЁР.ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

ГУРАВ.БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮНЭЛГЭЭ

3.1.Байгууллагын 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт

3.2.Төрийн албан хаагчийн сургалт, нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийн биелэлт

3.3.Хэрэглэгчийн үнэлгээний тайлан

ДӨРӨВ. ДҮГНЭЛТ

ТАВ. ЗӨВЛӨМЖ

Үйл ажиллагааны үнэлгээний дүн

ЗУРГАА. ХАВСРАЛТ

6.1.Байгууллагын 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт

6.2.Төрийн албан хаагчийн сургалт, нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийн биелэлт

6.3.Хэрэглэгчийн үнэлгээний тайлан

**ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ-ЭМ, ЭМНЭЛГИЙН ХЭРЭГСЛИЙН ХЯНАЛТ, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН 2025 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНД ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ ХИЙСЭН АЖЛЫН ТАЙЛАН**

2025 оны 12 сарын 25-ны өдөр Улаанбаатар хот

## НЭГ. ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ЗОРИЛГО

Энэхүү хяналт-шинжилгээ, үнэлгээний ажлын зорилго нь Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт, зохицуулалтын газрын бодлогын баримт бичгийн хэрэгжилт, байгууллагын 2025 оны үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, удирдлагыг үнэн зөв мэдээллээр хангах, газрын үйл ажиллагааг бодитой үнэлэхэд чиглэгдсэн болно. Тус ажлыг гүйцэтгэхдээ Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 43 дугаар "Журам батлах тухай" тогтоол, Эрүүл мэндийн сайдын 2022 оны А/346 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан "Эрүүл мэндийн салбарын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам"-ыг тус тус үндэслэл болгосон.

## ХОЁР. ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

Хяналт-шинжилгээ, үнэлгээг Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт, зохицуулалтын газрын 2025 оны гүйцэтгэлийн бусад мэдээ, тайланд тулгуурлан Эрүүл мэндийн сайдын 2022 оны А/346 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан "Эрүүл мэндийн салбарын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам"-ыг баримтлан дүгнэсэн.

Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт, зохицуулалтын газрын даргын баталсан 2025 оны "Хэрэглэгчийн үнэлгээ хийх ажлын хэсэг байгуулах тухай" А/216 дугаар байгуулагдсан ажлын хэсэг Хэрэглэгчийн үнэлгээний ажлыг гүйцэтгэн ерөнхий үнэлгээ 90,8 хувь буюу 4.5 оноотой үнэлсэн.

Үнэлгээний тайланг Даргын зөвлөлийн хурлаар танилцуулан, шийдвэр гаргуулж, тайланг Эрүүл мэндийн сайдын 2022 оны А/346 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан "Эрүүл мэндийн салбарын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ үнэлгээ хийх нийтлэг журам"-ын 7.3-т заасны дагуу 2025 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн 01/2378 дугаар албан бичгээр Эрүүл мэндийн яамны Салбарын хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газарт хүргүүлэв.

## ГУРАВ. БАЙГУУЛЛАГЫН ЧИГ ҮҮРГИЙН ҮЗҮҮЛЭЛТИЙН ҮНЭЛГЭЭ

### 3.1.Байгууллагын тухайн жилийн үйл ажиллагааны төлөвлөгөөний биелэлт

Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 43 дугаар тогтоолын 3 дугаар хавсралт "Байгууллагын үйл ажиллагаа, үр дүнг үнэлж дүгнэх журам"-ын дагуу Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт, зохицуулалтын газрын Төсвийн шууд захирагчийн 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг Төсвийн ерөнхийлөн захирагч баталсан байна.

Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт, зохицуулалтын газрын 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд нийт 8 зорилтын 48 арга хэмжээг төлөвлөж, хэрэгжилтийг тайлагнасан байна. 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтэд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээгээр:

- 100 хувийн хэрэгжилттэй-33 арга хэмжээ
- 70-99 хувийн хэрэгжилттэй- 15 арга хэмжээ

Дундаж 93.5 хувийн гүйцэтгэлтэй үнэлэгдсэн.

Зураг 1. Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт, зохицуулалтын газрын 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээ /чиглэл тус бүрээр/




Мэдээллийн эх сурвалж: Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт, зохицуулалтын газрын Төсвийн шууд захирагчийн 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт

Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт, зохицуулалтын газрын Төсвийн шууд захирагчийн 2025 оны гүйцэтгэлийн тайланд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээгээр 93.5 хувийн гүйцэтгэлтэй үнэлэгдэж байна.

Тайлбар: Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт, зохицуулалтын газрын 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө, тайланг хавсаргав.

## 3.2.Төрийн албан хаагчийн сургалт, нийгмийн баталгааг хангах төлөвлөгөөнд тусгагдсан зорилтын биелэлт

Засгийн газрын 2025 оны 43 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралт "Хяналт-шинжилгээ хийх журам", Эрүүл мэндийн сайдын 2022 оны А/346 дугаар тушаалаар батлагдсан "Эрүүл мэндийн салбарын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ нийх нийтлэг журам"-ын 3 дугаар хавсралтаар захиргааны байгууллагын хүний нөөцийг тогтвор суурьшилтай ажиллуулах талаар байгууллагын зүгээс хэрэгжүүлэх үйл ажиллагаа, шалгуур үзүүлэлт, зорилтот түвшинг баталсан. Үүний дагуу

- "Төрийн албан хаагчийн сургалт"-ын хөтөлбөрийг 2025 оны 01 дүгээр сарын 15-ны өдөр батлуулж, дотоод сургалт 29, гадаад сургалт 17 буюу нийт 46 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн боловч Орон нутгийн тусгай зөвшөөрөл олгох комисс болон орон тооны бус шинжээч нарт сургалтыг Эрүүл мэндийн сайдын 2025.02.10-ны өдрийн А/40 дүгээр тушаалаар хэрэгжүүлэх арга хэмжээг зохион байгуулаагүй тул 45 арга хэмжээнд хяналт-шинжилгээ хийсэн.
- "Төрийн албан хаагчийн ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөр"-ийг хэрэгжүүлэх төлөвлөгөөг 2025 оны 01 дүгээр сарын 15-ны өдөр батлуулж, 6 зорилтын хүрээнд 22 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байна.

Хүснэгт 1. Хүний нөөцийн тогтвор суурьшлыг хангах шалгуурын биелэлтэд өгсөн үнэлгээ /2025 оны жилийн эцсийн байдлаар/

| № | Шалгуур үзүүлэлтүүд | Нийт арга хэмжээ | Хэрэгжилт /хувиар/ | | | | Дундаж хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | 100% | 95% | 70% | 0% | |
| 1 | Төрийн албан хаагчийн сургалт | 45 | 31 | 4 | 0 | 11 | 77.3% |
| 2 | Төрийн албан хаагчийн ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах | 22 | 18 | 0 | 3 | 0 | 91.3% |
| **Дүн** | | 68 | 52 | 2 | 2 | 0 | 84.3% |

Тайлбар: Хүний нөөцийг чадавхжуулах, тогтвор суурьшилтай ажиллуулах, албан хаагчдын нийгмийн баталгааг хангаж ажиллах талаар байгууллагын 2025 оны жилийн төлөвлөгөөнд тусгагдсан зорилтын биелэлтийг хавсаргав.

### 3.3. Хэрэглэгчийн үнэлгээ

Засгийн газрын 2025 оны 43 дугаар тогтоолын 3 дугаар хавсралт "Байгууллагын үйл ажиллагаа, үр дүнг үнэлж дүгнэх журам", Эрүүл мэндийн сайдын 2022 оны А/346 дугаар тушаалаар батлагдсан "Эрүүл мэндийн салбарын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ нийх нийтлэг журам"-ын 1 дүгээр хавсралтаар дагуу хэрэглэгчийн үнэлгээнд үнэлгээ хийсэн.

Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт, зохицуулалтын газрын Хэрэглэгчийн үнэлгээ нь 2025 оны жилийн эцсийн байдлаар 94.6 хувьтай байна.

## ДӨРӨВ. ДҮГНЭЛТ

Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт, зохицуулалтын газар нь салбарын хууль тогтоомж, бодлого, стратеги боловсруулах, хэрэгжүүлэх, төрийн захиргааны удирдлага, зохицуулалтаар хангах, бодлогын хэрэгжилтэд хяналт-шинжилгээ хийх, үр дүнд үнэлгээ өгөх, төсвийн болон хөрөнгө оруулалтын зарцуулалтын үр дүн, салбарын үйлдвэрлэлийн харилцан уялдааг хангах зэрэг асуудалд өргөн хүрээтэй хандаж, 2025 онд төлөвлөсөн үйл ажиллагаагаа амжилттай хэрэгжүүлсэн байна.

2025 оны үйл ажиллагааны хэрэгжилтийг 93.5 хувь буюу ерөнхий үнэлгээг 4,6 оноогоор "бүрэн хангалттай" дүгнэв.

## ТАВ. ЗӨВЛӨМЖ

*6.1. Байгууллагын чиг үүргийн үзүүлэлтийн талаар:*

Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 43 дугаар тогтоолын 3 дугаар хавсралт "Байгууллагын үйл ажиллагаа, үр дүнг үнэлж дүгнэх журам", Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт, зохицуулалтын газрын 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулахдаа бусад бодлогын баримт бичигт тусгагдсан зорилт арга хэмжээний уялдааг хангах, гүйцэтгэлийн зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ тус бүрийн шалгуур үзүүлэлтийг оновчтой тодорхойлоход анхаарах;

Байгууллагын 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулахдаа Засгийн газрын 2020 оны 217 дугаар тогтоолоор батлагдсан журам, Засгийн газрын хэрэг эрхлэх газрын 2020 оны 100 дугаар тушаалаар батлагдсан аргачлалын дагуу гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээг төлөвлөх;

Төлөвлөгөөг боловсруулахдаа стратеги төлөвлөгөө болон бусад бодлогын баримт бичигтэй уялдуулан, зорилт, шалгуур үзүүлэлтийг тодорхойлж, тухайн жилийн хүрэх түвшин, гүйцэтгэл, үр дүнг тооцох;

Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулахдаа зорилт нь үр дүнд суурилсан, бодитой, биелэгдэхүйц байх, хэрэгжүүлэх арга хэмжээнүүд нь зорилтдоо чиглэсэн байх, нөөц, төсөв, санхүүгийн эх үүсвэр тодорхой байх, шалгуур үзүүлэлт нь тодорхой, хэмжигдэхүйц байх, судалгаа, шинжилгээнд суурилсан, мэдээллийн үнэн зөв, найдвартай байдлыг хангасан, тоон мэдээлэл нь чанарын үзүүлэлтээр баталгаажсан, төрийн үйлчилгээг чанартай, хурдан шуурхай, үр дүнтэй хэрэгжүүлэхэд чиглэсэн, хууль тогтоомжид нийцсэн байх зэрэг шаардлагууд дээр анхаарах;

*6.2.Төрийн албан хаагчийн сургалт, нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийг хэрэгжүүлэх 2025 оны төлөвлөгөөний үзүүлэлтийн талаар:*

Төрийн албан хаагчийн ажиллах нөхцөл, нийгмийн баталгаа, сургалтын төлөвлөгөөнүүдийн хэрэгцээ, шаардлагыг зөв тодорхойлж, хуульд заасан үндсэн зохицуулалтыг төлөвлөхгүй, арга хэмжээнүүдийг оновчтой төлөвлөх;

Арга хэмжээнүүдийг хэрэгжүүлэхэд шаардлагатай төсөв, санхүүгийн эх үүсвэрийг санхүүгийн тооцоололд хийж, оновчтой төлөвлөх;

Эрүүл мэндийн сайдын 2022 оны 07 сарын 01-ний
өдрийн А/346 дугаар тушаалын гуравдугаар хавсралт
Хүснэгт 3.10

# ЭМ, ЭМНЭЛГИЙН ХЭРЭГСЛИЙН ХЯНАЛТ, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ЖИЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮНЭЛГЭЭНИЙ ДҮН

(2025 он)

| Үзүүлэлт | | Хувь | Жин | Оноо |
|---|---|---|---|---|
| Д/д | 2 | 3 | 4 | 5 |
| 1 | Байгууллагын тухайн жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт | 93.5 | 0.18 | 4.6 |
| 2 | Төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл,нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийн биелэлт | 84.3 | 0.16 | 4.2 |
| 3 | Хэрэглэгчийн үнэлгээ | 94.6 | 0.18 | 4.7 |
| Ерөнхий үнэлгээ | | 90.8 | 0.17 | 4.5 |

*Төлөвлөгөөг хянасан:*

ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙД
*(албан тушаал)*

*Тамга*

***ТӨСВИЙН ЕРӨНХИЙЛӨН ЗАХИРАГЧ***

.............................. *(гарын үсэг)*

Т.МӨНХСАЙХАН

2025.04.16 *(огноо)*

*Төлөвлөгөө баталсан:*

ЭМ, ЭМНЭЛГИЙН ХЭРЭГСЛИЙН ХЯНАЛТ, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ
*(албан тушаал)*
*Тамга*

***ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧ***

.............................. *(гарын үсэг)*

Н.ЭРДЭНЭБАЯР

2025.04.16 *(огноо)*

## ЭМ, ЭМНЭЛГИЙН ХЭРЭГСЛИЙН ХЯНАЛТ, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН 2025 ОНЫ ГҮЙЦЭТГЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

| д/д | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Төсөв (сая, төгрөг) | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | 2025 онд хүрэх зорилтот түвшин | Хугацаа (I-IV улирал) | Хариуцах нэгж | Хамтран хэрэг жүүлэх газар, хэлтэс |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| Стратеги төлөвлөгөөний зорилго: Чанартай, аюулгүй, эмчилгээний өндөр идэвхтэй эм, эмнэлгийн хэрэгслийн хүртээмжийг сайжруулж, үндэсний зохицуулалтын тогтолцоог Төлөвшлийн түвшин 3-т хүргэнэ. | | | | | | | | |
| **НЭГ. ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДААС ТУСГАЙЛАН ҮҮРЭГ БОЛГОСОН АРГА ХЭМЖЭЭГ БҮРЭН ХЭРЭГЖҮҮЛНЭ.** | | | | | | | | |
| 1. | БСТ1.1<br>Эм, эмнэлгийн хэрэгслийн үндэсний бодлогын баримт бичигийг боловсруулна. | - | Боловсруулсан баримт бичиг | Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт, зохицуулалтын газрын 2024-2027 оны стратеги төлөвлөгөө | Эм, эмнэлгийн хэрэгслийн үндэсний бодлогын баримт бичигийг боловсруулж, Эрүүл мэндийн яаманд хүргүүлсэн байна. | II-III | Захиргаа, удирдлагын газар | Бүх газар, хэлтэс |
| 2. | ЗГҮАХ 2.3.3.3, 2.3.3.4<br><br>Арга хэмжээ 1.3<br>Нэг эх үүсвэрээр авах эм, эмнэлгийн хэрэгслийн нэр төрлийг нэмэгдүүлнэ. | - | Гэрээ<br><br>Нэг эх үүсвэрээр авсан эмийн нэр төрөл, тоо | 2024 онд нэг эх үүсвэрээр авсан эмийн тоо- 23 | Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хууль, "Олон улсын чанарын шаардлага хангасан хүний эм, эмнэлгийн хэрэгсэл, биобэлдмэл, вакциныг гадаад улсын үйлдвэрлэгчээс, эсхүл | I-IV | Эм хангамжийн газар | Захиргаа, удирдлагын газар |

| д/д | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Төсөв (сая, төгрөг) | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | 2025 онд хүрэх зорилтот түвшин | Хугацаа (I-IV улирал) | Хариуцах нэгж | Хамтран хэрэг жүүлэх газар, хэлтэс |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | олон улсын байгууллагаас шууд болон дамжуулан худалдан авах журам"-ын төсөлд нэмэлт, өөрчлөлт оруулж, хэлцэл хийж, гэрээ байгуулан худалдан авалт хийсэн байна. | | | |
| **ХОЁР. ЭМ, ЭМНЭЛГИЙН ХЭРЭГСЛИЙН ХЯНАЛТ, ЗОХИЦУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНД ОЛОН УЛСЫН ЧАНАРЫН УДИРДЛАГЫН ТОГТОЛЦООГ НЭВТРҮҮЛЭХ** | | | | | | | | |
| 3. | БСТ 1.2<br>Байгууллагын үйл ажиллагаанд нөхцөл байдлын үнэлгээ хийж, төлөвлөгөөг шинэчлэн батлуулна. | - | Үнэлгээний дүн<br><br>Шинэчлэн батлуулсан төлөвлөгөө<br><br>Төлөвлөгөөний хэрэгжитийн хувь | Байгууллагын хөгжлийн төлөвлөгөө "2023-2026" | Байгууллагын хөгжлийн төлөвлөгөө "2023-2026"-нд хяналт, үнэлгээ хийж, сайжруулах саналыг даргын зөвлөлийн хуралд танилцуулж, төлөвлөгөөг шинэчлэн батлуулж, хэрэгжилтийн ханган ажилласан байна. | I-III | Ажлын хэсэг | Бүх газар, хэлтэс |
| 4. | БСТ 1.3<br>Эмийн зохицуулалтын гадны байгууллагатай хамтын ажиллагааг эхлүүлнэ. | 20 сая төгрөг (улсын төсөв) | Хамтын ажиллагаа эхлүүлсэн байгууллагын тоо | Бүгд Найрамдах Польш улсын элчин сайдын яам, АНУ-ын элчин сайдын яамны Ази номхон далайн бүсийг хариуцсан хэлтсийн даргатай уулзалт зохион байгуулж, цаашдын хамтын ажиллагааг хэлэлцсэн. | Нэгээс доошгүй эмийн зохицуулалтын гадны байгууллагатай хамтын ажиллагаа эхлүүлсэн байна. | III-IV | Захиргаа, удирдлагын газар | Бүх газар, хэлтэс |
| 5. | БСТ 1.4<br>Олон улсын баримт бичгийг судалж, чанарын гарын авлага боловсруулна. | 10 сая төгрөг (улсын төсөв) | Боловсруулсан гарын авлага | - | Эмийн зохицуулалтын байгууллагын чанарын гарын авлага боловсруулсан байна. | II-IV | Ажлын хэсэг | Бүх газар, хэлтэс |
| 6. | МУХТҮЧ 2.2.7<br>БСТ 1.1 | - | Хүргүүлсэн журмын төсөл | - | Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хуулийг дагаж гарах 6 журмын төсөлд санал хүргүүлсэн байна. | I-IV | Ажлын хэсэг | Бүх газар, хэлтэс |

| д/д | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Төсөв (сая, төгрөг) | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | 2025 онд хүрэх зорилтот түвшин | Хугацаа (I-IV улирал) | Хариуцах нэгж | Хамтран хэрэг жүүлэх газар, хэлтэс |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | Эм, эмнэлгийн хэрэгслийн чанар аюулгүй байдлыг хангах, хангамж хүртээмжтэй холбоотой эрх зүйн баримт бичгийг боловсруулж, батлуулна. | | Шинээр батлуулсан журмын тоо | | Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт, зохицуулалтын газрын даргаар батлуулах 5 журмыг батлуулсан байна. | | | |
| 7. | БСТ 4.1<br>Эм, эмнэлгийн хэрэгслийн үйлдвэр, хангган нийлүүлэх байгууллага, эмийн санд тавигдах нийтлэг шаардлагыг олон улсын удирдамжид нийцүүлэн шинэчилнэ. | - | Стандарт хэмжил зүйн газарт хүргүүлсэн стандартын төсөл | Эмийн үйлдвэрлэлд тавигдах ерөнхий шаардлага MNS 5524-2014<br>Эм, эмнэлгийн хэрэгсэл хангган нийлүүлэх байгууллага MNS 5530-2014<br>Эмийн санд тавигдах нийтлэг шаардлага MNS 5260-2015 | Стандарт хэмжил зүйн газарт 3 стандартын төслийг хүргүүлсэн байна | I-IV | Ажлын хэсэг | ЛЗЗГ, ЭҮХ |
| 8. | БСТ 1.1<br>Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт, зохицуулалтай холбоотой стандарт ажиллагааны заавар (САЗ)-ыг шинэчлэнэ. | - | Шинээр боловсруулсан САЗ<br><br>Шинэчлэн батлуулсан САЗ | 179 Үйл ажиллагаанд мөрдөж буй 179 САЗ | Газар, хэлтсийн үйл ажиллагаатай холбоотой 8 САЗ-ыг шинээр батлуулсан байна | I-IV | Захиргаа, удирдлагын газар | Бүх газар, хэлтэс |
| **ГУРАВ. ЭМ, ЭМНЭЛГИЙН ХЭРЭГСЛИЙН БҮРТГЭЛ, ХЯНАЛТ, МЭДЭЭЛЛИЙН НЭГДСЭН ЦАХИМ ТОГТОЛЦООГ БҮРДҮҮЛНЭ.** | | | | | | | | |
| 9. | БСТ 1.8<br>Эм, эмнэлгийн хэрэгслийн нэгдсэн цахим тогтолцоог хөгжүүлж нэвтрүүлнэ. | 950 сая төгрөг (улсын төсөв, олон улсын төсөл, хөтөлбөр) | Нэгдсэн цахим программ<br><br>Хөгжүүлэлт хийж үйл ажиллагаанд нэвтэрсэн цахим систем | Tzmoh.gov.mn<br>Licemed.mohs.gov.mn<br>EMongolia<br>Burtgel.mohs.mn<br>Heps.hdc.gov.mn<br>Ereporting<br>Lims программ<br>License.mn | Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт, зохицуулалтын нэгдсэн системийн ашиглалтанд оруулсан байна.<br>Эм, эмнэлгийн хэрэгслийн зохицуулалтын удирдлагын систем, эм, эмнэлгийн хэрэгслийн нөөц, нийлүүлэлт, хяналтын систем, лабораторийн удирдлагын системийн | I-IV | Ажлын хэсэг | Эрүүл мэндийн хөгжлийн төв |

| д/д | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Төсөв (сая, төгрөг) | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | 2025 онд хүрэх зорилтот түвшин | Хугацаа (I-IV улирал) | Хариуцах нэгж | Хамтран хэрэг жүүлэх газар, хэлтэс |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | хөгжүүлэлтийг хийж, хэрэглээнд нэвтрүүлсэн байна. | | | |
| 10. | БСТ 1.5<br>Үйл ажиллагааны нэгдсэн мэдээллийн хянах самбар (Dashboard)-ыг нэвтрүүлнэ. | - | Үйл ажиллагааны хянах самбар | - | Газар, хэлтсийн 7 хоног, сар, улирлын тоон үзүүлэлтийг цахимд байршуулж, үйл ажиллагаанд нэвтрүүлсэн байна | II-III | Захиргаа, удирдлагын газар | Бүх газар, хэлтэс |
| 11. | БСТ 1.5<br>Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль, Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллана. | - | Цахимд байршуулсан мэдээллийн тоо | Shilendans.gov.mn цахим хуудсанд 63 удаагийн мэдээлэл, Засгийн газрын нээлттэй мэдээллийн сан shilen.gov.mn системд 23 бүлэг мэдээлэл тус тус байршуулсан. | Засгийн газрын 2022 оны 201 дүгээр тогтоолоор баталсан "Нээлттэй мэдээллийг цахим хэлбэрээр байршуулж нийтлэх, шинэчлэх, хяналт тавих нийтлэг журам"-ын хэрэгжилтийн хангаж, байгууллагын чиг үүрэг, үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалт, төсөв, санхүү, худалдан авах ажиллагаа, хүний нөөцийн талаарх мэдээллийн цахимд байршуулж, нээлттэй, ил тод байдлыг хангаж ажилласан байна. | | Захиргаа, удирдлагын газар | Бүх газар, хэлтэс |
| 12. | БСТ 1.5<br>Цахим хуудсыг ажиллуулах, мэдээлэл байршуулах, шинэчлэх, хяналт тавих журам батлуулна. | - | Батлуулсан журам | - | Цахим хуудсыг ажиллуулах, мэдээлэл байршуулах, шинэчлэх, хяналт тавих журмыг батлуулж, журмын дагуу мэдээллийг ил тод байршуулсан байна | II-IV | Захиргаа, удирдлагын газар | - |
| 13. | БСТ 1.8<br>Хяналт шалгалтад хамрагдсан болон шинээр үйл ажиллагаа эхлүүлсэн байгууллагын эрсдэлийн үнэлгээ, зөрчлийн бүртгэлийг цахим системд бүртгэнэ. | - | Хяналт шалгалтад хамрагдсан байгууллагын тоо<br><br>Бүртгэгдсэн мэдээллийн тоо | Нийт 3778 байгууллагад эрсдэлийн үнэлгээ хийж, цахим системд оруулсан.<br>2024 онд 86 аж, ахуйн нэгж, 19 албан тушаалтан, нийт 109 | Шинээр байгуулагдсан болон үйл ажиллагаа явуулж буй байгууллагын эрсдэлийн үнэлгээг хийж, хяналт шалгалтад хамрагдсан мэдээллийг цахимаар бүртгэсэн байна. Зөрчлийн хэрэг бүртгэлийн ажиллагаар | I-IV | Чанарын хяналтын газар | - |

| д/д | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Төсөв (сая, төгрөг) | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | 2025 онд хүрэх зорилтот түвшин | Хугацаа (I-IV улирал) | Хариуцах нэгж | Хамтран хэрэг жүүлэх газар, хэлтэс |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Хуулийн хугацаанд шийдвэрлэсэн зөрчлийн хэрэг | зөрчлийн хэрэг бүртгэлийн ажиллагаа явуулсан. | прокурорын нэгдсэн бүртгэлд бүртгүүлж, хуулийн хугацаанд шуурхай шийдвэрлэсэн байна. | | | |
| **ДӨРӨВ. БАЙГУУЛЛАГЫН ҮНЭТ ЗҮЙЛ, ЭЕРЭГ СОЁЛЫГ БҮРДҮҮЛЖ, ТАСРАЛТГҮЙ СУРАЛЦАГЧ БАЙГУУЛЛАГА БОЛНО.** | | | | | | | | |
| 14. | АТҮХХАХТ 2.6.2.1, 3.3.1.5, 6.4.11.1, 7.1.2.1, 7.1.2.2, 9.5.2.1<br>Авлигын эсрэг үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлнэ. | - | Төлөвлөгөө<br><br>Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь<br><br>Авлигатай тэмцэх газрын үнэлгээ | Авлигын эсрэг үндэсний хөтөлбөрийг хэрэгжилт 62.5 хувь үнэлэгдсэн. | Эрсдэлд суурилсан авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулж, хэрэгжүүлсэн байна. Авлигатай тэмцэх газрын үнэлгээнд 75 хувиас дээш үнэлгээ авсан байна | I-IV | Захиргаа, удирдлагын газар | Бүх газар, хэлтэс |
| 15. | БСТ 1.6<br>Нийгмийн баталгаа хангах хөтөлбөрийг хэрэгжүүлнэ. | 167 сая төгрөг (улсын төсөв) | Төлөвлөгөө<br><br>Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь | Нийгмийн баталгаа хангах хөтөлбөр дагуу батлуулсан төлөвлөгөөний хэрэгжилт 94 хувь | Нийгмийн баталгаа хангах хөтөлбөрийн хүрээнд 2025 оны төлөвлөгөөг батлуулж, хэрэгжилтийг бүрэн хангаж ажилласан байна. | I-IV | Захиргаа, удирдлагын газар | - |
| 16. | БТС 1.6<br>Эрүүл аж, төрөх, хөдөлгөөний дутагдлаас урьдчилан сэргийлэх арга хэмжээ хэрэгжүүлнэ. | 5 сая төгрөг (улсын төсөв) | Зохион байгуулсан арга хэмжээ | Байгууллагын 5 төрөлд тэмцээн, Сайдын нэрэмжит тэмцээн | Биеийн тамир спортын арга хэмжээ зохион байгуулж, бүх нийтийн арга хэмжээнд идэвх санаачлагатай оролцсон байна. | I-IV | Захиргаа, удирдлагын газар | - |
| 17. | БСТ 1.6<br>Албан хаагчдыг гадаад болон дотоод сургалтад тасралтгүй хамруулж, мэргэшүүлнэ. | 20 сая төгрөг (улсын төсөв) | Сургалтын төлөвлөгөө<br><br>Сургалтад хамрагдсан албан хаагчдын тоо<br><br>Тайлан | БНСУ-д зохион байгуулагдсан 8 төрлийн сургалтад Эм шинжлэх лабораторийн 6 албан хаагчийг ДЭМБ-ын санхүүжилтээр сургасан байна.<br>Албан хаагчдыг чадавхжуулах, мэдлэг | Сургалтын төлөвлөгөөг батлуулж, дотоод сургалтын төлөвлөгөөнд албан хаагчдыг чадавхжуулах, мэдлэг ур чадварыг дээшлүүлэх сургалтыг зохион байгуулсан байна. Өмнөх онуудад төрийн албаны мэргэшүүлэх сургалтад хамрагдсан албан хаагчдын судалгааг гаргаж, төрийн албанд | I-IV | Захиргаа, удирдлагын газар | Бүх газар, хэлтэс |

| д/д | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Төсөв (сая, төгрөг) | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | 2025 онд хүрэх зорилтот түвшин | Хугацаа (I-IV улирал) | Хариуцах нэгж | Хамтран хэрэг жүүлэх газар, хэлтэс |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Зохион байгуулсан сургалтын тоо | ур чадварыг дээшлүүлэх зорилгоор 19 сургалт зохион байгуулсан. Төрийн албаны мэргэшүүлэх сургалтад 21 албан хаагчийг хамруулсан байна. | анх томилогдсон албан хаагч, төрийн албанд шинээр томилогдсон албан хаагчийг мэргэшүүлэх дунд хугацааны сургалт, дунд хугацааны давтан сургалт ахлах түшмэлийн багц сургалт, эрхэлсэн түшмэлийн багц сургалтад тус тус хамруулсан байна. | | | |
| 18. | БСТ 1.6 Эрүүл, аюулгүй орчинд ажиллах нөхцлийг сайжруулна. | 17 сая төгрөг (улсын төсөв) | Хэрэгжүүлсэн арга хэмжээ | - | Албан хаагчдын ажиллах орчин нөхцөл сайжирсан байна. | I-IV | Захиргаа, удирдлагын газар | |
| 19. | Байгууллагын брэндбүүкийг шинээр боловсруулна. | - | Боловсруулсан брэндбүүк | - | Байгууллагын брэндбүүкийг боловсруулсан байна. | I-IV | Захиргаа, удирдлагын газар | Бүх газар, хэлтэс |
| 20. | БСТ 1.6 Дэлхийн эм зүйчдийн өдрийг зохион байгуулна. | 3 сая төгрөг (улсын төсөв) | Зохион байгуулсан арга хэмжээний тайлан | - | Дэлхийн эм зүйчдийн өдрийн хүрээнд төрийн бус байгууллагатай хамтран арга хэмжээ зохион байгуулсан байна | III | Захиргаа, удирдлагын газар | Бүх газар, хэлтэс |
| 21. | БСТ 1.7 Агентлагийн нэрэмжит "Ногоон тогоол"-ийг тохижуулна. | 2.5 сая төгрөг (улсын төсөв) | Хэрэгжүүлсэн арга хэмжээний тоо | БЗД-ийн Хонхор тосгонд 2021 онд мод тарьсан. | Нийгмийн хариуцлагын хүрээнд байгаль орчинд ээлтэй орчин бүрдүүлсэн байна. | II-III | Захиргаа, удирдлагын газар | Бүх, газар, хэлтэс |
| **ТАВ. ЭМ ШИНЖЛЭХ ЛАБОРАТОРИЙН ЧАДАВХИЙГ НЭМЭГДҮҮЛЖ, БҮС НУТГИЙН ОЛОН УЛСЫН ХЯНАЛТЫН ЛАБОРАТОРИЙН СҮЛЖЭЭНД НЭГДЭНЭ.** | | | | | | | | |
| 22. | БСТ 10.1 Лабораторийн байрыг зохистой дадлын шаардлагад нийцүүлэн шинэчлэнэ. | Олон улсын байгууллага | Лабораторийн шинэ байр | ХАБҮЛЛ-ын 1,2 5-р давхар | Лабораторийн байрыг зохистой дадлын шаардлагад нийцүүлэн шинэчилсэн ХӨСҮТ-ийн лабораторийн байранд үйл ажиллагаа эхлүүлсэн байна. | I-IV | Эм шинжлэх лаборатори | ЗУГ |
| 23. | БСТ 10.1 Лабораторийн тоног төхөөрөмжийг шинэчлэх | 1.8 сая доллар | Судалгааны дүн | Нийт 147 багаж тоног төхөөрөмж | Лабораторийн тоног төхөөрөмжийг шинэчлэх | I-IV | Эм шинжлэх лаборатори | ЗУГ |

| д/д | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Төсөв (сая, төгрөг) | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | 2025 онд хүрэх зорилтот түвшин | Хугацаа (I-IV улирал) | Хариуцах нэгж | Хамтран хэрэг жүүлэх газар, хэлтэс |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | судалгаа хийж, урвалж бодисын хангамжийг нэмэгдүүлнэ. | (олон улсын төсөл, хөтөлбөр) | Урвалж, бодисын тоо | шинжилгээнд ашиглах байна. | судалгаа хийж, урвалж бодисын хангамжийг нэмэгдүүлсэн байна. | | | |
| 24. | БСТ 10.1 Лабораторийн зохистой дадлыг нэвтрүүлэх бэлтгэл ажлыг эхлүүлнэ. | 3 сая төгрөг (улсын төсөв) | Хэрэгжүүлсэн үйл ажиллагаа | MNS/ISO IES 17025-2018 стандарт | Лабораторийн зохистой дадлыг нэвтрүүлэх бэлтгэл ажлыг хангаж ажилласан байна. | I-IV | Эм шинжлэх лаборатори | ЗУГ |
| **ЗУРГАА. ЭМИЙН ЗОХИЦУУЛАЛТЫН БАЙГУУЛЛАГЫН ОЛОН УЛСЫН ЖИШИГ ТОГТООХ ҮНЭЛГЭЭГЭЭР ТӨЛӨВШЛИЙН ТҮВШИНГ 3-Т ХҮРНЭ.** | | | | | | | | |
| 25. | БСТ 5 Бүртгэл, сунгалт, өөрчлөлтийн асуудлыг зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн шийдвэрлүүлнэ. | - | Бүртгэсэн, сунгасан, өөрчлөлт оруулсан бүртгэлээс хассан бүтээгдэхүүний тоо | 2024 онд 1063 эм, эмийн түүхий эд, 656 эрүүл мэндийн нэмэлт бүтээгдэхүүн, 463 лабораторийн оношилгооны хэрэгслийн бүртгэлийн асуудлыг шийдвэрлэсэн. | Бүртгэл, сунгалт, өөрчлөлтийн асуудлыг журмын дагуу зохион байгуулж, холбогдох зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн шийдвэрлүүлж, бүртгэлийн гэрчилгээ олгосон байна. | I-IV | Эмийн бүртгэлийн хэлтэс | - |
| 26. | БСТ 7.1 Зах зээл дэх эм, эмнэлгийн хэрэгслийн чанар, аюулгүй байдлын төлөвлөгөөт болон төлөвлөгөөт бус тандалт судалгаа хийнэ. | 15 сая (улсын төсөв) | Төлөвлөгөөт тандалтын тоо<br><br>Төлөвлөгөөт бус тандалтын тоо<br><br>Судалгааны тайлан | Төлөвлөгөөт тандалт-2 Төлөвлөгөөт бус тандалт-7<br><br>2012, 2017 онд тархалтын судалгаа хийсэн. | Зах зээл дэх эм, эмнэлгийн хэрэгслийн чанар, аюулгүй байдлын төлөвлөгөөт болон төлөвлөгөөт бус тандалт судалгаа хийсэн байна. | I-IV | Эмийн аюулгүй байдлын тандалт судалгааны газар | - |
| 27. | БСТ 7.3 Зах зээл дэх хуурамч, стандартын бус эмийн тархалтын судалгаа хийнэ. | 242 сая төгрөг (улсын төсөв) | Удирдамж<br><br>Судалгааны тайлан | 2019 оны судалгаа | Хуурамч, стандартын бус эмийн тархалтын судалгаа хийж, тайланг ЭМЯ-нд хүргүүлсэн байна | II-IV | Эмийн аюулгүй байдлын тандалт судалгааны газар | ЧХГ |

| д/д | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Төсөв (сая, төгрөг) | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | 2025 онд хүрэх зорилтот түвшин | Хугацаа (I-IV улирал) | Хариуцах нэгж | Хамтран хэрэг жүүлэх газар, хэлтэс |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| 28. | БСТ 6.1<br>Эмийн гаж нөлөө, аюулгүй байдлын мэдээллийг бүртгэж үнэлэн, холбогдох салбар зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн, шийдвэрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааг тогтмол хийж гүйцэтгэнэ. | - | ЭССЗ-ийн хурлаар баталгаажуулсан гаж нөлөөний тоо<br>Мэдээлсэн гаж нөлөөний тоо | Гаж нөлөөний тохиолдол 126, эмийн аюулгүй байдлын хугацаат тайлан 358, гадны эм үйлдвэрлэгчийн эмийн гаж нөлөөний 356 мэдээллийг тус тус бүртгэж, ЭССЗ-ийн хурлаар хэлэлцүүлж, үнэлгээг баталгаажуулсан. | Эмийн гаж нөлөө, аюулгүй байдлын мэдээллийг бүртгэж үнэлэн, холбогдох салбар зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн, шийдвэрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааг тогтмол хийж гүйцэтгэсэн байна. | I-IV улирал | Эмийн аюулгүй байдлын тандалт судалгааны газар | - |
| 29. | БСТ 4.2<br>Эм, эмнэлгийн хэрэгсэл үйлдвэрлэх-экспортлох, импортлох-ханган нийлүүлэх тусгай зөвшөөрөл олгох үйл ажиллагааг зохион байгуулна. | - | ТЗОК-ийн хурлын тоо<br><br>Хүсэлт ирүүлсэн байгууллагын тоо<br><br>Шийдвэрлэсэн тусгай зөвшөөрлийн тоо | ТЗОК-ийн 15 удаагийн хурал зохион байгуулж, 241 хүсэлтийг хүлээн авч шийдвэрлүүлсэн. | Тусгай зөвшөөрөл олгох, сунгах, түдгэлзүүлэх, хүчингүй болгох үйл ажиллагааг хуулийн хүрээнд зохион байгуулж, ТЗОК-ийн хурлын хэлэлжүүлж, шийдвэрлүүлсэн байна. | I-IV | Лиценз, зөвшөөрлийн зохицуулалтын газар | ЧХГ |
| 30. | БСТ 4.2<br>Эм, эмнэлгийн хэрэгслийн импорт, экспортын мэдүүлэг олгох үйл ажиллагааг зохион байгуулна. | - | Олгосон мэдүүлгийн тоо | Эм, эмнэлгийн хэрэгсэлд импорт, экспортын мэдүүлэг 8799 олгосон. | Эм, эмнэлгийн хэрэгслийн импорт, экспортын мэдүүлгийг хууль, журмын дагуу хянаж олгосон байна. | I-IV | Лиценз, зөвшөөрлийн зохицуулалтын газар | - |
| 31. | Хандив, тусламжийн эм, эмнэлгийн хэрэгслийн судалгаа хийнэ. | 2 сая (улсын төсөв) | Судалгааны тайлан | - | Хандив, тусламжийн эм, эмнэлгийн хэрэгслийн судалгаа хийж, ЭМЯ-нд хүргүүлсэн байна. | II-IV | Лиценз, зөвшөөрлийн зохицуулалтын газар | - |
| 32. | БСТ 11.1<br>Боомт бүхий аймгуудын эм, эмнэлгийн хэрэгсэл | 10 сая (улсын төсөв) | Үнэлгээний тайлан | 2024 онд 5 аймагт явцын хяналт үнэлгээ хийсэн. | Сэлэнгэ, Дорноговь аймгийн импортлох-ханган нийлүүлэх тусгай зөвшөөрөлтэй | III-IV | Лиценз, зөвшөөрлийн зохицуулал | ЧХГ |

| д/д | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Төсөв (сая, төгрөг) | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | 2025 онд хүрэх зорилтот түвшин | Хугацаа (I-IV улирал) | Хариуцах нэгж | Хамтран хэрэг жүүлэх газар, хэлтэс |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | импортлох-ханган тусгай зөвшөөрөлтэй нийлүүлэх байгууллагын үйл ажиллагаанд хяналт, үнэлгээ хийнэ. | | | | байгууллагууд зөвшөөрлийн нөхцөл, шаардлагыг биелүүлж байгаа эсэхэд хяналт, үнэлгээ хийж, мэргэжил аргазүйн зөвлөгөө өгсөн байна. | | тын газар | |
| 33. | БСТ 11.1<br>Төлөвлөгөөт, төлөвлөгөөт бус, гүйцэтгэлийн хяналт шалгалт хийнэ. | 100 сая төгрөг (улсын төсөв) | Хяналт шалгалтад хамрагдсан байгууллагын тоо<br><br>Арилгасан зөрчлийн хувь | Хяналт шалгалтад нийт 610 байгууллага хамрагдсан. 281 байгууллагад гүйцэтгэлийн хяналт хийж, эрсдэлийн түвшин бууруулсан. Албан шаардлагын хэрэгжилт 63 хувь. | Төлөвлөсөн байгууллагад удирдамжийн дагуу хяналт шалгалт хийж, илэрсэн зөрчил, дутагдлын дагуу арга хэмжээ авч дүнг нэгтгэн, цаашид авах арга хэмжээний санал боловсруулж, холбогдох газарт хүргүүлсэн байна. | I-IV | Чанарын хяналтын газар | - |
| 34. | БСТ 11.1<br>Урьдчилан сэргийлэх хяналт шалгалт хийнэ. | 45 сая төгрөг (улсын төсөв) | Хяналт шалгалтад хамрагдсан байгууллагын тоо<br><br>Арилгасан зөрчлийн тоо | 481 байгууллага, иргэний үйл ажиллагаанд хяналт хийж, 29.3 сая төгрөгийн торгууль тавьж, 315 нэрийн зөрчилтэй бүтээгдэхүүнийг илрүүлсэн. | Чанарын шаардлага хангахгүй, улсын бүртгэлд бүртгэгдээгүй эм, эмнэлгийн хэрэгсэл, эрүүл мэндийн нэмэлт бүтээгдэхүүнийг илрүүлэх хяналтыг 200-аас багагүй байгууллага, иргэнийг хамруулж, хийж зөрчлийг арилгуулсан байна. | I-IV | Чанарын хяналтын газар | - |
| 35. | БСТ 11.1<br>Хяналт шалгалтын журманд нэмэлт өөрчлөлт оруулах санал хүргүүлж, хяналтын хуудсыг шинэчлэн батлуулна. | - | Хүргүүлсэн саналын тоо<br><br>Батлагдсан хяналтын хуудас | Хяналт шалгалтад ашиглагдах хяналтын хуудсыг шинэчлэн 2025 оны А/29 дүгээр тушаалаар батлуулсан. | Хяналт шалгалтын журманд эм, эмнэлгийн хэрэгслийн хяналтын улсын байцаагчийн хяналт шалгалттай холбогдох заалтууд тусгаж, хяналт шалгалтын үйл ажиллагаанд ашиглах 4 төрлийн хяналтын хуудсыг шинэчлэн батлуулсан байна. | I-II | Чанарын хяналтын газар | - |
| 36. | БСТ 10.3, 11.1<br>Эм үйлдвэрлэлийн зохистой дадлын шалгуурыг олон улсын | - | Батлагдсан журам | ЭЭХХЗГ-ын даргын 2021 оны 168-р тушаал | Эм үйлдвэрлэлийн зохистой дадлын шалгуурыг олон улсын удирдамжид нийцүүлэн шинэчилж, батламжийн | II-IV | Эмийн үйлдвэрлэлийн хэлтэс | - |

| д/д | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Төсөв (сая, төгрөг) | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | 2025 онд хүрэх зорилтот түвшин | Хугацаа (I-IV улирал) | Хариуцах нэгж | Хамтран хэрэг жүүлэх газар, хэлтэс |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | удирдамжид нийцүүлэн шинэчилнэ. | | | | загварыг ДЭМБ-ын жишигт нийцүүлэн өөрчилж, журмыг шинэчилэн батлуулсан байна. | | | |
| 37. | БСТ 10.3<br>Дотоодын эмнэлгийн хэрэгслийн үйлдвэрлэлийн дэмжинэ. | 10 сая төгрөг (улсын төсөв) | Хэрэгжүүлсэн арга хэмжээ | - | Эмнэлгийн хэрэгсэл, чанарын удирдлагын тогтолцоо, зохицуулалтын чиглэлээр тавих шаардлага MNS ISO 13485 2021-ын баталгаажуулалтыг судлаж, шийдвэрлүүлсэн байна. | III-IV | Эмийн үйлдвэрлэлийн хэлтэс | - |
| 38. | БСТ 9<br>Эм үйлдвэрлэлийн зохистой дадлын батламж олгох, сунгах үйл ажиллагаар журмын дагуу зохион байгуулна. | - | Батламж авсан үйлдвэрийн тоо | GMP-ын шаардлага хангасан үйлдвэр-9 | Эм зүйн салбар зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж, батламж шинээр олгох, хугацаа сунгах үйл ажиллагаар зохион байгуулж шаардлага хангасан үйлдвэрүүдэд батламж олгосон байна | I-IV | Эмийн үйлдвэрлэлийн хэлтэс | - |
| 39. | БСТ 10.3<br>Фармакопейн хороо, Хүний эмийн зөвлөлийн эм зүйн салбар зөвлөлийн хурлыг зохион байгуулна . | - | Фармакопейн хорооны хурлын тоо<br>Эмзүйн салбар зөвлөлийн хурлын тоо<br>Батлагдсан фармакопейн өгүүлэлийн тоо | Үйлдвэрлэгчийн 11 фармакопейн өгүүлэл батлагдсан. Эмзүйн салбар зөвлөлийн хурлаар 13 үйлдвэрлэгчийн фармакопейн өгүүлэл хэлэлцүүлж шийдвэрлэсэн. | Фармакопейн хорооны хурлаар үйлдвэрлэгчийн фармакопейн өгүүлэл хэлэлцүүлж, батлуулсан байна<br>Эмзүйн салбар зөвлөлийн үйл ажиллагаар журмын дагуу зохион байгуулж, хурлаар үйлдвэрлэгчийн хэлэлцүүлэх асуудлыг хэлэлцүүлсэн байна. | I-IV | Эмийн үйлдвэрлэлийн хэлтэс | - |
| **ДОЛОО. ЭМИЙН ҮНИЙН ИЛ ТОД БАЙДЛЫГ ХАНГАЖ, ЭМ, ЭМНЭЛГИЙН ХЭРЭГСЛИЙН ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААНЫ ҮР АШГИЙГ САЙЖРУУЛАХ ЗАМААР ЗАЙЛШГҮЙ ШААРДЛАГАТАЙ ЭМИЙН ХҮРТЭЭМЖИЙГ НЭМЭГДҮҮЛЖ, ЭМИЙН ЗОХИСТОЙ ХЭРЭГЛЭЭГ ТӨЛӨВШҮҮЛНЭ.** | | | | | | | | |
| 40. | Эм, эмнэлгийн хэрэгслийн нөөц, тасалдлын мэдээ гаргаж, импорт, экспорт, борлуулалтын тайланд дүн шинжилгээ хийнэ. | - | Хүргүүлсэн мэдээллийн тоо<br><br>Дүн шинжилгээний тайлан | Эм, эмнэлгийн хэрэгслийн улсын нөөц, тасалдлын мэдээг сар тутамд, импортын тайланг жилд 1 удаа гаргасан. | Эм, эмнэлгийн хэрэгслийн улсын нөөц, тасалдлын мэдээллийг тогтмол хугацаанд гаргаж, дүн шинжилгээ хийж, холбогдох байгууллагад хүргүүлсэн байна. | I-IV | Эм хангамжийн газар | ЛЗЗГ ЭҮХ |

| д/д | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Төсөв (сая, төгрөг) | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | 2025 онд хүрэх зорилтот түвшин | Хугацаа (I-IV улирал) | Хариуцах нэгж | Хамтран хэрэг жүүлэх газар, хэлтэс |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| 41. | БСТ 2.1<br>Ерөнхий гэрээгээр худалдан авах эм, эмнэлгийн хэрэгслийн нэр төрлийг нэмэгдүүлнэ. | - | Цахим дэлгүүрт нэмэгдсэн эм, эмнэлгийн хэрэгслийн нэр төрлийн тоо | 2024 онд ерөнхий гэрээгээр худалдан авах эм, эмнэлгийн хэрэгслийн нэмэгдүүлсэн нэр төрлийн тоо - 13 | Ерөнхий гэрээгээр худалдан авах эм, эмнэлгийн хэрэгслийн нэр төрлийг 25 ≤ нэмэгдүүлнэ. | III-IV | Эм хангамжийн газар | |
| 42. | БСТ 7.1, 11.1<br>Эрт илрүүлэгт шаардагдах лабораторийн урвалж бодис, оношлуур, эмнэлгийн хэрэгслийн нөөц, чанар аюулгүй байдалд тандалт хийж, хяналт тавин ажиллана. | - | Нөөцийн тайлангийн тоо<br><br>Тандалтын тоо<br><br>Чанарын хяналтын тоо | 2024 оны нөөцийн тайлангийн тоо-36 | Эрт илрүүлэгт шаардагдах лабораторийн урвалж бодис, оношлуур, эмнэлгийн хэрэгслийн нөөц, чанар аюулгүй байдалд тандалт хийж, хяналт тавин ажилласан байна. | II-IV | Эм хангамжийн газар | ЭАБТСГ, ЧХГ |
| 43. | Зайлшгүй шаардлагатай эм, эмнэлгийн хэрэгслийг нотолгоонд суурилан сонгож, жагсаалтыг боловсруулж санал хүргүүлнэ. | - | Шинэчилсэн жагсаалт | Зайлшгүй шаардлагатай эмийн X, хүүхдийн зайлшгүй шаардлагатай эмийн III жагсаалт ЭМС-2023 оны А/197 дугаар тушаалаар батлагдсан. | Зайлшгүй шаардлагатай эмийн XI, хүүхдийн зайлшгүй шаардлагатай эмийн IV жагсаалтыг шинэчлэн боловсруулж, ЭМЯ-нд хүргүүлсэн байна. | II-IV | Эмийн аюулгүй байдлын тандалт судалгааны газар<br>Эмнэлгийн тоног төхөөрөмжийн газар | ЭХГ |
| 44. | БСТ 9<br>Эмийн зохистой хэрэглээг төлөвшүүлэх чиглэлээр үйл ажиллагаа зохион байгуулж, эмийн цахим жор бичилт, олголтыг нэмэгдүүлнэ. | 10 сая төгрөг (улсын төсөв) | Сургалтын тоо<br><br>Нөлөөллийн үйл ажиллагааны тоо<br><br>Цахим жороор олгосон эмийн тоо | Нийгмийн эрүүл мэндийг дэмжих-2024 өдөрлөг, Эмийн зохистой хэрэглээний аян зохион байгуулсан. | "Эмийн зохистой хэрэглээ"-ний аян зохион байгуулж, эмийн жор бичилт, олголтой холбоотой мэдээлэл өгч эмийн жорыг цахимаар хянах нөхцөлийг бүрдүүлж, сургалт нөлөөллийн үйл ажиллагааг тогтмол зохион байгуулсан байна. | I-IV | Эмийн аюулгүй байдлын тандалт судалгааны газар | ЧХГ<br>ЗУГ<br>ЭБХ |
| 45. | БСТ 9<br>Бичил биетний тэсвэржилтээс сэргийлэх | - | Тайлан | Бичил биетний тэсвэржилтээс сэргийлэх салбар | Бичил биетний тэсвэржилтээс сэргийлэх салбар дундын үйл ажиллагааны 2022-2025 оны | IV | Эмийн аюулгүй байдлын | ЧХГ<br>ЗУГ<br>ЭҮХ |

| д/д | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Төсөв (сая, төгрөг) | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | 2025 онд хүрэх зорилтот түвшин | Хугацаа (I-IV улирал) | Хариуцах нэгж | Хамтран хэрэг жүүлэх газар, хэлтэс |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | салбар дундын үйл ажиллагааны тайлан гаргаж, 2026-2029 оны төлөвлөгөөний төслийг боловсруулна. | | Төлөвлөгөөний төсөл | дундын үйл ажиллагааны 2022-2025 оны төлөвлөгөө | төлөвлөгөөний тайлан гаргаж, 2026-2029 оны төлөвлөгөөний төсөл боловсруулсан байна. | | тандалт судалгааны газар | ЭБХ ЭХГ |
| 46. | БСТ 8.1 Эмийн зар сурталчилгааны энгийн зөвшөөрөл олгох үйл ажиллагааг зохион байгуулна. | - | Зар сурталчилгааны тоо | 142 нэрийн эм, эрүүл мэндийн нэмэлт бүтээгдэхүүний зар сурталчилгааны зөвшөөрөл олгогдсон. | Эмийн зар сурталчилгааны агуулгыг хянаж, энгийн зөвшөөрөл олгох үйл ажиллагааг салбар зөвлөлөөр хэлэлцүүлж, шийдвэрлүүлсэн байна | I-IV | Эмийн аюулгүй байдлын тандалт судалгааны газар | - |
| **ДОЛОО. ЭМНЭЛГИЙН ТОНОГ ТӨХӨӨРӨМЖИЙН АШИГЛАЛТ, АЮУЛГҮЙ БАЙДЛЫГ ХАНГАНА.** | | | | | | | | |
| 47. | БСТ 3.1 Эрүүл мэндийн байгууллагад ашиглагдаж байгаа эмнэлгийн тоног төхөөрөмжид шалгалт тохируулга хийнэ. | 93 сая төгрөг (улсын төсөв) | Шалгалт тохируулга хийсэн тоног төхөөрөмжийн тоо | Шалгалт тохируулга хийсэн тоног төхөөрөмж-2435 | Төрийн болон хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагын 2400-аас дээш эмнэлгийн тоног төхөөрөмжид шалгалт тохируулгад хийж, хэвийн найдвартай ажиллагаа хангагдсан байна. | I-IV | Эмнэлгийн тоног төхөөрөмжийн газар | - |
| 48. | БСТ 3.2 Эмнэлгийн тоног төхөөрөмжийн мэдээллийн сангийн тайланг боловсруулна. | - | Тайлан | Тайлан | Эмнэлгийн тоног төхөөрөмжийн мэдээллийн сангийн тайланг боловсруулж, ЭМЯ-нд хүргүүлж, шийдвэр гаргагчдыг мэдээллээр хангасан байна. | IV | Эмнэлгийн тоног төхөөрөмжийн газар | - |

Жич: Байгууллагын чиг үүргийн дагуу хуулийн хүрээнд дараах бодлогын баримт бичгүүд гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсан болно. Үүнд:

- Монгол Улсыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл
- Монгол Улсын Засгийн газрын 2025-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө
- Байгууллагын хөгжлийн төлөвлөгөө (2023-2026)

2025 оны байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөнд нийт 48 ажил төлөвлөсөн. Үүнд:

- Шинээр төлөвлөсөн 15 арга хэмжээ
- 2024 оны хагас биелэлттэй 3 ажил
- Тогтмол зохион байгуулдаг 30 ажил багтсан байгаа болно.

БАТЛАВ.
ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ Д.АЛТАНЦЭЦЭГ

# ЭМ, ЭМНЭЛГИЙН ХЭРЭГСЛИЙН ХЯНАЛТ, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН "ТӨРИЙН АЛБАН ХААГЧИЙН АЖИЛЛАХ НӨХЦӨЛ, НИЙГМИЙН БАТАЛГААНЫ ХӨТӨЛБӨР"-ИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ 2025 ОНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ

| Д/д | Хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин /2024/ | Хүрэх түвшин /2025/ | Хэрэгжүүлэх хугацаа |
|---|---|---|---|---|---|
| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 |
| **Нэг. Цалин хөлс, нэмэгдэл, шагнал урамшуулал, тэтгэвэр тэтгэмж, тусламж дэмжлэгийг хуулийн хүрээнд үзүүлэх зорилтын хүрээнд:** | | | | | |
| 1.1 | Төрийн албан хаагчдын цалингийн сүлжээг шинэчлэн тогтоох тухай УИХ, Засгийн газраас баталсан шийдвэрийг хэрэгжүүлэх; | Хамрагдсан албан хаагчдын тоо | 110 албан хаагч | 110 албан хаагч | I-IV |
| 1.2 | Албан хаагчдын сар бүрийн цалин, нэмэгдэл, урамшууллын талаарх мэдээллийг сар бүр цахим хэлбэрээр албан хаагчдад хүргэх; | Хамрагдсан албан хаагчдын тоо | Албан хаагчдад 12 удаа | Албан хаагчдад 12 удаа | I-IV |
| 1.3 | Төрийн захиргаа, үйлчилгээний албан хаагчдын төрийн алба хаасан хугацааны нэмэгдэл олгох, төрийн захиргааны албан хаагчдад албан тушаалын зэрэг дэв олгох, ахиулан олгохыг шийдвэрлүүлэх; | Хамрагдсан албан хаагчдын тоо | Тухай бүр шийдвэрлэх | Тухай бүр шийдвэрлэх | I-IV |
| 1.4 | Албан хаагчдын хоол унааны зардлыг сар бүр олгох; | Нэмэгдсэн түвшин | 20,000/мянга/ | 20,000/мянга/ | I-IV |
| 1.5 | Албан хаагчдын ажлын үр дүн, гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийг үнэлсэн үнэлгээг үндэслэн улирлын болон жилийн эцсийн урамшуулал олгох асуудлыг шийдвэрлэх; | Олгосон урамшууллын тоо /сая төг/ | 263,783,719 | Урамшуулал олгосон байна. | II, IV |
| 1.6 | Тэмдэглэлт өдрүүдийг тохиолдуулан ажилдаа амжилт гарган ажиллаж байгаа албан хаагчдыг төрийн дээд одон, медаль, салбарын болон бусад байгууллагын шагналаар шагнах асуудлыг судлан шийдвэрлүүлэх; | Шагнагдсан албан хаагчдын тоо | 2 албан хаагч | 5-аас дээш | III-IV |
| 1.7 | Жилийн эцсийн ажлын үзүүлэлтийг үндэслэн идэвх санаачилгатай, үр бүтээлтэй ажилласан албан хаагчдыг салбарын сайдын нэрэмжит шагналд тодорхойлох; | Шагнагдсан албан хаагчдын тоо | 7 албан хаагч шагнал авсан | 5-аас дээш | IV |
| 1.8 | Орон нутгийн нэмэгдэл, Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласны тэтгэмж /5 жил тутам/ олгох; | Албан хаагчдын тоо | 15 албан хаагч 131,551,200 | 3 албан хаагч | I-IV |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | | төгрөг | | |
| 1.9 | Тэтгэвэрт гарсан албан хаагчдад олгох тэтгэмжийг олгох; | Албан хаагчдын тоо | 1 албан хаагч 31,389,389 төгрөг | 3 албан хаагч | I-IV |
| Хоёр. Албан хаагчдын орон сууцны хангамжийг нэмэгдүүлэхэд дэмжлэг үзүүлэх зорилтын хүрээнд: | | | | | |
| 2.1 | Орон сууцаар хангагдах, нөхцөлөөр сайжруулах талаар гаргасан албан хаагчийн өргөдөл хүсэлтийг бүртгэж, ил тод нээлттэй, шударгаар шийдвэрлэх нөхцөлийг бүрдүүлэх; | Хамрагдсан албан хаагчдын тоо | Тухай бүр судалж шийдвэрлэх | Тухай бүр судалж шийдвэрлэх | I-IV |
| 2.2 | Албан хаагчдыг орон сууцны болон бусад зээл авахад шаардлагатай тодорхойлолт, мэдээллийг гаргаж өгөх; | Хамрагдсан албан хаагчдын тоо | Тухай бүр судалж шийдвэрлэх | Тухай бүр судалж шийдвэрлэх | I-IV |
| Гурав. Ажиллах нөхцөлийг сайжруулах үндсэн зорилтын хүрээнд | | | | | |
| 3.1 | Албан үүргээ гүйцэтгэхэд шаардлагатай тоног төхөөрөмж, эд хогшил, техник хэрэгслийн хэрэгцээг судлан тогтоож, шаардагдах хөрөнгийг жил бүрийн төсөвт тусгах замаар шийдвэрлэх; | Батлагдсан төсөв | 273,397,300 төгрөгийн тоног төхөөрөмж худалдан авалт хийсэн | Тоног төхөөрөмж худалдан авалт хийх | I-IV |
| 3.2 | Ажиллах орчин нөхцөлийг сайжруулах зорилгоор ажлын байранд засвар үйлчилгээг хийх; | Батлагдсан төсөв | Засвар хийгдсэн | Засвар хийгдсэн байна | I-IV |
| Дөрөв. Албан хаагчдын сурч, хөгжих боломжийг бүрдүүлж, дэмжлэг үзүүлэх зорилтын хүрээнд: | | | | | |
| 4.1 | 2025 оны дотоод сургалтын төлөвлөгөөг баталж, хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах; | Батлагдсан төлөвлөгөө | Төлөвлөгөөний дагуу сургалтын үйл ажиллагааг зохион байгуулсан. | Сургалтын төлөвлөгөөг баталж, хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах | I-IV |
| 4.2 | Засгийн газрын захиалгын дагуу Удирдлагын академид зохион байгуулагдах богино хугацааны сургалтуудыг хамтран зохион байгуулж, сургалтад нэгжийн удирдлага, мэргэжилтнүүдийг хамруулах; | Хамрагдсан албан хаагчдын тоо | 10 албан хаагч сургасан. | Албан хаагчдыг квотын дагуу сургах | I-IV |
| 4.3 | Авлигатай тэмцэх газраас зохион байгуулагдах богино хугацааны сургалтуудыг хамтран зохион байгуулж, сургалтад газар, хэлтсийн дарга, мэргэжилтнүүдийг хамруулах; | Хамрагдсан албан хаагчдын тоо | 110 албан хаагч танхим, цахим хэлбэрээр хамрагдсан. | Албан хаагчдыг сургалтад хөтөлбөрийн дагуу сургах | I-IV |
| 4.4 | Төрийн албан хаагчийн мэргэшүүлэх сургалтад газар, хэлтсийн дарга, мэргэжилтнүүдийг хамруулах; | Хамрагдсан албан хаагчдын тоо | 11 албан хаагч хамрагдсан. | Албан хаагчдыг сургалтад хөтөлбөрийн дагуу хамруулах | I-IV |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 4.5 | Албан хаагчдыг байгууллагын болон зохион байгуулагч талын зардлаар гадаад сургалтад хамруулах /цахим, танхим/; | Хамрагдсан албан хаагчдын тоо | 20 албан хаагчийг байгууллагын болон зохион байгуулагч талын зардлаар сургасан. | Албан хаагчийг сургаж, батламж олгох | I-IV |
| Тав. Албан хаагчдын эрүүл мэндийг хамгаалж, эрүүл амьдрах дадлыг хэвшүүлэх зорилтын хүрээнд: | | | | | |
| 5.1 | Эрүүл мэндийн яам болон бусад байгууллагаас уламжлал болгон зохион байгуулагддаг 5 төрөлт спортын тэмцээнд ЭЭХХЗГ-ын шигшээ баг бүрдүүлж, бэлтгэл хангаж оролцуулах; | Зохион байгуулагдсан уралдаан, тэмцээн | 1-ээс дээш | 1-ээс дээш | I-IV |
| 5.2 | Албан хаагчдад ажлын байран дахь дасгал, хөдөлгөөнийг хэвшүүлэх үүднээс клуб, дугуйлан ажлын байранд явуулах, дэмжих; | Хамрагдсан албан хаагчдын тоо | - | Албан хаагчид клуб, дугуйланд хамрагдах | I-IV |
| Зургаа. Төрийн албан хаагчийн нийгмийн хэрэгцээ, сэтгэл зүйн хандлагыг мэдэрч, байгууллагын соёл, хамт олны уур амьсгалыг өөрчлөх замаар албан хаагчдын ажлын байран дээрх сэтгэл ханамжийг сайжруулах зорилтын хүрээнд: | | | | | |
| 6.1 | Байгууллагын соёл, зохион байгуулалт, хүний нөөцтэй холбоотой асуудлаар сэтгэл ханамжийн судалгааг албан хаагчдаас жил бүр авч, үнэлэлт, дүгнэлт хийж ажиллах; | Хамрагдсан албан хаагчдын тоо | 50-ээс дээш | 90-ээс дээш | IV |
| 6.2 | Эх үрсийн баяр, Салбарын тэмдэглэлт өдөр, Шинэ жил, Олон улсын эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах өдөр, Ахмадын баярыг тэмдэглэн өнгөрүүлэхэд зардлын тодорхой хувийг хууль тогтоомжийн дагуу шийдвэрлэх; | Хамрагдсан албан хаагчдын тоо | Төсөвт багтаан тухай бүр шийдвэрлэсэн. | Шийдвэрлэсэн байна. | I-IV |

БАТЛАВ
ЭМ, ЭМНЭЛГИЙН ХЭРЭГСЛИЙН ХЯНАЛТ,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ДАРГЫН АЛБАН
ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

П.АЛТАНЦЭЦЭГ

## ЭМ, ЭМНЭЛГИЙН ХЭРЭГСЛИЙН ХЯНАЛТ, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН 2025 ОНЫ СУРГАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

2025.01.15 Улаанбаатар хот

| Д/д | № | Сургалтын нэр | Сургалт зохион байгуулах хугацаа | Хариуцах газар нэгж /албан хаагч/ | Сургалтын хэлбэр /танхим, цахим/ | Хамрагдах албан хаагч | Оролцогчдын тоо |
|---|---|---|---|---|---|---|---|
| НЭГДҮГЭЭР УЛИРАЛД ЗОХИОН БАЙГУУЛАГДАХ СУРГАЛТ | | | | | | | |
| 1 | 1 | Төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээ /гадны сургалтын байгууллагатай хамтрах/ | 1-3 сар | Захиргаа, удирдлагын газар | Танхим, цахим | Нийт албан хаагчид | 132 |
| 2 | 2 | Төрийн албан хаагчийг мэргэшүүлэх багц сургалтууд | 1-3 сар | Захиргаа, удирдлагын газар | Танхим, цахим | Төрийн захиргааны албан хаагчид | 5-аас дээш |
| 3 | 3 | Төрийн албан хаагчийг мэргэшүүлэх багц сургалтууд | 1-3 сар | Захиргаа, удирдлагын газар | Танхим | Төрийн захиргааны албан хаагчид | 2 |
| 4 | 4 | Чанарын удирдлагын тогтолцоо | 1-3 сар | Мэргэшсэн сургалтын байгууллага | Танхим, цахим | Нийт албан хаагчдад | 132 |
| 5 | 5 | Хүний эрх-Жендерийн эрх тэгш байдлын хууль таниулах сургалт | 1-3 сар | Эрүүл мэндийн яам жендерийн хороо | Танхим, цахим | Удирдах албан хаагчид | 9 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 6 | 6 | Лабораторийн итгэмжлэлд тавигдах шаардлага ISO/IEC 17025: Ур чадварын сорилтод тавих ерөнхий шаардлага ISO/IEC 17043 /Модуль-1/ /Модуль-2/ | 1-3 сар | Эмнэлгийн тоног төхөөрөмжийн газар | Танхим | ЭТТГ-ын мэргэжилтнүүд | 5 |
| 7 | | | 4-6 сар | | | | 5 |
| 8 | 7 | Нийгмийн сүлжээ маркетинг хөгжүүлэлт, контент үйлдвэрлэлийн сургалт | 1-3 сар | Захиргаа, удирдлагын газар | Танхим, цахим | Сургалт, олон нийт хэвлэл мэдээллийн ажилтан | 1 |
| 9 | 8 | Авлига ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх сургалт | 1-3 сар | Авлигатай тэмцэх газар | Танхим, цахим | Нийт албан хаагчид | 132 |
| 10 | 9 | Архивын албан хэрэг хөтлөлтийн мэргэшүүлэх сургалт | 1-3 сар | Захиргаа удирдлагын газар | Танхим | Архивын эрхлэгч | 1 |
| 11 | 10 | ISO19011:2020 дотоод аудитор эрх олгох сургалт | 1-3 сар | Захиргаа удирдлагын газар | Танхим | Дотоод аудит | 1 |
| **ХОЁРДУГААР УЛИРАЛД ЗОХИОН БАЙГУУЛАГДАХ СУРГАЛТ** | | | | | | | |
| 12 | 1 | Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт шалгалтын эрх зүй, анхаарах асуудал | 4-6 сар | Чанарын хяналтын газар | Танхим | Аймаг, нийслэлийн улсын /ахлах/ байцаагчид | 32 |
| 13 | 2 | Авлига ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх сургалт | 4-6 сар | Захиргаа, удирдлагын газар | Танхим, цахим | Нийт албан хаагчид | 132 |
| 14 | 3 | СЭЗИС-ийн Power BI, MS Excel программын сургалт | 4-6 сар | Эм хангамжийн газар | Танхим | ЭХГ-ын мэргэжилтнүүд | 6 |
| 15 | 4 | Итгэлцлийн зохистой дадал буюу Good Reliance Practice | 4-6 сар | Захиргаа, удирдлагын газар | Танхим | Нийт албан хаагчид | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | Эмийн аюулгүй байдлын тандалт, судалгааны газар | | | |
| 16 | 5 | Global benchmarking tool<br>ОУ-ын жишиг тогтоох хэрэгсэл | 4-6 сар | Захиргаа, удирдлагын газар<br>Эмийн аюулгүй байдлын тандалт, судалгааны газар | Танхим цахим | Нийт албан хаагчид | 132 |
| 17 | 6 | Зохицуулалтын зохистой дадал буюу Good Regulatory Practice | 4-6 сар | Захиргаа, удирдлагын газар<br>Эмийн аюулгүй байдлын тандалт, судалгааны газар | Танхим | Нийт албан хаагчид | 100 |
| 18 | 7 | Статистикийн мэдээллийн нэгдсэн сангаас 2025 онд зохион байгуулах сургалт | 4-6 сар | Статистикийн мэдээллийн нэгдсэн сан | Танхим, цахим | ЗУГ-ын мэргэжилтэн | 1 |
| 19 | 8 | ISO9001:2016 дотоод аудиторын сургалт | 1-3 сар | Захиргаа, удирдлагын газар | Танхим, цахим | ЗУГ-ын мэргэжилтэн | 1 |
| 20 | 9 | Хүний эрх-Жендерийн эрх тэгш байдлын хууль таниулах сургалт | 4-6 сар | Эрүүл мэндийн яамны жендерийн хороо | Танхим | Гүйцэтгэх албан хаагчид | 80 |
| 21 | 10 | MNS ISO 17043 : 2010<br>Тохирлын үнэлгээ Ур чадварын сорилтод тавих ерөнхий шаардлага | - | Үндэсний итгэмжлэлийн төв<br>Эм шинжлэх лаборатори | Танхим | Эм шинжлэх лаборатори | 2 |
| 22 | 11 | MNS ISO/IEC 9001;2015<br>Тохирлын үнэлгээ - Менежментийн тогтолцооны аудит, баталгаажуулалт гүйцэтгэдэг байгууллагад тавих шаардлага | - | Үндэсний итгэмжлэлийн төв<br>Эм шинжлэх лаборатори | Танхим | | 3 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 23 | 12 | ***MNS ISO/IEC 17025 : 2018*** Сорилтын болон шалгалт тохируулгын лабораторийн чадавхид тавих ерөнхий шаардлага | - | Үндэсний итгэмжлэлийн төв Эм шинжлэх лаборатори | Танхим | | 5 |
| ГУРАВДУГААР УЛИРАЛД ЗОХИОН БАЙГУУЛАГДАХ СУРГАЛТ | | | | | | | |
| 24 | 1 | Авлига ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх сургалт | 7-9 сар | Захиргаа, удирдлагын газар | Танхим, цахим | Нийт албан хаагчид | 132 |
| ДӨРӨВДҮГЭЭР УЛИРАЛД ЗОХИОН БАЙГУУЛАГДАХ СУРГАЛТ | | | | | | | |
| 25 | 1 | Төрийн албан хаагчийг мэргэшүүлэх багц сургалтууд | 9-12 сар | Захиргаа, удирдлагын газар | Танхим, цахим | Төрийн захиргааны албан хаагчид | 5-аас дээш |
| 26 | 2 | Төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээ /гадны сургалтын байгууллагатай хамтрах/ | 9-12 сар | Захиргаа, удирдлагын газар | Танхим, цахим | Нийт албан хаагчид | 132 |
| 27 | 3 | Монгол улсын шинжлэх ухааны академи Технологийн инкубаторын "Микробиологийн шинжээчдийн чадавхийг дээшлүүлэх танхимийн сургалт. | - | Монгол улсын шинжлэх ухааны академи Технологийн инкубатор | Танхим | Эм шинжлэх лаборатори | 5 |
| 28 | 4 | АШУҮИС-Био-Анагаахын хүрээлэнгийн "Лабораторийн амьтан судлал, шинжлэх ухааны хэрэглээ" сургалт | - | АШУҮИС-Био-Анагаахын хүрээлэн | Танхим | | 4 |
| 29 | 5 | "Agilent Demo Center"-с зохион байгуулагддаг "Хийн хроматографи" багажны сургалт | - | Демо лаборатори | Танхим | | 1 |
| 30 | 6 | PCR арга зүй эзэмшүүлэх | - | МУИС-н хэрэглээний шинжлэх ухаан, инженерчлэлийн сургууль | Танхим | | 1 |
| | | | | | | | |

| | I-IV ДҮГЭЭР УЛИРАЛД ЭРҮҮЛ МЭНДИЙН САЛБАРЫН МЭРГЭЖИЛТНҮҮДЭД ЗОХИОН БАЙГУУЛАГДАХ СУРГАЛТ | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | № | Сургалтын нэр | Сургалт зохион байгуулах хугацаа | Хариуцах газар нэгж /албан хаагч/ | Сургалтын хэлбэр /танхим, цахим/ | Хамрагдах албан хаагч | Оролцогчдын тоо |
| 31 | 1 | Хэвлэл мэдээллийн байгууллагуудад байгууллагын үйл ажиллагааг танилцуулах сургалт | 1-3 сар | Захиргаа, удирдлагын газар | Танхим | Хэвлэл мэдээллийн байгууллагын удирдлага, мэдээний сэтгүүлчид | 50-80 |
| 32 | 2 | 2025 оны хяналт шалгалтын чиглэл, хяналт шалгалтын үйл ажиллагаанд ашиглагдах хяналтын хуудасны хэлэлцүүлэг | 1-3 сар | Чанарын хяналтын газар | Танхим | Аймаг, нийслэлийн улсын /ахлах/ байцаагчид | 32 |
| 33 | 3 | Эмнэлгийн тоног төхөөрөмжийн инженер, техникийн ажилтан нарт зориулсан "Эмнэлгийн тоног төхөөрөмжийн засвар үйлчилгээ" сэдэвт сургалт | 1-9 сар | Эмнэлгийн тоног төхөөрөмжийн газар | Танхим, цахим | Эрүүл мэндийн байгууллагын ЭТТ-ийн инженер техникч нарт | 24 |
| 34 | 4 | Эм, эмнэлгийн хэрэгсэлд импорт, экспортын мэдүүлэг олгох журмын танилцуулах сургалт | 3-11 сар | Лиценз, зөвшөөрлийн зохицуулалтын газар | Танхим цахим | ЭХНБ-ууд | 500 |
| 35 | 5 | Орон нутгийн тусгай зөвшөөрөл олгох комисс болон орон тооны бус шинжээч нарт сургалт | 3-11 сар | Лиценз, зөвшөөрлийн зохицуулалтын газар | Танхим цахим | Орон нутгийн ТЗОК олгох комисс болон шинжээч нар | 150 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 36 | 6 | Цахим системийн хэрэглээний талаар эм ханган нийлүүлэх байгууллагуудад сургалт зохион байгуулна. | 3-11 сар | Захиргаа, удирдлагын газар<br>Лиценз, зөвшөөрлийн зохицуулалтын газар | Танхим цахим | ЭЭХХЗГ-ын мэргэжилтнүүд болон ААНБ-ууд | 500 |
| 37 | 7 | Эмийн бүртгэлийн шинжээчид зориулсан сургалт | 4-6 сар | ЭБХ-ийн ахлах мэргэжилтэн Д.Өлзийдулам | Танхим | ЭЭХХЗГ-тай гэрээтэй Эм, оношлуур, БИБ-ийн бүртгэлийн шинжээч нар | 36 |
| 38 | 8 | Эм бүртгүүлэгч байгууллагуудад зориулсан сургалт | 4-6 сар | ЭБХ-ийн ахлах мэргэжилтэн Д.Өлзийдулам | Танхим | Байгууллагуудын Эм, оношлуур, БИБ-ийн бүртгэл хариуцсан мэргэжилтэн | 100 |
| 39 | 9 | Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт шалгалтын эрх зүй, анхаарах асуудал | 4-6 сар | Чанарын хяналтын газар | Танхим | Аймаг, нийслэлийн улсын /ахлах/ байцаагчид | 32 |
| 40 | 10 | Цахим мэдээллийн нэгдсэн тогтолцооны талаарх мэдээлэл өгөх сургалт | 4-9 сар | Эм хангамжийн газар | Танхим | ЭМБ, ЭЭХХангамжийн байгууллагын мэргэжилтэн, албан хаагчид | 150 |
| 41 | 11 | Эмнэлгийн тоног төхөөрөмжийн хөрөнгийн төлөвлөлтийн программын ашиглалтын сургалт | 4-9 сар | Эмнэлгийн тоног төхөөрөмжийн газар | Танхим, цахим | Эрүүл мэндийн байгууллагын ЭТТ-ийн инженер техникч нарт | 24 |
| 42 | 12 | Худалдан авах ажиллагааны талаарх мэдээлэл өгөх сургалт | 7-9 сар | Эм хангамжийн газар | Танхим | Нийслэл, орон нутгийн эрүүл мэндийн байгууллагын эм зүйч нар | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 43 | 13 | Эмийн зохистой хэрэглээг төлөвшүүлэх 10 хоногийн аяны хүрээнд ерөнхий боловсролын сурагчидад | 9 сар | ЭАБТСГ-ын мэргэжилтэн У.Соёл-Эрдэнэ | Танхим | Ерөнхий боловсролын сурагчид | 50 |
| 44 | 14 | Эмийн зохистой хэрэглээг төлөвшүүлэх 10 хоногийн аяны хүрээнд сургуулийн өмнөх насны хүүхдүүд | 9 сар | ЭАБТСГ-ын мэргэжилтэн У.Соёл-Эрдэнэ | Танхим | Сургуулийн өмнөх насны хүүхдүүдэд | 40 |
| 45 | 15 | "Эм үйлдвэрлэлд тавих ерөнхий шаардлага" MNS 5524 стандартын сургалт | 10 сар | Эм үйлдвэрлэлийн хэлтэс | Танхим | Дотоодын эмийн үйлдвэрүүд | 80 |
| 46 | 16 | Бичил биетний тэсвэржилтээс сэргийлэх дэлхийн 7 хоногийн аяны хүрээнд ерөнхий боловсролын сурагчдад | 11 сар | ЭАБТСГ-ын мэргэжилтэн С.Ганболор | Танхим | Ерөнхий боловсролын сурагчид | 70 |

# ЭМ, ЭМНЭЛГИЙН ХЭРЭГСЛИЙН ХЯНАЛТ, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН 2025 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

2025 оны 12 сарын 25 өдөр

| Д/д | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Төсөв | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Зорилтот түвшин | Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /хүрээгүй бол тайлбар/ | Гүйцэтгэлийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| Стратеги төлөвлөгөөний зорилго: Чанартай, аюулгүй, эмчилгээний өндөр идэвхтэй эм, эмнэлгийн хэрэгслийн хүртээмжийг сайжруулж, үндэсний зохицуулалтын тогтолцоог Төлөвшлийн түвшин 3-т хүргэнэ. | | | | | | | |
| **НЭГ. ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДААС ТУСГАЙЛАН ҮҮРЭГ БОЛГОСОН АРГА ХЭМЖЭЭГ БҮРЭН ХЭРЭГЖҮҮЛНЭ.** | | | | | | | |
| 1. | БСТ1.1 Эм, эмнэлгийн хэрэгслийн үндэсний бодлогын баримт бичгийг боловсруулна. | - | Боловсруулсан баримт бичиг | Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт, зохицуулалтын газрын 2024-2027 оны стратеги төлөвлөгөө | Эм, эмнэлгийн хэрэгслийн үндэсний бодлогын баримт бичгийг боловсруулж, Эрүүл мэндийн яаманд хүргүүлсэн байна. | Эм, эмнэлгийн хэрэгслийн зохицуулалтын дунд хугацааны стратеги 2025-2028 оны төсөлд газар, хэлтсээс санал авч нэгтгэн ЭМС-д 2025 оны 5 дугаар сарын 26-ны өдөр танилцуулсан.<br>Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт, зохицуулалтын газрын 2024-2027 оны стратеги төлөвлөгөөг шинэчлэн боловсруулахаар дарга, хэлтсээс санал авсан. Газар, хэлтсээс чиг үүргийн дагуу дунд төлөвлөгөөнд оруулах саналаа ирүүлсэн. Тухайлбал: Эм зүйн тусламж, үйлчилгээнд олон улсын стандарт (GMP, GLP, GDP, GSP, GCP, GPP)-ын шалгуурыг ашиглан эрсдэлд суурилсан хөндлөнгийн хяналтыг хэрэгжүүлэх зорилт дэвшүүлж, улсын хэмжээнд эм зүйн тусламж, үйлчилгээний чанар, аюулгүй байдалд бие даасан хяналтыг хэрэгжүүлэх, хяналтын үйл ажиллагаа явуулахад бусад байгууллагын оролцоог хангах зэргээр саналаа ирүүлсэн.<br>Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт, зохицуулалтын газрын үндэсний бодлогын баримт бичгийн төслийг боловсруулж байна. | 70 |
| 2. | ЗГҮАХ 2.3.3.3, 2.3.3.4<br><br>Арга хэмжээ 1.3 Нэг эх үүсвэрээр авах эм, эмнэлгийн хэрэгслийн нэр төрлийг нэмэгдүүлнэ. | - | Гэрээ<br><br>Нэг эх үүсвэрээр авсан эмийн нэр төрөл, тоо | 2024 онд нэг эх үүсвэрээр авсан эмийн тоо- 23 | Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хууль, “Олон улсын чанарын шаардлага хангасан хүний эм, эмнэлгийн хэрэгсэл, биобэлдмэл, вакциныг гадаад улсын үйлдвэрлэгчээс, эсхүл олон улсын байгууллагаас шууд болон дамжуулан худалдан авах журам”-ын төсөлд нэмэлт, өөрчлөлт оруулж, хэлцэл хийж, гэрээ байгуулан худалдан авалт хийсэн байна. | “Олон улсын чанарын шаардлага хангасан хүний эм, эмнэлгийн хэрэгсэл, биобэлдмэл, вакциныг гадаад улсын үйлдвэрлэгчээс, эсхүл олон улсын байгууллагаас шууд болон дамжуулан худалдан авах журам”-д заасны дагуу худалдан авах захиалгын нэр төрлийг ЭМДЕГ, ЭМБ-даас авч нэгтгэн 3 дугаар сарын 26-ны өдрийн 01/627 дугаар бичгээр ЭМЯ-нд хүргүүлсэн.<br>БНСУ-ын Korea United Pharm Inc., үйлдвэрийн 5 нэрийн хавдрын эмийн нэг жилийн хэрэгцээг ирүүлэх тухай 6 дугаар сарын 03-ны өдрийн 01/1130 дугаар бичгээр 32 ЭМБ-аас захиалгын саналыг авч нэгтгэн 6 дугаар сарын 12-ны өдрийн 01/1231 дугаар бичгээр ЭМЯ-нд хүргүүлсэн.<br>Эмийн зөвлөлийн 6 дугаар сарын 17-ны өдрийн 06 дугаар хурлаар нэг эх үүсвэрийн аргаар худалдан авсан эмийн нэр төрөлд нэг удаагийн импортын мэдүүлэг олгох тухай асуудлыг хэлэлцүүлж, шийдвэрийн дагуу БНСУ-ын DongKoo Bio Pharma Co.Ltd, Korea United Pharm Inc, Hanmi Pharma Co.LTD үйлдвэрээс | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | худалдан авах дараах 9 нэрийн эмэнд нэг удаагийн импортын мэдүүлэг олгосон. Үүнд:<br>- Хавдрын тусламж, үйлчилгээнд хэрэглэдэг (5) БНСУ-ын Korea United Pharm үйлдвэрийн Карбоплатин 450мг/45мл, тарилгын уусмал, Цисплатин 50мг/50мл, тарилгын уусмал, Дакарбазин 200мг, тарилгын уусмал бэлтгэх лиофилизат нунтаг, Дактиномицин 0.5мг, тарилгын уусмал бэлтгэх лиофилизат нунтаг, Метотрексат 50мг/2мл, тарилгын уусмал эм;<br>- DongKoo Bio Pharma Co.Ltd үйлдвэрийн (3) Амлодипин+Валсартан 10мг/160мг, шахмал, Дапаглифлозин 10мг, шахмал, Клопидогрел 75мг, шахмал эм;<br>- Hanmi pharm Co.Ltd үйлдвэрийн (1) Ривароксобан 20мг, шахмал эм тус тус болно.<br>Тус шийдвэрийн хүрээнд Korea United Pharm үйлдвэртэй 6 дугаар сарын 9, DongKoo Bio Pharma Co.Ltd үйлдвэртэй 6 дугаар сарын 27-ны өдөр тус тус гэрээ байгуулсан.<br>ЭМБ-аас төрөөс төлбөрийг нь хариуцах таталтын эсрэг эмийн нэг жилийн хэрэгцээний тоог 8 дугаар сарын 05-ны өдрийн 01/1471 дугаар бичгээр авч нэгтгэн UNICEF, UNOPS, UNDP болон IDA Foundation ОУБ, Novartis Pharma Services үйлдвэрийн ТГ-т мэдээллийг хүргүүлж, нийлүүлэх боломжтой нэр төрөл, үнийн санал авсан.<br>ЭЭХтХ-ийн 47 дугаар зүйлийн 47.2, "Олон улсын чанарын шаардлага хангасан хүний эм, эмнэлгийн хэрэгсэл, биобэлдмэл, вакциныг гадаад улсын үйлдвэрлэгчээс, эсхүл олон улсын байгууллагаас шууд болон дамжуулан худалдан авах журам"-ын 2.1-т тус тус заасны дагуу ЭМДЕГ-т Novartis Pharma Services үйлдвэрийн үнийн санал ирүүлсэн 17 нэрийн эмэнд төсвийн нөлөөлөл болон бусад холбогдох саналыг ирүүлж хамтран ажиллах тухай 9 дүгээр сарын 24-ний өдөр 05/1708 дугаар бичиг хүргүүлсэн. 10 дугаар сарын 02-ны өдрийн 05/1806 болон 05/1807 дугаар албан бичгээр ЭМБ-ын захиалгын тоо, хэмжээг авч ОУБ болон үйлдвэрлэгчидтэй хийж буй хэлцлийн дүнд уналт таталтын эсрэг 10 үйлдвэрлэгчийн 45 нэр төрлийн эм, гемофилийн эсрэг рекомбинант VIII, IX факторыг худалдан авахаар шийдвэрлэсэн бөгөөд ЭМС-ын 11 дүгээр 20-ны өдрийн А/429 дүгээр тушаалаар батлагдсан ажлын хэсгийн нэг эх үүсвэрийн аргаар худалдан авах санал бүхий эмийн нэр төрөл, тоо хэмжээ, төсвийн тооцооллыг гаргаж, ЭМС-аар 3 хүртэлх жилээр батлуулан хэлцэл хийх байгууллагатай гэрээ байгуулах шийдвэр гарсан. | |
| **ХОЁР. ЭМ, ЭМНЭЛГИЙН ХЭРЭГСЛИЙН ХЯНАЛТ, ЗОХИЦУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНД ОЛОН УЛСЫН ЧАНАРЫН УДИРДЛАГЫН ТОГТОЛЦООГ НЭВТРҮҮЛЭХ** | | | | | | | |
| 3. | БСТ 1.2 | - | Үнэлгээний дүн | Байгууллагын хөгжлийн | Байгууллагын хөгжлийн төлөвлөгөө "2023-2026"- | Агентлагийн даргын 2025 оны А/19 тушаалаар "Эмийн зохицуулалтын үйл ажиллагааг үнэлүүлэх бэлтгэл ажил хангах | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | Байгууллагын үйл ажиллагаанд нөхцөл байдлын үнэлгээ хийж, төлөвлөгөөг шинэчлэн батлуулна. | | Шинэчлэн батлуулсан төлөвлөгөө<br><br>Төлөвлөгөөний хэрэгжитийн хувь | төлөвлөгөө "2023-2026" | нд хяналт, үнэлгээ хийж, сайжруулах саналыг даргын зөвлөлийн хуралд танилцуулж, төлөвлөгөөг шинэчлэн батлуулж, хэрэгжилтийн ханган ажилласан байна. | ажлын хэсэг" байгуулагдаж, "Байгууллагын 2023-2026 оны хөгжлийн төлөвлөгөө" болон Олон улсын жишиг тогтоох үнэлгээний дагуу төлөвшлийн түвшин 3 (ТТ3)-т хүрэх үйл ажиллагааны хэрэгжилтүүдийг нэгтгэж үнэлгээ хийсэн. Тус төлөвлөгөөнд эмийн зохицуулалтын 9 чиглэлийн 73 дэд шалгуурын хүрээнд нийт 87 ажлыг төлөвлөснөөс 67% нь ТТ 3-т хамаарах харин ТТ 1 болон 2-т хамаарах буюу эмийн зохицуулалтын суурь эрх зүйн зохицуулалтыг бэхжүүлэх ажил нь төлөвлөгөөний 12%-ийг эзэлсэн. Төлөвлөгөөний хэрэгжилтийг үнэлэхэд 73 дэд шалгуураас 41%, үйл ажиллагааны 47%-ийг бүрэн хэрэгжсэн үзүүлэлтэй гарсан. Олон улсын жишиг тогтоох үнэлгээний аргачлалаар өөрийн үнэлгээг дахин хийхэд ТТ 1 болон 2-т хамаарах 59 дэд шалгуураас 50 дэд шалгуурт хамаарах үйл ажиллагааг бүрэн хэрэгжүүлдэг бөгөөд ТТ 3-т хүрэхэд 73 дэд шалгуурт хамаарах үйл ажиллагааг хэрэгжүүлэх шаардлагатай. Өөрөөр хэлбэл ТТ 3-т хүрэхэд 128 дэд шалгуурыг бүрэн хэрэгжүүлж, 61%-ийн хэрэгжилттэй дүн гарсан. Дээрх 2 үнэлгээний дүнд үндэслэн "Байгууллагын хөгжлийн төлөвлөгөө 2025-2028"-ын төслийг боловсруулж, 2025 болон 2026 оны 1 дүгээр улиралд ТТ 1 болон 2-т хамаарах бүхий үйл ажиллагааг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн. Тус төлөвлөгөөнд 44 шалгуурын 90 дэд шалгуурын хүрээнд 105 үйл ажиллагааг хэрэгжүүлэхээр тусгасан. Төлөвлөгөөг 2025 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн А/221 тушаалаар шинэчлэн батлуулсан. | |
| 4. | БСТ 1.3 Эмийн зохицуулалтын гадны байгууллагатай хамтын ажиллагааг эхлүүлнэ. | 20 сая төгрөг (улсын төсөв) | Хамтын ажиллагаа эхлүүлсэн байгууллагын тоо | Бүгд Найрамдах Польш улсын элчин сайдын яам, АНУ-ын элчин сайдын яамны Ази номхон далайн бүсийг хариуцсан хэлтсийн даргатай уулзалт зохион байгуулж, цаашдын хамтын ажиллагааг хэлэлцсэн. | Нэгээс доошгүй эмийн зохицуулалтын гадны байгууллагатай хамтын ажиллагаа эхлүүлсэн байна. | 1. БНПУ-ын Эм, эмнэлгийн хэрэгсэл болон биоцидийн бүртгэлийн газартай хамтын ажиллагааны санамж бичиг 2025 оны 3 дугаар сарын 13-ны өдөр зурж, Гадаад харилцааны яамнаас байгууллага хоорондын гэрээний бүртгэлийн "2025 03/04" дугаарт бүртгэсэн. БНПУ-ын Эм, эмнэлгийн хэрэгсэл, биоцидын бүтээгдэхүүний бүртгэлийн газрын төлөөлөгч 6 сарын 02-06-ны өдрүүдэд ажлын айлчлал хийж, хамтын ажиллагааны баримт бичгийн хүрээнд өмнө хэлэлцсэн асуудлыг бодит ажил хэрэг болгох үүднээс эмийн бүртгэл, хангамжийн асуудлаар хамтран ажиллах талаар харилцан тохиролцсон. Эм үйлдвэрлэлийн зохистой дадлын шаардлага хангасан Армон, Мон-Интра эмийн үйлдвэрүүдийн үйл ажиллагаатай танилцаж, 2022-2024 онд экспортод гаргасан уламжлалт эмийн мэдээлэлтэй танилцилсан.<br>2. АНУ-ын Элчин сайдын яамны худалдааны төлөөлөгчидтэй 4 дүгээр сарын 04-ний өдөр хийсэн уулзалтын үеэр нэг эх үүсвэрийн худалдан авалтын зохицуулалтын талаар танилцуулж, тус улсын ижил чиг үүргийн байгууллагатай хамтран ажиллах саналыг илэрхийлсэн.<br>3. БНСУ-ын Эм, хүнсний аюулгүй байдлын яамны сургалтад хамрагдах төслийг 2023 онд БНСУ-ын KOICA-ын группд | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | илгээсэн. Эм, эмнэлгийн хэрэгслийн зохицуулалтыг бэхжүүлэх 3 жилийн сургалтад хамруулах албан бичиг ирүүлж, 2025 оны 8 дугаар сарын 24-ний өдрөөс 9 дүгээр сарын 06-ны өдрүүдэд БНСУ-д 14 албан хаагч эм, эмнэлгийн хэрэгслийн зохицуулалтыг бэхжүүлэх сургалтад хамрагдсан.<br>4. БНСУ-ын олон улсын эрүүл мэндийн сангийн санхүүжилтээр "Эмнэлгийн тоног төхөөрөмжийн техникийн үйлчилгээний чадавхийг сайжруулах–CEOMETS" хөтөлбөрийг 2026 оны 01 дүгээр сараас эхлэн 5 жилийн хугацаатай хэрэгжүүлэхээр харилцан ойлголцлын санамж бичиг, санхүүжилтийн гэрээ байгуулахаар хэлэлцэл хийж байна. | |
| 5. | БСТ 1.4<br>Олон улсын баримт бичгийг судалж, чанарын гарын авлага боловсруулна. | 10 сая төгрөг (улсын төсөв) | Боловсруулсан гарын авлага | - | Эмийн зохицуулалтын байгууллагын чанарын гарын авлага боловсруулсан байна. | - ДЭМБ-аас эмийн зохицуулалтын байгууллагад зориулан гаргасан QMS-ийн загвар гарын авлага, стандарт ажиллагааны заавар, баримтжуулалт, эрсдэлийн удирдлага, хяналтын системийг хэрхэн хэрэгжүүлэх тухай зааварчилгаа, Япон улсын эмийн зохицуулалтын байгууллага (PMDA)-аас 02 дугаар сарын 26-наас 28-ны өдрүүдэд зохион байгуулсан "PMDA-ATC Pharmacovigilance Seminar 2025" сургалтад танилцуулагдсан эрсдэлийн менежментийн төлөвлөгөө зэрэг баримт бичгийг орчуулсан.<br>- ДЭМБ-ын "Үндэсний эмийн зохицуулалтын байгууллагуудад чанарын удирдлагын тогтолцоог хэрэгжүүлэх тухай удирдамж"-ийг орчуулж судалсан.<br>- ДЭМБ, АХБ, ЭМЯ-тай хамтран "Чанарын удирдлагын тогтолцоог хэрэгжүүлэх" сургалтыг 6 дугаар сарын 10-13-ны өдрүүдэд зохион байгуулсан.<br>- Эм зүйн салбарын үзүүлэлт 2024 оны эмхэтгэлийг газар, хэлтэс болон гадны байгууллагаас ирүүлсэн статистик тоон мэдээллийг нэгтгэн боловсруулж, эмхэтгэлийн төслийг гаргаж ЭХБ болон олон нийтэд түгээсэн.<br>- "Чанарын удирдлагын тогтолцоо нэвтрүүлэх нь буюу Менежментийн тогтолцооны ач холбогдол" сургалтыг 11 дүгээр сарын 19-ний өдөр зохион байгуулсан. | 70 |
| 6. | МУХТҮЧ 2.2.7<br>БСТ 1.1<br>Эм, эмнэлгийн хэрэгслийн чанар аюулгүй байдлыг хангах, хангамж хүртээмжтэй холбоотой эрх зүйн баримт бичгийг | - | Хүргүүлсэн журмын төсөл<br><br>Шинээр батлуулсан журмын тоо | - | Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хуулийг дагаж гарах 6 журмын төсөлд санал хүргүүлсэн байна.<br>Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт, зохицуулалтын газрын даргаар батлуулах 5 журмыг батлуулсан байна. | Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хуулийг дагаж гарах дараах журмыг шинэчлэн боловруулж батлуулсан. Үүнд:<br>1. "Эм, эмийн үйлчлэгч бодис, эмнэлгийн хэрэгсэл, эрүүл мэндийн нэмэлт бүтээгдэхүүнийг бүртгэх журам" Эрүүл мэндийн сайдын 5 дугаар сарын 26-ны өдрийн А/206 дугаар тушаалаар батлагдаж, Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн сангийн 7272 дугаарт бүртгэгдсэн.<br>2. Эрүүл мэндийн сайдын 02 дугаар сарын 03-ны өдрийн А/34 дүгээр тушаалаар "Зөвлөлийн бүрэлдэхүүн, ажиллах журам" батлагдсан. | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | боловсруулж, батлуулна. | | | | | 3. Эрүүл мэнд, спортын сайдын 2013 оны А/68 тушаалаар батлагдсан "Мансууруулах болон сэтгэцэд нөлөөт эмийг импортлох, үйлдвэрлэхэд, ханган нийлүүлэх журам"-ыг Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт эмийн жагсаалт болон тэдгээрийг үйлдвэрлэх, импортлох, ханган нийлүүлэх, экспортлох, хадгалах, устгах, түгээх, худалдах үйл ажиллагааг зохицуулах журам болон өөрчилж жагсаалтын шинэчилсэн төслийг байгууллагын цахим хуудсанд байршуулж, цахим хэлэлцүүлгийг 6 дугаар сарын 03-ны өдөр хийсэн.<br>4. Эмнэлгийн хэрэгслийг эрсдэлийн зэргээр ангилах журмын төслийг 6 бүлэг, 187 заалтай боловсруулсан. Журмын төсөлд үндэслэн 4254 эмнэлгийн хэрэгслийн хэрэгслийг эрсдэлийн зэргээр ангилж, нийт 11203 эмнэлгийн хэрэгслийг эрсдэлийн зэргээр ангилсан жагсаалт үүсгэсэн. Даргын зөвлөлийн 5 дугаар сарын 20-ны өдрийн хурлаар Эмнэлгийн хэрэгслийг эрсдэлийн зэргээр ангилах журам, жагсаалтын төслийг хэлэлцүүлж, шаардлагатай өөрчлөлтийг тусгаж, нийт 11553 эмнэлгийн хэрэгслийг эрсдэлийн зэргээр ангилсан жагсаалтын төсөл гарсан.<br>5. "Эмнэлгийн тоног төхөөрөмжид шалгалт баталгаажуулалт, шалгалт тохируулга хийх журам"-ын төслийг 7 бүлэг 47 заалт, 5 хавсралттай боловсруулсан.<br>6. Засгийн газрын 2024 оны 42 дугаар тогтоол "Олон улсын чанарын шаардлага хангасан хүний эм, эмнэлгийн хэрэгсэл, биобэлдмэл, вакциныг гадаад улсын үйлдвэрлэгчээс, эсхүл олон улсын байгууллагаас шууд болон дамжуулан худалдан авах журам"-ын төсөлд нэмэлт өөрчлөлт оруулах нийт 48 саналыг ЭМЯ-нд 2025 оны 04 дүгээр сарын 01-ний өдрийн 01/644 дүгээр бичгээр хүргүүлсэн.<br>7. ЭМС-ын 2025 оны 3 дугаар сарын 31-ний өдрийн А/101 дүгээр тушаалаар "Олон улсын чанарын шаардлага хангасан хүний эм, эмнэлгийн хэрэглэгдэхүүн, биобэлдмэл, вакциныг гадаад улсын үйлдвэрлэгчээс, эсхүл олон улсын байгууллага, эмийн зохицуулалтын үнэлгээгээр ДЭМБ-аас хүлээн зөвшөөрөгдсөн эмийн зохицуулалтын эрх бүхий байгууллагатай гадаад улсаас шууд болон дамжуулан худалдан авах журам"-ыг боловсруулахад хамтран ажиллаж төслийг 2025 оны 9 дүгээр сарын 05-ны өдрийн ЭМЯ-ны УЗ-ийн хурлаар хэлэлцүүлсэн. ЭМЯ-ны 10 дугаар сарын 01-ний өдрийн санал ирүүлэх тухай албан бичгээр 5 яамнаас ирүүлсэн саналын томьёолол, журмын төслийн нийцлийг тодорхойлж, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, Сангийн яамнаас ирүүлсэн 3 саналыг төсөлд тусгаж, ЭМЯ-нд 11 дүгээр сарын 29-ний өдөр цахимаар хүргүүлсэн. | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт, зохицуулалтын газрын даргаар батлуулсан журам-6. Үүнд:<br>1. “Эмийн эмчилгээний хорооны журам”-ыг агентлагийн даргын өдрийн А/28 дугаар тушаалаар батлуулсан.<br>2. “Эмийн зөвлөл болон Эмнэлгийн хэрэгслийн зөвлөлийн салбар зөвлөлийн ажиллах журам”-ыг агентлагийн даргын 2025 оны А/42 дугаар тушаалаар батласан.<br>3. “Эм, эмнэлгийн хэрэгсэл, эрүүл мэндийн нэмэлт бүтээгдэхүүний чанар, аюулгүй байдлын талаар шуурхай сэрэмжлүүлэх, эргүүлэн татах, устгах журам”-ыг агентлагийн даргын А/130 дугаар тушаалаар батлагдсан.<br>4. “Эмийн гаж нөлөөг бүртгэх, мэдээлэх, үнэлэх, тайлагнах журам”-ыг шинэчлэн боловсруулж, агентлагийн даргын А/128 дугаар тушаалаар “Фармаковижилансийн үйл ажиллагааг зохицуулах журам”-ыг 6 бүлэг, 6 хавсралттай батлуулсан.<br>5. “Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт, зохицуулалтын үйл ажиллагаатай холбоотой төлбөр, хураамжийн хэмжээ, зардлын жишиг, зарцуулах журам” шинэчлэн боловсруулах ажлын хэсэг агентлагийн даргын 2025 оны А/02 дугаар тушаалаар батлагдсан.<br>6. “Эм, эмнэлгийн хэрэгсэл, эмийн үйлчлэгч бодис, Эрүүл мэндийн нэмэлт бүтээгдэхүүнийг бүртгэх журам”-ыг үндэслэн шинэчлэн боловсруулж, ЭЭХХЗГ-ын даргын 2025 оны А/194 дүгээр тушаалаар батлуулсан. | |
| 7. | БСТ 4.1<br>Эм, эмнэлгийн хэрэгслийн үйлдвэр, ханган нийлүүлэх байгууллага, эмийн санд тавигдах нийтлэг шаардлагыг олон улсын удирдамжид нийцүүлэн шинэчилнэ. | - | Стандарт хэмжил зүйн газарт хүргүүлсэн стандартын төсөл | Эмийн үйлдвэрлэлд тавигдах ерөнхий шаардлага<br>MNS 5524-2014<br>Эм, эмнэлгийн хэрэгсэл ханган нийлүүлэх байгууллага<br>MNS 5530-2014<br>Эмийн санд тавигдах нийтлэг шаардлага<br>MNS 5260-2015 | Стандарт хэмжил зүйн газарт 3 стандартын төслийг хүргүүлсэн байна. | 1. Эмийн жорын маягт, жор бичилтэд тавигдах ерөнхий шаардлага MNS 5376:2016 стандарт шинэчлэн 7 дугаар сарын 31-ний өдрийн 01/1459 дугаар албан бичгээр СХЗГ-т хүргүүлсэн.<br>2. Эмийн санд тавигдах нийтлэг шаардлага MNS 5260:2015 стандарт шинэчлэн 11 дүгээр сарын 12-ны өдрийн 01/2097 дугаар албан бичгээр СХЗГ-т хүргүүлсэн.<br>3. Эм, эмнэлгийн хэрэгсэл ханган нийлүүлэх байгууллагад тавигдах ерөнхий шаардлага MNS 5530:2014 стандарт шинэчлэн боловсруулж, 11 дүгээр сарын 04-ний өдрийн 01/2097 дугаар албан бичгээр СХЗГ-т хүргүүлсэн.<br>4. Эмийн чанарын хяналтын лабораторид тавих шаардлага MNS 6621:2016 стандарт шинэчлэн боловсруулж байна. MNS ISO/IEC 2017, ДЭМБ Техникийн тайлангийн цувралууд 957 зэрэгт өөрчлөлт орсонтой холбоотойгоор шаардлагатай нэмэлт өөрчлөлтүүдийг хийж байна. | 100 |
| 8. | БСТ 1.1<br>Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт, | - | Шинээр боловсруулсан САЗ | 179 Үйл ажиллагаанд мөрдөж буй 179 САЗ | Газар, хэлтсийн үйл ажиллагаатай холбоотой 8 САЗ-ыг шинээр батлуулсан байна. | Шинэчлэн болон шинээр боловсруулсан САЗ-ын тоо-13. Үүнд:<br>- Хяналт, шалгалтын үйл ажиллагаатай холбоотой 4 САЗ-ыг Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хууль болон холбогдох эрх | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | зохицуулалтай холбоотой стандарт ажиллагааны заавар (САЗ)-ыг шинэчлэнэ. | | Шинэчлэн батлуулсан САЗ | | | зүйд өөрчлөлт орсонтой холбоотойгоор шинэчлэн батлуулсан.<br>- Дотоодын эмийн үйлдвэрийн эм бүртгэх САЗ, импортын эмийн бүртгэлийн өөрчлөлтийн САЗ-ыг батлуулсан.<br>- GMP-ийн батламж шинээр олгох, хугацаа сунгах, Үйлдвэрлэгчийн фармакопейн өгүүллийг фармакопейн хороогоор батлуулах, Эмзүйн салбар зөвлөлийн бүрэлдэхүүн ажиллах САЗ-д өөрчлөлт оруулж шинэчлэн батлуулсан.<br>- Эмийн хэрэглэх заавар баталгаажуулах САЗ-ыг шинэчлэн боловсруулж батлуулсан.<br>- Сэжигтэй хуурамч, стандартын бус эмийг илрүүлэх тандалт судалгаа хийх САЗ-ыг хуулинд нийцүүлэн шинэчлэн боловсруулж, батлуулсан.<br>- Эм, эмнэлгийн хэрэгсэл, эрүүл мэндийн нэмэлт бүтээгдэхүүний чанар, аюулгүй байдлын талаар шуурхай сэрэмжлүүлэх, эргүүлэн татах, устгах стандарт ажиллагааны зааврыг шинээр боловсруулж, батлуулсан.<br>- Зах зээлийн тандалтын үйл ажиллагааны талаар зохицуулалтын байгууллага дотооддоо мэдээлэх САЗ-ыг шинээр боловсруулж, батлуулсан.<br>- Дархлаажуулалтын дараах урвал хүндрэлийг бүртгэх, мэдээлэх, мэдээлэл солилцох САЗ-ыг шинэчлэн боловсруулж, батлуулсан.<br>- Импортын эмийг бүртгэх, дотоодын эмийн үйлдвэрийн эм бүртгэх САЗ, импортын эмийн бүртгэлийн өөрчлөлтийн САЗ батлуулсан.<br>Шинэчлэн боловсруулж буй САЗ-ын тоо-16. Үүнд:<br>- Лабораторийн үйл ажиллагаанд ашиглагдаж буй мэдрэмжит ион солилцооны хроматограф (ӨИШХ), пектрофотометр, pH метр, шатаах зуух, аналитик жин, бат бөх тодорхойлох багажийн САЗ-ыг боловсруулсан.<br>- Тусгай зөвшөөрлийн хүсэлтийг цахимаар хүлээн авах болон гэрчилгээнд бичилт хийх САЗ, тусгай зөвшөөрөл шинээр олгох, чиглэл нэмэх, хугацаа сунгах, хаягийн өөрчлөлт, нэмэлт агуулах бүртгэх САЗ-ын төслийг боловсруулсан.<br>- Эм, эмнэлгийн хэрэгсэлд импорт, экспортын мэдүүлэг олгох САЗ, хандив, тусламжийн эм, эмнэлгийн хэрэгсэлд импорт, экспортын мэдүүлэг олгох САЗ-ын төслийг боловсруулсан. | |
| **ГУРАВ. ЭМ, ЭМНЭЛГИЙН ХЭРЭГСЛИЙН БҮРТГЭЛ, ХЯНАЛТ, МЭДЭЭЛЛИЙН НЭГДСЭН ЦАХИМ ТОГТОЛЦООГ БҮРДҮҮЛНЭ.** | | | | | | | |
| 9. | БСТ 1.8<br>Эм, эмнэлгийн хэрэгслийн нэгдсэн цахим тогтолцоог | 950 сая төгрөг (улсын төсөв, олон | Нэгдсэн цахим программ<br><br>Хөгжүүлэлт хийж үйл ажиллагаанд | Tzmoh.gov.mn<br>Licemed.mohs.gov.mn<br>EMongolia<br>Burtgel.mohs.mn | Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт, зохицуулалтын нэгдсэн системийн ашиглалтанд оруулсан байна. | Байгууллагын үйл ажиллагааны цахим шилжилтийг эрчимжүүлэх ажлын хэсэг агентлагийн даргын 3 дугаар сарын 26-ны өдрийн А/59 дүгээр тушаал батлагдаж, эмийн бүртгэлийн Лайсмед программийн өгөгдлийн санг эм, эмнэлгийн хэрэгслийн хяналтын | 90 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | хөгжүүлж нэвтрүүлнэ. | улсын төсөл, хөтөлбөр) | нэвтэрсэн цахим систем | Heps.hdc.gov.mn<br>Ereporting<br>Lims програм<br>License.mn | Эм, эмнэлгийн хэрэгслийн зохицуулалтын удирдлагын систем, эм, эмнэлгийн хэрэгслийн нөөц, нийлүүлэлт, хяналтын систем, лабораторийн удирдлагын системийн хөгжүүлэлтийг хийж, хэрэглээнд нэвтрүүлсэн байна. | нэгдсэн цахим системд хөрвүүлэх (data migration) ажил хийгдэж, эмийн бүртгэлийн модульд туршилт хийж байна.<br>Үүнд:<br>- Хилээр орж ирж байгаа эм, эмнэлгийн хэрэгслийг гаалийн мэдээллээс иргэдийн гарт очих хүртэлх мэдээлэл солилцох, эмийн үнэ, чанар, аюулгүй байдлын хяналтыг сайжруулахаар гаалийн автоматжуулсан мэдээллийн системтэй 40 төрлийн мэдээлэл солилцож байна. Мэдээлэл солилцож байгаа сервист импортын мэдүүлгийг гаалийн системд 1 дуудагдаж дахин дуудагдахгүй байх тохиргоо хийж бүрэн цахимжуулсан.<br>- Эм, эмнэлгийн хэрэгслийн нөөц, үнийн өсөлтөд хяналтын тогтолцоо бүрдүүлэхээр Цахим төлбөрийн баримтын систем (POS API 2.0)-ийг шинэчилж, эмийн цувралын дугаар, үнэ, жижиглэнгийн үнийн мэдээллийг хянах, эмийн зах зээлийн дараах чанар аюулгүй байдлын хяналтыг цувралын дугаараар мөшгөх тогтолцоог бүрдүүлж, Цахим төлбөрийн баримтын систем "POS API 3.0"-д цувралын дугаараар бүртгэн И-баримтын загварт цувралын дугаар хэвлэх боломжийг бий болгож "Цахим мэдээллийн нэгдсэн сан" бий болгохоор ажиллаж байна. ЭМЯ-наас өгсөн чиглэлийн дагуу ЗӨСҮТ-ийн агуулахын бүртгэлийн системийн ажлын даалгавар, эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт зохицуулалтын нэгдсэн системийн ажлын даалгаврыг нэгтгэн, 10 дугаар сарын 01-ний өдөр ЭМЯ-нд цахимаар хүргүүлсэн. Тус системийн хөгжүүлэлтийг Гэрэгэ Системс ХХК хийж байна.<br>- СМТТ-тэй хамтран бараа бүртгэлийн нэгдсэн системд эм, эмнэлгийн хэрэгслийн хамгийн бага хэмжих нэгж, түүний суурь үнэ, бөөний үнэ, жижиглэнгийн үнэ, зах зээлийн эргэлтийг хянах, эмийн сангийн худалдаж байгаа эм, эмнэлгийн хэрэгслийн жижиглэнгийн үнийг эм хангамжийн байгууллагаас цахим төлбөрийн системээр дамжуулан авч байна.<br>Дийг Ай Ти ХХК-тай 2024 онд "Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт, зохицуулалтын газрын суурь системийн техник эдийн засгийн үндэслэл боловсруулах" ЭЭХХЗГ/03/28 дугаар ажил гүйцэтгэх гэрээний дагуу эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт, зохицуулалтын нэгдсэн цахим систем /Digital.mmra.gov.mn/ -ийн хөгжүүлэлт хийж Лабораторын удирдлага, Импортын мэдүүлгийн удирдлага, Эм, эмнэлгийн хэрэгслийн бүртгэлийн удирдлагын модулийн хөгжүүлэлт дууcч Эмийн бүртгэлийн мэдээний сан Лайсмед программ, Эм шинжлэх лабораторийн ЛИМС программын өгөгдлийн сан хөрвүүлэх ажил хийгдсэн.<br>И-Монгол академи УТҮГ-т цахимаар хүлээн авч байгаа үйлчилгээг зохицуулалтыг сайжруулах зорилгоор дараах арга хэмжээнд хэрэгжүүлсэн. Үүнд: | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | - Жоргүй олгох эмийн зар сурталчилгааны агуулгыг дамжуулан word файлаар хүлээн авах хүсэлт<br>- Эрүүл мэндийн нэмэлт бүтээгдэхүүний зар сурталчилгааны зөвшөөрлийг эмнэлгийн хэрэгслийн зар сурталчилгааны зөвшөөрөл болгох хүсэлт<br>- Үндэсний үйлдвэрийн эм, эмнэлгийн хэрэгслийн бүртгэл, импортын эмийн сунгалт, хасалт, өөрчлөлтийн бүртгэлийн үйл ажиллагааг цахимжуулах хүсэлт<br>- Вакцин, биобэлдмэлийн бүртгэлийн баримт бичгийг цахимаар хүлээн авах хүсэлт<br>- Бүртгэлийн шинжээч нарыг санамсаргүй аргаар сонгох талаар хөгжүүлэлтийг хийлгэх хүсэлтийг тус тус хүргүүлж, үйл ажиллагаандаа нэвтрүүлж эхэлсэн. Бүртгэлийн шинжээч нарыг санамсаргүй аргаар сонгох үйл ажиллагааг шинжээчийн сонгон шалгаруулалтыг хийсний дараа хийх боломжтой болсон.<br>"Хянагч" тохиргоог өөрийн ажлын байрны чиг үүрэгт хамаарах үйлчилгээнээс сонгон тухайн газрын хэлтсийн дарга, ахлах хянахаар тохиргоотой болгож хөгжүүлсэн.<br>- Ахуйн шавж, мэрэгч устгах, ариутгах, халдваргүйжүүлэх импортын бодисын бүртгэлийн үйл ажиллагаа, үндэсний үйлдвэрийн бодисын бүртгэлийн үйл ажиллагаа, бүртгэлийн өөрчлөлтийн үйл ажиллагаа, бүртгэлийн хугацаа сунгалтын үйл ажиллагаа, бүртгэлийг хүчин болгох үйл ажиллагаа шинээр нэмэгдсэн.<br>- Бүртгэлийн шинжээчийг санамсаргүйгээр сонгохоор хөгжүүлэлт хийсэн.<br>- Лайсмед мэдээний санд ханган байгууллагын мэдээлэл дутуу буюу хоосон талбартай бол импортын мэдүүлэг хүсэх үед хориг тавих хөгжүүлэлтийг хийсэн. Нийт 262 байгууллагын мэдээллийг бүрэн болгож, мэдээний сангийн бүрэн байдлыг хангасан.<br>- Хур системд холбогдсонтой холбоотой дундаа зайтай 43 нэрийн эмийн бар кодын мэдээллийг шахаж зайгүй болгож Лайсмед мэдээний санд оруулсан. | |
| 10. | БСТ 1.5<br>Үйл ажиллагааны нэгдсэн мэдээллийн хянах самбар (Dashboard)-ыг нэвтрүүлнэ. | - | Үйл ажиллагааны хянах самбар | - | Газар, хэлтсийн 7 хоног, сар, улирлын тоон үзүүлэлтийг цахимд байршуулж, үйл ажиллагаанд нэвтрүүлсэн байна. | Үйл ажиллагааны нэгдсэн мэдээллийн хянах самбар (Dashboard)-ыг 5 дугаар сарын 27-ны өдрөөс эхлэн ажиллуулж эхэлсэн. Газар, хэлтсүүдийн статистик тоон үзүүлэлтийг авч нэгтгэн долоо хоног бүрийн 1 дэх өдрийн даргын зөвлөлийн хурлаар танилцуулж, байгууллагын цахимд байршуулж, үйл ажиллагаандаа нэвтрүүлсэн.<br>Эм, эмнэлгийн хэрэгслийн нэгдсэн систем бүрэн ажиллаж эхэлснээр эмийн бүртгэл, импортын мэдүүлэг, тусгай зөвшөөрөл, эм шинжлэх лабораторын шинжилгээ, дотоодын үйлдвэрийн мэдээлэл, эмийн нөөцийн систем, эмийн шатлал бүрт үнийн | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | нэмэгдэл, цувралаар мөшгөх системийн мэдээллийг нэгдсэн мэдээллийн хянах самбар (Dashboard)-аар хянах боломжтой болно | |
| 11. | БСТ 1.5<br>Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль, Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллана. | - | Цахимд байршуулсан мэдээллийн тоо | Shilendans.gov.mn цахим хуудсанд 63 удаагийн мэдээлэл, Засгийн газрын нээлттэй мэдээллийн сан shilen.gov.mn системд 23 бүлэг мэдээлэл тус тус байршуулсан. | Засгийн газрын 2022 оны 201 дүгээр тогтоолоор баталсан "Нээлттэй мэдээллийг цахим хэлбэрээр байршуулж нийтлэх, шинэчлэх, хяналт тавих нийтлэг журам"-ын хэрэгжилтийн хангаж, байгууллагын чиг үүрэг, үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалт, төсөв, санхүү, худалдан авах ажиллагаа, хүний нөөцийн талаарх мэдээллийн цахимд байршуулж, нээлттэй, ил тод байдлыг хангаж ажилласан байна. | shilendans@mof.gov.mn цахим хуудсанд дараах мэдээллийг байршуулсан. Үүнд:<br>- Санхүүгийн сар бүрийн 8-ны дотор байршуулах 18 төрлийн 59 мэдээг хуулийн хугацаанд байршуулсан.<br>- Байгууллагын батлагдсан орон тоонд орсон өөрчлөлт болон Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 8, 9 дүгээр зүйлд заасны дагуу нийт 24 удаа мэдээллийг хугацаанд нь байршуулсан.<br>- Байгууллагын цахим хуудсанд нийт 273 мэдээллийг байршуулсан. Үүнд: өдөр тутмын болон онцлох үйл ажиллагаатай холбоотой мэдээлэл-215, эмийн аюулгүй байдлын талаарх сэрэмжлүүлэг мэдээлэл-7, гаж нөлөөний мэдээлэл-11, эмийн бүртгэлийн үйл ажиллагаатай холбоотой-23, тусгай зөвшөөрлийн үйл ажилллагаатай холбоотой тушаал-17 тус тус байршуулсан байна. | 100 |
| 12. | БСТ 1.5<br>Цахим хуудсыг ажиллуулах, мэдээлэл байршуулах, шинэчлэх, хяналт тавих журам батлуулна. | - | Батлуулсан журам | - | Цахим хуудсыг ажиллуулах, мэдээлэл байршуулах, шинэчлэх, хяналт тавих журмыг батлуулж, журмын дагуу мэдээллийг ил тод байршуулсан байна. | Цахим хуудсыг ажиллуулах, мэдээлэл байршуулах, шинэчлэх, хяналт тавих журмын төслийг бэлтгэхэд шаардлагатай хууль холбогдох журмуудыг судлан төслийг боловсруулах ажлыг хийж байна. | 70 |
| 13. | БСТ 1.8<br>Хяналт шалгалтад хамрагдсан болон шинээр үйл ажиллагаа эхлүүлсэн байгууллагын эрсдэлийн үнэлгээ, зөрчлийн бүртгэлийг цахим системд бүртгэнэ. | - | Хяналт шалгалтад хамрагдсан байгууллагын тоо<br><br>Бүртгэгдсэн мэдээллийн тоо<br><br>Хуулийн хугацаанд шийдвэрлэсэн зөрчлийн хэрэг | Нийт 3778 байгууллагад эрсдэлийн үнэлгээ хийж, цахим системд оруулсан. 2024 онд 86 аж, ахуйн нэгж, 19 албан тушаалтан, нийт 109 зөрчлийн хэрэг бүртгэлийн ажиллагаа явуулсан. | Шинээр байгуулагдсан болон үйл ажиллагаа явуулж буй байгууллагын эрсдэлийн үнэлгээг хийж, хяналт шалгалтад хамрагдсан мэдээллийг цахимаар бүртгэсэн байна. Зөрчлийн хэрэг бүртгэлийн ажиллагааг прокурорын нэгдсэн бүртгэлд бүртгүүлж, хуулийн хугацаанд шуурхай шийдвэрлэсэн байна. | Төлөвлөгөөт хяналт шалгалтад хамрагдахаар шилэн хяналтын цахим системд 2025 онд сонгогдсон объектын эрсдэлийн шалгуурын сонголт, үнэлгээ, хамруулалтад 757 байгууллагыг төлөвлөгөөт хяналт шалгалтад хамруулахаар төлөвлөлтийг баталгаажуулсан. Төлөвлөгөөт хяналт шалгалтад 688 объект хамрагдаж, гүйцэтгэлийн хяналтын үнэлгээнд бүрэн хамруулсан байна.<br>Төлөвлөгөөт хяналт шалгалтад хамрагдсан ЭХБ-д нийт 4591 зөрчил илэрч, 1953 зөрчлийг арилгуулж, 268 байгууллагад 2638 заалт бүхий улсын байцаагчийн албан шаардлагаар үүрэг даалгавар өгч биелэлтийг гаргуулсан. Эмнэлгүүдэд 3224 зөрчил, дутагдал илэрч 1043 дутагдлыг арилгуулж, 2181 дутагдлыг арилгуулахаар 156 байгууллагад улсын байцаагчийн албан шаардлагаар үүрэг даалгавар өгч биелэлтийг гаргуулсан. 2024 оны 12 дугаар сарын 25-аас 2025 оны 12 дугаар сарын 01-ний | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | өдөр хүртэлх хугацаанд нийт 271 зөрчилд холбогдуулан зөрчлийн хэрэг бүртгэлтийн ажиллагаа явуулсан. Үүнээс хялбаршуулсан журмаар 195, зөрчлийг хэрэг нээсэн 62, хүлээн авахаас татгалзаж шийдвэрлэсэн 8, харьяаллын дагуу шилжүүлсэн 6 байна. Тайлант хугацаанд 79 ААН, 169 иргэнд 583.3 сая төгрөгийн торгох шийтгэл ноогдуулж, 105,7 сая төгрөгийн нөхөн төлбөр тогтоож, 108,9 сая төгрөгийн үнийн дүн бүхий 179 нэр, төрлийн 26223 ширхэг зөрчилтэй бараа бүтээгдэхүүнийг хураан авч нийслэлийн орон тооны бус зөвлөлд шилжүүлсэн.<br>Бүртгэлгүй эм, эрүүл мэндийн нэмэлт бүтээгдэхүүн 102,5 сая төгрөгийн үнийн дүн бүхий 114 нэр төрлийн 23562 ширхэг, хадгалалтын дэглэм алдагдсан 2,3 сая төгрөгийн үнийн дүн бүхий 33 нэр төрлийн 2098 ширхэг, хаяг шошгын зөрчилтэй 320,0 төгрөгийн үнийн дүн бүхий 1 нэр төрлийн 8 ширхэг, хэрэглэх хүчинтэй хугацаа дууссан 3,8 сая төгрөгийн үнийн дүн бүхий 31 нэр төрлийн 555 ширхэг бүтээгдэхүүнийг хураан авч зөвлөлд шилжүүлсэн. | |
| **ДӨРӨВ. БАЙГУУЛЛАГЫН ҮНЭТ ЗҮЙЛ, ЭЕРЭГ СОЁЛЫГ БҮРДҮҮЛЖ, ТАСРАЛТГҮЙ СУРАЛЦАГЧ БАЙГУУЛЛАГА БОЛНО.** | | | | | | | |
| 14. | АТҮХХАХТ 2.6.2.1, 3.3.1.5, 6.4.11.1, 7.1.2.1, 7.1.2.2, 9.5.2.1<br>Авлигын эсрэг үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлнэ. | - | Төлөвлөгөө<br><br>Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь<br><br>Авлигтай тэмцэх газрын үнэлгээ | Авлигын эсрэг үндэсний хөтөлбөрийг хэрэгжилт 62.5 хувь үнэлэгдсэн. | Эрсдэлд суурилсан авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулж, хэрэгжүүлсэн байна. Авлигатай тэмцэх газрын үнэлгээнд 75 хувиас дээш үнэлгээ авсан байна. | УИХ-ын 2023 оны 6 дугаар сарын 30-ны өдрийн 59 дүгээр тогтоолын хавсралтаар батлагдсан Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийн дагуу байгууллагын 2025 оны "Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт, зохицуулалтын газрын үйл ажиллагааны төлөвлөгөө"-г боловсруулж, 3 дугаар сарын 27-ны өдрийн газрын даргын А/65 дугаар тушаалын хавсралтаар батлуулсан. Тус төлөвлөгөөнд 5 зорилт 18 арга хэмжээ тусгагдсан. 2025 оны 5 дугаар сарын 30-ны өдөр эхний хагас жилийн хэрэгжилтийг цахимаар хүргүүлсэн. Авлигтай тэмцэх газрын үнэлгээний дүн гараагүй байна. | 70 |
| 15. | БСТ 1.6<br>Нийгмийн баталгаа хангах хөтөлбөрийг хэрэгжүүлнэ. | 167 сая төгрөг (улсын төсөв) | Төлөвлөгөө<br><br>Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь | Нийгмийн баталгаа хангах хөтөлбөр дагуу батлуулсан төлөвлөгөөний хэрэгжилт 94 хувь | Нийгмийн баталгаа хангах хөтөлбөрийн хүрээнд 2025 оны төлөвлөгөөг батлуулж, хэрэгжилтийг бүрэн хангаж ажилласан байна. | "Төрийн албан хаагчийн ажиллах нөхцөл, нийгмийн баталгааны хөтөлбөр"-ийн хүрээнд 2025 оны хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг 6 зорилт 22 арга хэмжээ тусгаж, батлуулсан. Төлөвлөгөөний хэрэгжилт 91.3 хувьтай байна. Хэрэгжүүлсэн үйл ажиллагаанд:<br>- Албан хаагчдад шинээр зэрэг дэв олгуулах, зэрэг дэвийг ахиулах саналыг ЭМЯ-нд 01/297, 01/1422 дугаар албан бичгээр хүргүүлж, ЭМС-ын "Төрийн захиргааны албан тушаалын зэрэг дэв олгуулах тухай" А/66, А/274 дүгээр тушаалаар шинээр 21 албан хаагчид зэрэг дэв олгож, 14 албан хаагчийн зэрэг дэвийг ахиулсан. Монгол Улсын Ерөнхий сайдын 100 дугаар захирамжаар 2 албан хаагчийн зэрэг дэвийг ахиулан олгосон.<br>- Нийслэлийн орон сууцны корпорацид 4 дүгээр сарын 18-ны өдөр 01/745 дугаар албан бичгээр "Орон сууцны нөхцөлийн судалгааг" хүргүүлсэн. | 90 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | - Байгууллагын албан хаагчдын онцлогт тохирсон төсөл, хөтөлбөрийг санаачлан хэрэгжүүлэх "Хүсэлт гаргах тухай" 01/1914 дугаар албан бичгийг Нийслэлийн орон сууцны корпорацид 10 дугаар сарын 20-ны өдөр хүргүүлсэн.<br>- Хүүхдийн эрхийг хамгаалах өдрийн хүрээнд байгууллагын эцэг эхийн зөвлөлтэй хамтран "Миний аав ээжийн байр" үйл ажиллагаа зохион байгуулсан.<br>- Төрийн албан хаагчийг чадавхжуулах сургалтын төлөвлөгөөг 01 дүгээр сарын 15-ны өдөр батлуулсан. Эм зүйн салбарын мэргэжилтнүүдэд 3 зорилтын хүрээнд 46 сургалт хийхээр төлөвлөснөөс 44 сургалт зохион байгуулсан.<br>- Дотоод сургалт буюу байгууллагын албан хаагчдын мэдлэг, чадварыг нэмэгдүүлэхээр төрийн албанд анх томилогдсон албан хаагчийг чиглүүлэх богино хугацааны зайн сургалтад шинээр томилогдсон 11 албан хаагч, төрийн албанд шинээр томилогдсон албан хаагчийг мэргэшүүлэх дунд хугацааны сургалтад 3 албан хаагч, дунд хугацааны давтан сургалтад 2, ахлах түшмэлийн багц сургалтад 4 албан хаагч, эрхэлсэн түшмэлийн багц сургалтад 2 нийт 22 албан хаагчийг тус тус сургасан.<br>- Ажлын байранд албан хаагчдыг чадваржуулах 13 сургалт зохион байгуулсан.<br>- БНСУ-д 22 албан хаагч, Япон улсад 3 албан хаагч, БНХАУ 2 албан хаагч, Польш улс 2 албан хаагч, АНЭУ-ын Аби даби хотод 1 албан хаагч, ОХУ-ын Москва хотод 1 албан хаагч, БНФУ-ын Манила хот 1 албан хаагч нийт 32 албан хаагчийг гадаад сургалтад хамруулсан байна . | |
| 16. | БТС 1.6<br>Эрүүл аж, төрөх, хөдөлгөөний дутагдлаас урьдчилан сэргийлэх арга хэмжээ хэрэгжүүлнэ. | 5 сая төгрөг (улсын төсөв) | Зохион байгуулсан арга хэмжээ | Байгууллагын 5 төрөлд тэмцээн, Сайдын нэрэмжит тэмцээн | Биеийн тамир спортын арга хэмжээ зохион байгуулж, бүх нийтийн арга хэмжээнд идэвх санаачлагатай оролцсон байна. | - ЭМС-ын нэрэмжит HEALTH CUP 2025 тэмцээн 3 дугаар сарын 24-30-ны өдрүүдэд зохион байгуулагдаж, 5 төрөлд тэмцээнд 28 тамирчин амжилттай оролцсон.<br>- Байгууллагын нийт 25 албан хаагч иог, пилатесийн дасгалаар ажлын 5 өдөр тогтмол хичээллэж байна.<br>- Дэлхийн Эм зүйчдийн өдөрт зориулсан "Think Health, Think Pharmacist" бүх нийтийн гүйлт болон эрүүл мэндийн өдөрлөгийн арга хэмжээг ЭЗМТХ-той хамтран амжилттай зохион байгуулж, гүйлтийн оролцогчдын бүртгэл, гарын бэлэг гардуулах ажлыг хариуцан ажилласан. | 100 |
| 17. | БСТ 1.6<br>Албан хаагчдыг гадаад болон дотоод сургалтад тасралтгүй хамруулж, мэргэшүүлнэ. | 20 сая төгрөг (улсын төсөв) | Сургалтын төлөвлөгөө<br><br>Сургалтад хамрагдсан албан хаагчдын тоо | БНСУ-д зохион байгуулагдсан 8 төрлийн сургалтад Эм шинжлэх лабораторийн 6 албан хаагчийг ДЭМБ-ын | Сургалтын төлөвлөгөөг батлуулж, дотоод сургалтын төлөвлөгөөнд албан хаагчдыг чадавхжуулах, мэдлэг ур чадварыг дээшлүүлэх сургалтыг зохион | Төрийн албан хаагчийг чадавхжуулах сургалтын төлөвлөгөөг 01 дүгээр сарын 15-ны өдөр батлуулсан. Үүнд:<br>- Эм зүйн салбарын мэргэжилтнүүдэд 3 зорилтын хүрээнд 46 сургалт хийхээр төлөвлөснөөс 44 сургалт зохион байгуулсан.<br>- Ажлын байранд албан хаагчдыг чадваржуулах 13 сургалт зохион байгуулсан. | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Тайлан<br><br>Зохион байгуулсан сургалтын тоо | санхүүжилтээр сургасан байна.<br>Албан хаагчдыг чадавхжуулах, мэдлэг ур чадварыг дээшлүүлэх зорилгоор 19 сургалт зохион байгуулсан.<br>Төрийн албаны мэргэшүүлэх сургалтад 21 албан хаагчийг хамруулсан байна. | байгуулсан байна. Өмнөх онуудад төрийн албаны мэргэшүүлэх сургалтад хамрагдсан албан хаагчдын судалгааг гаргаж, төрийн албанд анх томилогдсон албан хаагч, төрийн албанд шинээр томилогдсон албан хаагчийг мэргэшүүлэх дунд хугацааны сургалт, дунд хугацааны давтан сургалт ахлах түшмэлийн багц сургалт, эрхэлсэн түшмэлийн багц сургалтад тус тус хамруулсан байна. | - Удирдлагын академийн мэргэшил дээшлүүлэх сургалтад дараах албан хаагчид хамрагдсан. Үүнд: төрийн албанд анх томилогдсон албан хаагчийг чиглүүлэх богино хугацааны зайн сургалтад шинээр томилогдсон 11 албан хаагч, төрийн албанд шинээр томилогдсон албан хаагчийг мэргэшүүлэх дунд хугацааны сургалтад 3 албан хаагч, дунд хугацааны давтан сургалтад 2, ахлах түшмэлийн багц сургалтад 4 албан хаагч, эрхэлсэн түшмэлийн багц сургалтад 2 нийт 22 албан хаагчийг тус тус сургасан.<br>- БНСУ-д 22 албан хаагч, Япон улсад 3 албан хаагч, БНХАУ 2 албан хаагч, Польш улс 2 албан хаагч, АНЭУ-ын Аби даби хотод 1 албан хаагч, ОХУ-ын Москва хотод 1 албан хаагч, БНФУ-ын Манила хот 1 албан хаагч нийт 32 албан хаагчийг гадаад сургалтад хамруулсан байна . | |
| 18. | БСТ 1.6<br>Эрүүл, аюулгүй орчинд ажиллах нөхцлийг сайжруулна. | 17 сая төгрөг (улсын төсөв) | Хэрэгжүүлсэн арга хэмжээ | - | Албан хаагчдын ажиллах орчин нөхцөл сайжирсан байна. | Албан хаагчдын Хавдар судлалын үндэсний төвтэй гэрээ байгуулан урьдчилан сэргийлэх үзлэгт 81 албан хаагчийг хамруулсан. Ерөнхий бүтэн биеийн багцад эмэгтэй 8, эрэгтэй 5 үзүүлэлтээр үзлэг болон шинжилгээнд хамрагдсан байна. | 90 |
| 19. | Байгууллагын брэндбүүкийг шинээр боловсруулна. | - | Боловсруулсан брэндбүүк | - | Байгууллагын брэндбүүкийг боловсруулсан байна. | Нийт албан хаагчид ажлын байранд өмсөх боломжтой байгууллагын логотой подволк хийлгэхээр загвар гаргасан. Байгууллагаа төлөөлж уралдаан тэмцээнд газар, хэлтсээс оролцох албан хаагчид подволкийг хийлгэсэн. | 90 |
| 20. | Дэлхийн эм зүйчдийн өдрийг зохион байгуулна. | 8 сая төгрөг (улсын төсөв) | Зохион байгуулсан арга хэмжээний тайлан | - | Дэлхийн эм зүйчдийн өдрийн хүрээнд төрийн бус байгууллагатай хамтран арга хэмжээ зохион байгуулсан байна. | Дэлхийн эм зүйчдийн өдрийг угтан ЭМЯ, Эм зүйн мэргэжлээр төгсөгчдийн холбоо НҮТББ-тай хамтран "Think health, Think pharmacy"-Эрүүл мэндийн төлөө эм зүйчтэй хамт сэдвээр дараах үйл ажиллагааг зохион байгуулсан. Үүнд:<br>- Бүх нийтийн гүйлт болон эмийн зохистой хэрэглээний мэдээллийг түгээн дэлгэрүүлэх өдөрлөгийг 9 дүгээр сарын 07-ны өдөр зохион байгуулсан. Бүх нийтийн гүйлтийг насанд хүрэгчид, өсвөр нас, хөгжлийн бэрхшээлтэй иргэд, тэргэнцэртэй иргэд, мэргэжлийн тамирчид гэсэн ангилалтай 6 төрлөөр зохион байгуулсан.<br>- Иргэдэд "Эмийн зохистой хэрэглээний мэдээллийг давхцалгүй түгээх" зорилгоор эм хангамжийн болон ЭМБ-тай хамтран Үндэсний цэцэрлэгт хүрээлэнд чихрийн шижин, зүрх судас, хоол боловсруулах эрхтэн тогтолцоо, бөөр, шээсний зам, амьсгалын зам, тамхины хор нөлөө, арьс харшил/гоо сайхан/, бичил биетний эсрэг эмийн зохистой хэрэглээ, эрүүл мэндийн нэмэлт бүтээгдэхүүний зохистой хэрэглээ, өвдөлт намдаах, хөнгөвчлөх эмчилгээний тусламж үйлчилгээ, | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | гэмтэл, бэртлийн үед үзүүлэх тусламж, үйлчилгээ, хүүхдэд үзүүлэх эм зүйн тусламж, үйлчилгээ, эм зүйн нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээ гэсэн чиглэлүүдээр, эм хоорондын болон эм хүнсний харилцан нөлөөлөл, эмийн гаж нөлөө, түүнээс урьдчилан сэргийлэх, эмийг гэрийн нөхцөлд хадгалах, хэрэглэх үеийн анхааруулга, эмийн зохисгүй хэрэглээнээс үүдэн гарах хүндрэлээс сэргийлэх, хянах зэрэг эрүүл мэндийг дэмжих зөвлөгөө мэдээллийг түгээсэн.<br>- Өдөрлөгийн үеэр иргэдээс гэрт нь байгаа хэрэглээгүй үлдээсэн, хугацаа дууссан, хагарч гэмтээсэн эмийн үлдэгдлийг цуглуулан авсан.<br>- Business.mn сэтгүүлийг гаргасан. | |
| 21. | БСТ 1.7 Агентлагийн нэрэмжит "Ногоон төгөл"-ийг тохижуулна. | 2.5 сая төгрөг (улсын төсөв) | Хэрэгжүүлсэн арга хэмжээний тоо | БЗД-ийн Хонхор тосгонд 2021 онд мод тарьсан. | Нийгмийн хариуцлагын хүрээнд байгаль орчинд ээлтэй орчин бүрдүүлсэн байна. | Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлигаар "Мод тарих үндэсний өдөр" арга хэмжээг ЭМЯ-наас зохион байгуулж, мод тарих үйл ажиллагаанд оролцсон. Нийт 18 албан хаагч оролцож, агч мод 20 ширхэг, голт бор мод 30 ширхэгийг тус тус тарьсан. Мөн 2025 оны 10 дугаар сарын 11-ний өдөр Олон улсын эко цэцэрлэгт хүрээлэнд 19 албан хаагч мод тарьсан. | 100 |
| **ТАВ. ЭМ ШИНЖЛЭХ ЛАБОРАТОРИЙН ЧАДАВХИЙГ НЭМЭГДҮҮЛЖ, БҮС НУТГИЙН ОЛОН УЛСЫН ХЯНАЛТЫН ЛАБОРАТОРИЙН СҮЛЖЭЭНД НЭГДЭНЭ.** | | | | | | | |
| 22. | БСТ 10.1 Лабораторийн байрыг зохистой дадлын шаардлагад нийцүүлэн шинэчлэнэ. | Олон улсын байгууллага | Лабораторийн шинэ байр | ХАБҮЛЛ-ын 1,2,5-р давхар | Лабораторийн байрыг зохистой дадлын шаардлагад нийцүүлэн шинэчилсэн ХӨСҮТ-ийн лабораторийн байранд үйл ажиллагаа эхлүүлсэн байна. | Лабораторийн байрны архитектур, инженерийн зураг төсөл 5 дугаар сарын 13-ны өдөр Төрийн нарийн бичгийн даргаар батлагдсан. Барилгын ажлын менежментийн олон улсын тендер 8 дугаар сарын 14-ний өдөр, дотоод засварын ажлын олон улсын тендер 8 дугаар сарын 20-ны өдөр, лабораторийн зориулалтын тавилга худалдан авалтын олон улсын тендер 8 дугаар сарын 21-ний өдөр тус тус зарлагдсан. Барилга, засварын ажилд ЭМ-СИ-ЭС проперти ХХК, барилгын засварын ажлын хяналт хийхээр ЭН-СИ-СИ-ЭС ХХК, лабораторийн тавилга нийлүүлэлтийг Монэга Энтерпрайзис ХХК хариуцан ажиллахаар тус тус шалгарсан. Барилга, засварын ажил эхэлж 11 дүгээр сарын 11-ний өдрөөс эхлэн 7 хоног бүрийн 2 дахь өдөр барилгын ажлын явцтай танилцаж байна. | 70 |
| 24 | Авлига ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх сургалт | 7-9 | Захиргаа удирдлагын газар | Танхим, цахим | Нийт албан хаагчид | Авлигатай тэмцэх газрын Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх хэлтсийн комиссар н.Балдандорж 2025.06.30-ны өдөр “Авлига ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх” сэдэвт сургалтад 2025.10.29-ний өдөр танхим, цахимаар нийт 73 албан хаагч хамрагдсан. |
| ДӨРӨВДҮГЭЭР УЛИРАЛД ЗОХИОН БАЙГУУЛАГДАХ СУРГАЛТ | | | | | | |
| 25 | Төрийн албан хаагчийг мэргэшүүлэх багц сургалтууд | 7-9 сар | Захиргаа, удирдлагын газар | Танхим, цахим | Төрийн захиргааны албан хаагчид | Удирдлагын академийн төрийн албаны сургуулийн мэргэшил дээшлүүлэх институтэд улсын төсвийн санхүүжилт болон байгууллагын зардлаар нийт 11 алба хаагчдыг сургасан.<br>-Төрийн албанд шинээр томилогдсон албан хаагчийг мэргэшүүлэх дунд хугацааны сургалтад-3,<br>-Төрийн албан хаагчийг мэргэшүүлэх дунд хугацааны давтан сургалтад-2,<br>-Ахлах түшмэлийн багц сургалтад-4,<br>-Эрхэлсэн түшмэлийн багц сургалтад -2 албан хаагчийг тус тус сургасан. |
| 26 | Төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээ /гадны сургалтын байгууллагатай хамтрах/ | 9-12 сар | Захиргаа, удирдлагын газар | Танхим, цахим | Нийт албан хаагчид | Нийт албан хаагчдыг ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх зорилгоор тайлант хугацаанд “BCH resource” ХХК-тай хамтран 2025.10.29-ний өдөр “Хэрхэн аз жаргалтай ажиллах нууц” сэдэвт сургалтыг |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | танхимаар болон цахимаар зохион байгуулсан. |
| 27 | МУШУА, Технолгийн инкубаторын “Микробиологийн шинжээчдийн чадавхыг дээшлүүлэх танхимыг сургалт | - | МУШУА, Технолгийн инкубатор | Танхим | Эм шинжлэх лаборатори | “Хүнс хөдөө аж ахуйн, хөнгөн үйлдвэрийн судалгааны хөгжлийн төв”-өөс зохион байгуулсан 3 өдрийн “Микробиологийн зохистой дадал, биоаюулгүйн ажиллагаа сургалт”-д 1 шинжээч, 2 лаборант хамрагдсан. |
| 28 | АШУҮИС-Био-Анагаахын хүрээлэнгийн “Лабораторийн амьтан судлал, шинжлэх ухааны хэрэглээ” сургалт | - | АШУҮИС-Био-Анагаахын хүрээлэн | Танхим | | 2025 оны төсөвт тодотгол хийж, байгууллагын төсвөөс сургалтын зардал гарах боломжгүй болсон учраас хэрэгжээгүй. |
| 29 | Agilent Demo Center-с зохион байгуулагддаг “Хийн хроматографи” багажны сургалт | - | Демо лаборатори | Танхим | | |
| 30 | PCR арга зүй эзэмшүүлэх | - | МУИС-н хэрэглээний шинжлэх ухаан инженерчлэлийн сургууль | Танхим | | |
| | I-IV ДҮГЭЭР УЛИРАЛД ЭРҮҮЛ МЭНДИЙН САЛБАРЫН МЭРГЭЖИЛТНҮҮДЭД ЗОХИОН БАЙГУУЛАХ СУРГАЛТ | | | | | |
| 31 | Хэвлэл мэдээллийн байгууллагуудад байгууллагын үйл ажиллагааг танилцуулах сургалт | 1-3 сар | ЗУГ | Танхим | Хэвлэл мэдээллийн байгууллагын удирдлага, мэдээний сэтгүүлчид | Сургалт, олон нийт, хэвлэл мэдээллийн асуудал хариуцсан мэргэжилтэн ажлаас чөлөөлөгдөж, Төрийн албаны нөөцөөс нөхөх зар тул тухайн сургалтыг зохион байгуулаагүй болно. |
| 32 | 2025 оны хяналт шалгалтын чиглэл, хяналт шалгалтын үйл ажиллагаанд | 1-3 сар | Чанарын хяналтын газар | Танхим | Аймаг, нийслэлийн улсын /ахлах/ байцаагчид | Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хуулийн шинэчилсэн найруулга батлагдсантай холбогдуулан Чанарын хяналтын газрын улсын /ахлах/ байцаагчид 2025.01.29-ний өдөр Хяналт шалгалтын үйл ажиллагаанд |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | ашиглагдах хяналтын хуудасны хэлэлцүүлэг | | | | | ашиглагдах хяналтын хуудасны хэлэлцүүлэг зохион байгуулсан.<br>Хэлэлцүүлэгт оролцсон алба хаагчдаас ирсэн саналыг тусгасан эм, биобэлдмэлийн хяналт, шалгалтын үйл ажиллагаанд ашиглагдах 4 төрлийн хяналтын хуудсыг ЭЭХХЗГ-ын даргын 2025 оны А/29 дүгээр тушаалаар батлуулж, байгууллагын цахим хуудсанд нийтэлсэн.<br>Нийтлэгдсэн хяналтын хуудасны нэршил:<br>10.16.1 кодтой "эмийн сангийн үйл ажиллагааг шалгах" хяналтын хуудас;<br>10.16.2 кодтой "эм, эмнэлгийн хэрэгслийн хадгалалт, түгээлтийг шалгах" хяналтын хуудас;<br>10.15.1 кодтой "эм, эмнэлгийн хэрэгслийн үйлдвэрийн үйл ажиллагааг шалгах" хяналтын хуудас;<br>10.17.1 кодтой Эрүүл мэндийн байгууллагын эм зүйн тусламж үйлчилгээг шалгах хяналтын хуудас. |
| 33 | Эмнэлгийн тоног төхөөрөмжийн инженер, техникийн ажилтан нарт зориулсан "Эмнэлгийн тоног төхөөрөмжийн засвар үйлчилгээ" сэдэвт сургалт | 1-9 сар | ЭТТГ | Танхим, цахим | Эрүүл мэндийн байгууллагын ЭТТ-ийн инженер техникч нарт | Нийслэл, орон нутгийн төрийн болон хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагын эмнэлгийн тоног төхөөрөмжийн инженер, техникч нарт зориулсан "Эмнэлгийн тоног төхөөрөмжийн хууль, эрх зүйн орчин болон аюулгүй байдал" сэдэвт сургалтыг 2025.09.28-ны өдөр зохион байгуулж, сургалтад нийт 46 байгууллагын 98 эмнэлгийн тоног төхөөрөмжийн инженер, техникч нар хамрагдаж гэрчилгээ олгосон. |
| 34 | Эм, эмнэлгийн хэрэгсэлд импорт, экспортын мэдүүлэг олгох журмын танилцуулах сургалт | 3-11 сар | ЛЗЗГ | Танхим цахим | ЭХНБ-ууд | Эм ханган нийлүүлэх байгууллага, Эмийн сан, төрийн өмчит эрүүл мэндийн 100 гаруй байгууллагын ажилтнуудад 2025.02.20-ны өдөр Эм, эмнэлгийн хэрэгсэлд импорт, экспортын мэдүүлэг олгох журмын танилцуулах сургалт, Шинэчлэн батлагдсан |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | эрх зүйн баримт бичигтэй холбоотой (хууль, цахим систем, стандарт, мэдүүлэг) сургалт зохион байгуулсан. |
| 35 | Орон нутгийн тусгай зөвшөөрөл олгох комисс болон орон тооны бус шинжээч нарт сургалт | 3-11 сар | ЛЗЗГ | Танхим цахим | Орон нутгийн ТЗОК олгох комисс болон шинжээч нар | Эрүүл мэндийн сайдын 2025.02.10-ны өдрийн А/40 дүгээр тушаалын дагуу тусгай зөвшөөрөл олгох комиссын 2023 оны А/402, орон тооны бус шинжээчийн ажиллах 2023 оны А/383 журмууд тус тус хүчингүй болсон тул тус сургалтыг зохион байгуулах шаардлагагүй болсон. |
| 36 | Цахим системийн хэрэглээний талаар эм хангах нийлүүлэх байгууллагуудад сургалт зохион байгуулна. | 3-11 сар | ЗУГ, ЛЗЗГ | Танхим цахим | ЭЭХХЗГ-ын мэргэжилтнүүд болон ААНБ-ууд | Цахим системийн хэрэглээний талаар эм ханган нийлүүлэх байгууллагын нийт 80 ажилтнуудад 2025.07.23, 2025.08.15-ны өдрүүдэд сургалтыг зохион байгуулсан. |
| 37 | Эмийн бүртгэлийн шинжээчид зориулсан сургалт | 4-6 сар | Эмийн бүртгэлийн хэлтэс /Д.Өлзийдулам ЭБХ-ийн ахлах мэргэжилтэн/ | Танхим | ЭЭХХЗГ-тай гэрээтэй Эм, оношлуур, БИБ-ийн бүртгэлийн шинжээч нар | Шинжээчид болон бүртгэлийн мэргэжилтнүүдэд 2025.09.24-ний өдөр сургалтыг зохион байгуулж 37 шинжээч хамрагдсан байна. |
| 38 | Эм бүртгүүлэгч байгууллагуудад зориулсан сургалт | 4-6 сар | Эмийн бүртгэлийн хэлтэс /Д.Өлзийдулам ЭБХ-ийн ахлах мэргэжилтэн/ | Танхим | Байгууллагуудын Эм, оношлуур, БИБ-ийн бүртгэл хариуцсан мэргэжилтэн | Эм бүртгүүлэгч байгууллагын 101 ажилтанд Эм эмнэлгийн хэрэгслийн тухай хууль, Эм, эмнэлгийн хэрэгсэл, эмийн үйлчлэгч бодис, эрүүл мэндийн нэмэлт бүтээгдэхүүнийг бүртгэх журмын талаарх сургалтыг 2025.07.23-ны өдөр зохион байгуулсан. |
| 39 | Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт шалгалтын эрх зүй, анхаарах асуудал | 4-6 сар | Чанарын хяналтын газар | Танхим | Аймаг, нийслэлийн улсын /ахлах/ байцаагчид | Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналтын улсын /ахлах/ байцаагчид 2025.02.25-2025.12.02-ны өдрийн хооронд “Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт шалгалтын эрх зүй, анхаарах асуудал” сэдэвт сургалтад танхим, цахим хэлбэрээр хамрагдсан. Сургалт танхим хэлбэрээр 1 удаа, цахим хэлбэрээр 12 удаа зохион байгуулагдсан ба цахим сургалтуудыг |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | Цагдаагийн ерөнхий газрын Хар тамхитай тэмцэх газар, Нийслэлийн Прокурорын газартай хамтран зохион байгуулсан. |
| 40 | Цахим мэдээллийн нэгдсэн тогтолцооны талаарх мэдээлэл өгөх сургалт | 4-9 сар | ЭХГ | Танхим | ЭМБ, ЭЭХХангамжийн байгууллагын мэргэжилтэн, албан хаагчид | Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт, зохицуулалтын нэгдсэн систем"-ийг хөгжүүлэгч ЭМХТ-ийн Цахим хөгжлийн албатай хамтран 2025 оны 07 дугаар сарын 29-ний өдөр хангамжийн байгууллагуудад Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт зохицуулалтын нэгдсэн системыг хүртээмжийг сайжруулах, мөн олон улсын жишигт нийцсэн ил тод, үр дүнтэй зохицуулалт хийх боломжой талаар сургалт зохион байгуулсан. Сургалтад танхимаар 50, цахимаар 100 ханган нийлүүлэх байгууллагын төлөөлөл буюу нийт 150 оролцогчийг хамруулан , шинэ програмтай танилцаж, хэрхэн ашиглах талаар сургалт зохион байгуулсан. |
| 41 | Эмнэлгийн тоног төхөөрөмжийн хөрөнгийн төлөвлөлтийн программын ашиглалтын сургалт | 4-9 сар | ЭТТГ | Танхим, цахим | Эрүүл мэндийн байгууллагын ЭТТ-ийн инженер техникч нарт | НҮБ-ын хүүхдийн сангийн санхүүжилтээр “Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт, зохицуулалтын нэгдсэн систем” -ийн хөгжүүлэлтийг Гэрэгэ системс ХХК-тай хамтран 2026 оны 6 дугаар сард нэвтрүүлэхээр ажиллаж байна. Тус хөгжүүлэлттэй холбоотойгоор Эмнэлгийн тоног төхөөрөмжийн хөрөнгийн төлөвлөлтийн HEPS программыг ашиглахгүй болох юм. |
| 42 | Худалдан авах ажиллагааны талаарх мэдээлэл өгөх сургалт | 7-9 сар | ЭХГ | Танхим | Нийслэл, орон нутгийн эрүүл мэндийн байгууллагын эм зүйч нарт | Азийн хөгжлийн банктай хамтран Төрийн өмчийн эрүүл мэндийн байгууллагуудын эм, эмнэлгийн хэрэгслийн худалдан авалт хариуцан ажиллаж буй мэргэжилтнүүдийн ерөнхий гэрээний талаарх ойлголт, хууль эрх зүйн мэдлэг, оролцоо болон чадавхыг нэмэгдүүлэхэд дэмжлэг үзүүлэх зорилгоор “Төрийн өмчийн эрүүл мэндийн байгууллагуудын оролцогч талуудыг ерөнхий гэрээний аргаар эм, эмнэлгийн хэрэгсэл |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | худалдан авах ажиллагаанд чадавхжуулах, хангамжийн тогтвортой байдлыг бэхжүүлэх нь" сэдэвт танхимын сургалтыг 2025.07.03-04-ний өдрүүдэд зохион байгуулсан. Сургалтад төрийн өмчийн эрүүл мэндийн байгууллагын нийт 37 эм зүйч, эмийн мэргэжилтнийг хамруулсан. |
| 43 | Эмийн зохистой хэрэглээг төлөвшүүлэх 10 хоногийн аяны хүрээнд ерөнхий боловсролын сурагчидад | 9 сар | ЭАБТСГ-ын мэргэжилтэн Танхим У. Соёл-Эрдэнэ | Танхим | Ерөнхий боловсролын сурагчид | Эмийн зохистой хэрэглээний аянд нэгдэж оролцох тухай АНЭМГ, ЭМБ-ууд руу 2025.09.11-ний өдөр албан бичиг хүргүүлсэн. Аяныг 2025.09.16-27 өдрүүдэд зохион байгуулж байгууллагын цахим хаягт рийл-7, зурагт хуудас-9, байршуулж 1522 like, 3288 share, 68800 хүн үзсэн байна. Аянд нэгдэж оролцон тайлангаа ирүүлсэн 35 ЭМБ, цахим жор бичилтээр тэргүүлсэн 6 ЭМБ-т агентлагийн даргын гарын үсгээр баталгаажуулсан батламжийг цахим шуудангаар 2025.11.03-07-ны хооронд хүргүүлсэн. |
| 44 | Эмийн зохистой хэрэглээг төлөвшүүлэх 10 хоногийн аяны хүрээнд сургуулийн өмнөх насны хүүхдүүд | 9 сар | ЭАБТСГ-ын мэргэжилтэн Танхим У. Соёл-Эрдэнэ | Танхим | Сүргуулийн өмнөх насны хүүхдүүдэд | |
| 45 | Эм үйлдвэрлэлд тавих ерөнхий шаардлага MNS 5524 стандартын сургалт | 10 сар | ЭҮХ | Танхим | Дотоодын эмийн үйлдвэрүүд | "Эм зүйн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн зохистой дадал" MNS 5524 стандартын шинэчилсэн төслийн сургалтад GMP-н шаардлага хангасан 10 үйлдвэрийн 20 гаруй албан хаагчдад зориулсан сургалтыг 2025.08.13-ны өдөр зохион байгуулсан. |
| 46 | Бичил биетний тэсвэржилтээс сэргийлэх дэлхийн 7 хоногийн аяны хүрээнд ерөнхий боловсролын сурагчдад | 11 сар | ЭАБТСГ-ын мэргэжилтэн С.Ганболор | Танхим | АШУҮИС-ийн Эм зүйн сургуулийн оюутнууд | АШУҮИС-ийн Эм зүйн сургуулийн 70 гаруй оюутнуудад бичил биетний эсрэг эмийн зохистой хэрэглээ, бичил биетний тэсвэржилтийн талаар 2025 оны 11 дүгээр сарын 24-ний өдөр мэдээлэл өгсөн. |

ХЯНАСАН:
ЗАХИРГАА УДИРДЛАГЫН ГАЗРЫН ДАРГЫН
АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ ........................ /Т.ХОНГОРЗУЛ/

БОЛОВСРУУЛСАН:
ЭМ ЗҮЙН САЛБАРЫН СУРГАЛТ,СУДАЛГАА
ШИНЖИЛГЭЭ, СТАТИСТИК БҮРТГЭЛ
ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТЭН ............................ /М.ОДОНТУЯА/

2025.12.24

“ТӨРИЙН АЛБАН ХААГЧИЙН АЖИЛЛАХ НӨХЦӨЛ, НИЙГМИЙН БАТАЛГААНЫ ХӨТӨЛБӨР”-ИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ 2025 ОНЫ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

| Д/д | Хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин /2024/ | Хүрэх түвшин /2025/ | Биелэлт | Хэрэгжүүлэх хугацаа |
|---|---|---|---|---|---|---|
| 1 | 2 | 3 | 4 | 5 | | 6 |
| **Нэг. Цалин хөлс, нэмэгдэл, шагнал урамшуулал, тэтгэвэр тэтгэмж, тусламж дэмжлэгийг хуулийн хүрээнд үзүүлэх зорилтын хүрээнд:** | | | | | | |
| 1.1 | Төрийн албан хаагчдын цалингийн сүлжээг шинэчлэн тогтоох тухай УИХ, Засгийн газраас баталсан шийдвэрийг хэрэгжүүлэх | Хамрагдсан албан хаагчдын тоо | 110 албан хаагч | 110 албан хаагч | Монгол Улсын Засгийн газрын 2024.12.25-ны өдрийн 238 дугаар тогтоолын дагуу 2025 оны 1 дүгээр сарын 02-ны өдрөөс Агентлагийн даргын 2025 оны А/01 дүгээр тушаалаар албан хаагчдын цалин хөлс нэмэгдлийг шинэчлэн баталсан. | I-IV |
| 1.2 | Албан хаагчдын сар бүрийн цалин, нэмэгдэл, урамшууллын талаарх мэдээллийг сар бүр цахим хэлбэрээр албан хаагчдад хүргэх | Хамрагдсан албан хаагчдын тоо | Албан хаагчдад 12 удаа | Албан хаагчдад 12 удаа | Албан хаагчдын сар бүрийн цалин, нэмэгдэл, урамшууллын талаарх мэдээллийг сар бүр ХНУМТ цахим системд шинэчлэлийг хийж албан хаагчдын мэйлээр цалингийн задаргааг цалин олгох тухай бүр хүргүүлсэн. | I-IV |
| 1.3 | Төрийн захиргаа, үйлчилгээний албан хаагчдын төрийн алба хаасан хугацааны нэмэгдэл олгох асуудлыг шийдвэрлүүлэх | Хамрагдсан албан хаагчдын тоо | Тухай бүр шийдвэрлэх | Тухай бүр шийдвэрлэх | Байгууллагад шинээр томилогдсон Төрийн захиргаа, үйлчилгээний нийт 17 албан хаагчдын төрийн алба хаасан хугацааны нэмэгдлийг | I-IV |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | | ХНУМТ цахим системд оруулсан. Мөн мэдээлэл зөрүүтэй байсан 3 албан хаагчийн мэдээллийг тушаалын дагуу засварлаж цахим системд оруулснаар төрийн алба хаасан хугацааны нэмэгдлээ бүрэн авч байна. | |
| 1.4 | Албан хаагчдын хоол унааны зардлыг сар бүр олгох | Нэмэгдсэн түвшин | 20,000 төгрөг | 20,000 төгрөг | Албан хаагчдын хоол унааны зардлыг сар бүр олгож байна. Нийт 2025 онд хоол унааны зардалд 506,173,732 төгрөг олгосон байна. | I-IV |
| 1.5 | Албан хаагчдын ажлын үр дүн, гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийг үнэлсэн үнэлгээг үндэслэн улирлын болон жилийн эцсийн урамшуулал олгох асуудлыг шийдвэрлэх | Олгосон урамшууллын дүн | 263,783,719 | Урамшуулал олгосон байна. | ЗГ-ын 301 дүгээр тогтоолын дагуу албан хаагчдын ажлын үр дүн, гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийг үнэлсэн үнэлгээг үндэслэн 2025 онд нийт 280,063,100 төгрөгийн урамшуулал олгосон. | II, IV |
| 1.6 | Тэмдэглэлт өдрүүдийг тохиолдуулан ажилдаа амжилт гарган ажиллаж байгаа албан хаагчдыг төрийн дээд одон, медаль, салбарын болон бусад байгууллагын шагналаар шагнах асуудлыг судлан шийдвэрлүүлэх | Шагнагдсан албан хаагчдын тоо | 2 албан хаагч | 5-аас дээш | Үндэсний их баяр наадам, Ардын хувьсгалын ойн баярын өдрийг тохиолдуулан байгууллагын газар хэлтсийн албан хаагчдаас шагналын материалыг хүлээн авч Эрүүл мэндийн яам руу 2025 онд 2 (6,11 сард) удаа хүргүүлсэн. | III-IV |
| 1.7 | Жилийн эцсийн ажлын | Шагнагдсан | | 5-аас дээш | Үндэсний их баяр | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | үзүүлэлтийг үндэслэн идэвх санаачлагатай, үр бүтээлтэй ажилласан албан хаагчдыг салбарын сайдын нэрэмжит шагналд тодорхойлох | албан хаагчдын тоо | 7 албан хаагч шагнал авсан | | наадам, Ардын хувьсгалын ойн баярын өдрийг тохиолдуулан байгууллагын газар хэлтсийн албан хаагчдаас шагналын материалыг хүлээн авч Эрүүл мэндийн яам руу 2025 онд 2 (6,11 сард) удаа хүргүүлсэн. | IV |
| 1.8 | Орон нутгийн нэмэгдэл, Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласны тэтгэмж /5 жил тутам/ олгох; | Албан хаагчдын тоо | 15 албан хаагч 131,551,200 төгрөг | 15 албан хаагч | Орон нутагт ажиллаж байгаа /давхардсан тоогоор/ 20 албан хаагчдад орон нутгийн нэмэгдэл /төсвөөс олгох/ болох 66,218,645 төгрөг, орон нутгийн 9 байцаагчид /орон нутгийн төсвөөс олгох ОННэмэгдэл/-д 29,726,440.57 төгрөгийг жилийн эцсийн байдлаар олгоод байна. Мөн 5 жил тутамд олгох мөнгөн урамшууллыг 3 албан хаагчид нийт 27,702,000 төгрөгийг олгосон. | I-IV |
| 1.9 | Тэтгэвэрт гарсан албан хаагчдад тэтгэмжийг олгох | Албан хаагчдын тоо | 1 албан хаагч 31,389,389 төгрөг | 3 албан хаагч | Засгийн газрын 2019 оны "Журам батлах тухай" 7 дугаар тогтоолын хавсралт Төрийн албан хаагчид өндөр насны тэтгэвэрт гарахад нэг удаагийн буцалтгүй тусламж олгох журмын дагуу 2025 онд 3 албан хаагчид тэтгэмжийг | I-IV |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | | олгосон. | |
| **Хоёр. Албан хаагчдын орон сууцны хангамжийг нэмэгдүүлэхэд дэмжлэг үзүүлэх зорилтын хүрээнд:** | | | | | | |
| 2.1 | Орон сууцаар хангагдах, нөхцлөөр сайжруулах талаар гаргасан албан хаагчийн өргөдөл хүсэлтийг бүртгэж, ил тод нээлттэй, шударгаар шийдвэрлэх нөхцлийг бүрдүүлэх | Хамрагдсан албан хаагчдын тоо | Тухай бүр судалж шийдвэрлэх | Тухай бүр судалж шийдвэрлэх | Байгууллагын албан хаагчдын орон сууцны нөхцлийн судалгааг нэгтгэн гаргаж Нийслэлийн орон сууцны корпорацид нийт 63 албан хаагчдын мэдээллийг хүргүүлэн нөхцлийг сайжруулах талаар албан хүсэлтийг хүргүүлсэн.<br>1 албан хаагч ипотекийн зээлэнд хамрагдсан. | I-IV |
| 2.2 | Албан хаагчдыг орон сууцны болон бусад зээл авахад шаардлагатай тодорхойлолт, мэдээллийг гаргаж өгөх | Хамрагдсан албан хаагчдын тоо | Тухай бүр судалж шийдвэрлэх | Тухай бүр судалж шийдвэрлэх | Орон сууцны болон бусад зээл авахад шаардлагатай тодорхойлолтыг 20 албан хаагчдад байгууллагын зүгээс гарган ажилласан. | I-IV |
| **Гурав. Ажиллах нөхцлийг сайжруулах үндсэн зорилтын хүрээнд** | | | | | | |
| 3.1 | Албан үүргээ гүйцэтгэхэд шаардлагатай тоног төхөөрөмж, эд хогшил, техник хэрэгслийн хэрэгцээг судлан тогтоож, шаардагдах хөрөнгийг жил бүрийн төсөвт тусгах замаар шийдвэрлэх | Батлагдсан төсөв | 273,397,300 төгрөгийн тоног төхөөрөмж худалдан авалт хийсэн | Тоног төхөөрөмж худалдан авалт хийх | Албан хаагчдад албан үүргээ гүйцэтгэхэд шаардлагатай тоног төхөөрөмж, эд хогшил, техник хэрэгслийн хэрэгцээг судлан тогтоож, багаж техник хэрэгслийн зардалд 17,167.5 мянган төгрөгийн төсөв батлуулсан.<br>Үүний дагуу 2025 онд албан хаагчдад шаардлагатай техник хэрэгсэлд 5,299.0 | I-IV |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | | мянган төгрөг зарцуулсан. | |
| 3.2 | Ажиллах орчин нөхцлийг сайжруулах зорилгоор ажлын байранд засвар үйлчилгээг хийх | Батлагдсан төсөв | Засвар хийгдсэн | Засвар хийгдсэн байна | Албан хаагчдын орчин нөхцлийг сайжруулах , өдөр тутмын үйл ажиллагааг хангаж ажиллах зорилгоор өрөөний тохижилт, засвар үйлчилгээнд 4,704.0 мянган төгрөг зарцуулсан байна. | I-IV |
| **Дөрөв. Албан хаагчдын сурч, хөгжих боломжийг бүрдүүлж, дэмжлэг үзүүлэх зорилтын хүрээнд:** | | | | | | |
| 4.1 | 2025 оны дотоод сургалтын төлөвлөгөөг баталж, хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах | Батлагдсан төлөвлөгөө | Төлөвлөгөөний дагуу сургалтын үйл ажиллагааг зохион байгуулсан. | Сургалтын төлөвлөгөөг баталж, хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах | “Төрийн албан хаагчийн сургалт”-ын төлөвлөгөөг 2025 оны 01 дүгээр сарын 15-ны өдөр дотоод сургалт буюу 29 арга хэмжээ, гадаад сургалт буюу 17 арга хэмжээ хэрэгжүүлэхээр төлөвлөж, баталсан. | I-IV |
| 4.2 | Засгийн газрын захиалгын дагуу Удирдлагын академид зохион байгуулагдах богино хугацааны сургалтуудыг хамтран зохион байгуулж, сургалтад нэгжийн удирдлага, мэргэжилтнүүдийг хамруулах | Хамрагдсан албан хаагчдын тоо | 10 албан хаагч сургасан. | Албан хаагчдыг квотын дагуу сургах | Удирдлагын академийн төрийн албаны сургуулийн мэргэшил дээшлүүлэх институтэд улсын төсвийн санхүүжилт болон байгууллагын зардлаар нийт 11 алба хаагчдыг сургасан.<br>-Төрийн албанд шинээр томилогдсон албан хаагчийг мэргэшүүлэх дунд хугацааны сургалтад-3,<br>-Төрийн албан хаагчийг мэргэшүүлэх дунд | I-IV |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | | хугацааны давтан сургалтад-2,<br>-Ахлах түшмэлийн багц сургалтад-4,<br>-Эрхэлсэн түшмэлийн багц сургалтад -2 албан хаагчийг тус тус сургасан байна. | |
| 4.3 | Авлигатай тэмцэх газраас зохион байгуулагдах богино хугацааны сургалтуудыг хамтран зохион байгуулж, сургалтад газар, хэлтсийн дарга, мэргэжилтнүүдийг хамруулах | Хамрагдсан албан хаагчдын тоо | 110 албан хаагч танхим, цахим хэлбэрээр хамрагдсан. | Албан хаагчдыг сургалтанд хөтөлбөрийн дагуу сургах | Авлигатай тэмцэх газрын Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх хэлтсийн комиссар н.Балдандорж 2025.06.30-ны өдөр “Авлига ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх” сэдэвт сургалтад 2025.10.29-ний өдөр танхим, цахимаар нийт 70 албан хаагч хамрагдсан. | I-IV |
| 4.4 | Төрийн албан хаагчийн мэргэшүүлэх сургалтад газар хэлтсийн дарга, мэргэжилтнүүдийг хамруулах | Хамрагдсан албан хаагчдын тоо | 11 албан хаагч хамрагдсан. | Албан хаагчдыг сургалтанд хөтөлбөрийн дагуу сургах | Удирдлагын академийн төрийн албаны сургуулийн мэргэшил дээшлүүлэх институтэд улсын төсвийн санхүүжилт болон байгууллагын зардлаар нийт 11 алба хаагчдыг сургасан.<br>-Төрийн албанд шинээр томилогдсон албан хаагчийг мэргэшүүлэх дунд хугацааны сургалтад-3,<br>-Төрийн албан хаагчийг мэргэшүүлэх дунд | I-IV |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | | хугацааны давтан сургалтад-2,<br>-Ахлах түшмэлийн багц сургалтад-4,<br>-Эрхэлсэн түшмэлийн багц сургалтад -2 албан хаагчийг тус тус сургасан байна. | |
| 4.5 | Албан хаагчдыг байгууллагын болон зохион байгуулагч талын зардлаар гадаад сургалтад хамруулах /цахим, танхим/ | Хамрагдсан албан хаагчдын тоо | 20 албан хаагчийг байгууллагын болон зохион байгуулагч талын зардлаар сургасан. | Албан хаагчийг сургаж, батламж олгох | Албан хаагчдыг хөгжүүлэх, мэргэшүүлэх чиглэлээр зохион байгуулагч талын зардлаар хамруулсан (гадаад сургалт) 32 алба хаагч хамрагдсан.<br>АНЭУ-ын Абу даби хот 2025.11.22-11.27 хүртэл 1 албан хаагч<br>-ОХУ Москва хот 2025.09.15-09.19 хүртэл 1 албан хаагч<br>-БНФУ-ын Манила хот 2025.09.08-09.12 хүртэл 1 албан хаагч<br>-БНСУ- Сөүл хот 2025.05.24-08.10 хүртэл 2 албан хаагч<br>БНСУ- Сөүл хот 2025.08.25-09.05 хүртэл 14 албан хаагч<br>БНСУ- Сөүл хот 2025.10.27-11.14 хүртэл 4 албан хаагч<br>БНСУ- Сөүл хот 2025.11.17-11.21 хүртэл 1 албан хаагч | I-IV |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | | БНСУ- Осонг хот 2025.06.16-06.20 1 албан хаагч<br>-Япон улсын Токио хот 2025.02.25-02.28 хүртэл 2 албан хаагч<br>Япон улсын Токио хот 2025.06.02-06.08 хүртэл 1 албан хаагч<br>-БНХАУ-ын ӨМӨЗО Хөх хот 2025.05.10-05.18 2 албан хаагч<br>-БНПУ 2025.03.11-03.17 хүртэл 2 албан хаагч гадаад улсад зохион байгуулагдсан сургалтад хамрагдсан байна | |
| **Тав. Албан хаагчдын эрүүл мэндийг хамгаалж, эрүүл амьдрах дадлыг хэвшүүлэх зорилтын хүрээнд:** | | | | | | |
| 5.1 | Эрүүл мэндийн яам болон бусад байгууллагаас уламжлал болгон зохион байгуулагддаг 5 төрөлт спортын тэмцээнд ЭЭХХЗГ-ын шигшээ баг бүрдүүлж, бэлтгэл ханган оролцуулах | Зохион байгуулагдсан уралдаан, тэмцээн | 1-ээс дээш | 1-ээс дээш | Эрүүл мэндийн яамнаас уламжлал болгон зохион байгуулагддаг Сайдын нэрэмжит спортын 5 төрөлт тэмцээнд нийт 37 тамирчин амжилттай оролцсон. | I-IV |
| 5.2 | Албан хаагчдад ажлын байран дахь дасгал, хөдөлгөөнийг хэвшүүлэх үүднээс клуб, дугуйлан ажлын байранд явуулах, дэмжих | Хамрагдсан албан хаагчдын тоо | - | Албан хаагчид клуб, дугуйланд хамрагдах | "Lotus иог"-ийн клубтэй хамтран байгууллагын нийт 12 албан хаагч долоо хоногийн 1,3,5 өдрүүдэд уламжлалт иог буюу хатха, пилатес иогоор амралтын өрөөнд хичээллэж байна. | I-IV |
| **Зургаа. Төрийн албан хаагчийн нийгмийн хэрэгцээ, сэтгэл зүйн хандлагыг мэдэрч, байгууллагын соёл, хамт олны уур амьсгалыг өөрчлөх замаар албан хаагчдын ажлын байран дээрх сэтгэл ханамжийг сайжруулах зорилтын хүрээнд:** | | | | | | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| 6.1 | Байгууллагын соёл, зохион байгуулалт, хүний нөөцтэй холбоотой асуудлаар сэтгэл ханамжийн судалгааг албан хаагчдаас жил бүр авч, үнэлэлт, дүгнэлт хийж ажиллах | Хамрагдсан албан хаагчдын тоо | 50-ээс дээш | 90-ээс дээш | Байгууллагын соёл, зохион байгуулалт, хүний нөөцтэй холбоотой асуудлаар сэтгэл ханамжийн судалгааг 2025 оны 12 дугаар сард 101 албан хаагчаас авсан. | IV |
| 6.2 | Эх үрсийн баяр, Салбарын тэмдэглэлт өдөр, Шинэ жил, Олон улсын эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах өдөр, Ахмадын баярыг тэмдэглэн өнгөрүүлэхэд зардлын тодорхой хувийг хууль тогтоомжийн дагуу шийдвэрлэх | Хамрагдсан албан хаагчдын тоо | Төсөвт багтаан тухай бүр шийдвэрлэсэн | Шийдвэрлэсэн байна | Хүүхдийн баярыг тохиолдуулан албан хаагдын нийт 194 хүүхдэд Агентлагийн даргын А/118 тушаалаар бэлэг өгсөн. | I-IV |

ХЯНАСАН:
ЗАХИРГАА УДИРДЛАГЫН ГАЗРЫН ДАРГЫН
АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ ........................ /Т.ХОНГОРЗУЛ/

БОЛОВСРУУЛСАН:
ХУУЛИЙН АСУУДАЛ ХАРИУЦСАН
МЭРГЭЖИЛТЭН ................................/Н.ГАНДОЛГОР/

2025.12.24

ЭМ, ЭМНЭЛГИЙН ХЭРЭГСЛИЙН
ХЯНАЛТ, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗАР

# ХЭРЭГЛЭГЧИЙН ҮНЭЛГЭЭНИЙ ХУРААНГУЙ ТАЙЛАН, НЭГДСЭН САНАЛ ЗӨВЛӨМЖ

Улаанбаатар
2025 он

# 1. Та манай байгууллагаас авсан үйлчилгээний төрөл аль бэ?




Нийт хэрэглэгчийн 37.3 хувь нь Чанарын хяналтын газар, Эмийн бүртгэл хэлтэс 16 хувь, Бусад 11.8 хувь Эмийн аюулгүй байдлын тандалт судалгаа газар, Тусгай зөвшөөрөл, мэдүүлэг олголт 7.7 хувь , Эмийн үйлдвэр 6.8 хувь, Эм шинжлэх лаборатори 5.6 хувь, Эмнэлгийн тоног төхөөрөмжийн баталгаажуулалт 3.3 хувь, Эмийн хангамж 1.8 хувь нь тус газар хэлтсээр үйлчлүүлсэн байна.

## 2. Үнэлгээний хэсэг




Үйлчлүүлэгч тухайн байгууллагын үйлчилгээний хүртээмж, цаг хугацаанд хэр сэтгэл хангалуун байгааг асуухад 3.9 хувь нь маш муу, 5.1 хувь нь муу, 11.9 хувь нь хэвийн 26.8 хувь нь сайн 52.4 хувь нь маш сайн гэж хариулсан байна.




Үйлчлүүлэгч Үйлчилгээний чанар, мэргэжлийн түвшин хэр сэтгэл хангалуун байгааг асуухад 2.1 хувь нь маш муу, 1.6 хувь нь муу, 11.2 хувь нь хэвийн 24.3 хувь нь сайн 60.7 хувь нь маш сайн гэж хариулсан байна.

## Ажилтнуудын харилцаа, ёс зүй




Үйлчлүүлэгч ажилтнуудын харилцаа, ёс зүйд хэр сэтгэл хангалуун байгааг асуухад 2.4 хувь нь маш муу, 2.4 хувь нь муу, 6.2 хувь нь хэвийн 23.1 хувь нь сайн 65.9 хувь нь маш сайн гэж хариулсан байна.




Үйлчлүүлэгч мэдээлэл, зөвлөгөөний тодорхой байдалд хэр сэтгэл хангалуун байгааг асуухад 3.3 хувь нь маш муу, 4.2 хувь нь муу, 8.9 хувь нь хэвийн 24.3 хувь нь сайн 59.3 хувь нь маш сайн гэж хариулсан байна.

## Баримт бичгийн боловсруулалт, ил тод байдал




Үйлчлүүлэгч баримт бичгийн боловсруулалт, ил тод байдал хэр сэтгэл хангалуун байгааг асуухад 2.4 хувь нь маш муу, 3.3 хувь нь муу, 7.7 хувь нь хэвийн 27.7 хувь нь сайн 58.9 хувь нь маш сайн гэж хариулсан байна.




Үйлчлүүлэгч нийт сэтгэл ханамж хэр сэтгэл хангалуун байгааг асуухад 3.6 хувь нь маш муу, 3.3 хувь нь муу, 10.1 хувь нь хэвийн 24 хувь нь сайн 59.1 хувь нь маш сайн гэж хариулсан байна.

# 3. Санал, сэтгэгдэл

## 1. Та манай байгууллагын үйлчилгээнд сэтгэл хангалуун байсан уу?

Лаборатори болон ЭЭХХЗГ ажлын уялдааг сайжруулах. Нэгдсэн нэг ойлголтыг хангаж ажиллах

Тогтолцоо, мэргэжилтний харьцаа хандлага, үйлчилгээг сайжруулах, улам хүндрэл үүсгэж байгаа

Эм шинжлэх лаборатори хүчин чадал муу, зуны турш засвар хийсэн болохоор шинжилгээний хариу маш удаан гардаг, үүнээс болоод бүртгэлийн сунгалт дээр дандаа асуудал үүсдэг, Тандалт судалгааны албаны харилцаа хандлага муу, бүртгэлийн явц удаан, шинжээч багш нар зарим үед маш удаан дүгнэлт гаргадаг,

Лицензийн албаны мэргэжилтнүүд импортын мэдүүлгийг цаг хугацаанд нь гаргаж өгдөг. Олон хүнтэй харилцдаг стресстэй гэдгийг ойлгодог ч ажилтнуудын харилцаа хандлагад анхаарч өгнө үү. Ойлгомжгүй байгаа зүйлээ асуухад уриалгахан тайлбарлаж өгдөг байвал маш их баярлана.

Орон нутагт эмийн сан ,ЭХНБ, эмнэлэг олон ганц байцаагч байгаа тул орон тоог нь нэмэх, орон нутагт Эмнэлгийн чанарын хяналт хариуцсан тасаг ,албатай болох

Импортын лицензийг ажлын 5 өдөртөө багтааж гаргаж байх, эмийн бүртгэлийн хурал, сунгалт, өөрчлөлтийг заасан хугацаандаа тогтмол хийж байвал зөв байна.

Лабораторийн үйл ажиллагаа тогтвортой, процесс нь журмын дагуу эсвэл шаардлага тавьж үйл ажиллагаагаа явуулах хэрэгтэй байна. Үйл ажиллагааны процессоо байнга өөрчилдөг. Нэг очиход л ингэхээр болсон тэгэхээр болсон гэдэг. Үнэхээр ойлгомжгүй. Мэдээлэл, зөвлөгөөний тодорхой байдал бага байдаг үүнийгээ сайжруулбал мөн баримт бичгийн мэдээлэл ирдэггүй үүнийг байгууллагын санхүү рүү мөн илгээгдэхээр сайт дээрээ оруулж өгвөл илүү амар болно байх

Tanai baiguullagiin ajil uilchilgee sain

Хурд сайжруулах, боловсруулах баримт бичгийг эмхэтгэж товч цөөн болгох тал дээр анхаарвал сайн.

Маш удаан, хурал зарлагдах, шинжилгээний хариу гарах гэх мэт зүйлсэд хамгийн хурдандаа 2-3 сар зарцуулагддаг. Нэг эм бүртгэгдэхэд бараг 4-6 сар болж байна.

Журмын хугацаандаа асуудал шийдэгдэхгүй байгаа. Жишээ нь шинжээч дээр 5 сар хүлээж байна.

| |
|---|
| Бүртгэл хариуцсан мэргэжлийн орон тоог нэмэгдүүлэх |
| Утсан холбоогоор мэдээлэл авахад бэрхшээлтэй |
| Асуудлыг цагт нь шийддэг |
| Шинжилгээний хариу хүлээгдэл их, чадамж муутай, харилцаа хандлага муу, үйл явц нь ойлгомжгүй. |
| Хуулийн хугацааг мөрдөн ажиллахыг хүсэж байна. ЭМНБ-ний бүртгэл хариуцсан мэргэжилтэн болон Licemed систем хариуцсан мэргэжилтэн ажлын ачаалал ихтэй харагддаг. Үүнээс болж бүртгэлийн үйл явц удаашрах нь элбэг болсон. Үүнийг анхааралдаа аваасай |
| Сургалт болон танилцуулга хийж байгаа presentation--ээ байгууллагууддаа тарааж өгдөг болбол сайн байна. |
| сануулга зөвлөмж өгч байвал зүгээр |
| Хамтран ажилладаг байгууллагууд олон учир хурдан шуурхай ажиллахын тулд хүний нөөцийг нэмэгдүүлэх шаардлагатай багаж хэрэглэлийг нэмэх<br>Манай байгууллагын үйлчилгээнд дараах хүндрэлүүд байнга тулгарч байна. Үүнд: шинжилгээний дээж хүлээн авах, боловсруулах явц ачаалал өндөртэйгөөс хариу гарах хугацаа удааширдаг, зарим тохиолдолд дээж авах боломжгүй гацаж саатдаг зэрэг асуудлууд орж байна. Үүний улмаас эмийн бүртгэл, сунгалтын үйл ажиллагаа удааширч, бүртгэлээс хасагдах эрсдэл үүсэж байна. Иймд эдгээр процессыг сайжруулах, ажлын ачааллыг оновчтой зохицуулах, дээж хүлээн авах үйл явцыг тогтмолжуулах талаар арга хэмжээ авч өгнө үү. |
| Мэргэжилтнүүдийн ачаалал их тул бичиг баримт шалгуулахаар очиход шалгуулж амждаггүй буцдаг. Олон удаа очиж байж шалгуулдаг. |
| Стандарт бодис, урвалжуудын хангамжийг нэмэгдүүлэх шаардлагатай гэж үзэж байна. |
| Мэдээллээ ил тод жигд хүртээмжтэй тараах, хариу хурдан гаргах |
| Заавар өөрчлөлтийн Бүрдүүлэх материал болон шийдвэрлэлтийн талаарх мэдээлэл хүргэлт тодорхой байдаг нь маш ойлгомжтой, амар байдаг<br>Зөвлөн тусалж мэдээллийг түргэн шуурхай өгдөгт баярладаг. |

| |
|---|
| Маш сайн хүртээмжтэй |
| Зөвлөлийн хурлаа сард 2-3 удаа хийх |
| Хяналт шалгалт сайн хийдэг зөвлөгөө сайн өгдөг. |
| Zarim zuil n denduu todorhoigui. Tsag hugatsaanii huvid mash ih udaashraltai. Buh zuil n todorhoi bval sn bn. Hundrel chiregdel ihtei |
| Лабораторийн үйл ажиллагааг сайжруулах |
| Цаашид мэдээ, мэдээллээ олон сувгаар дамжуулдаг байх |
| Эмийн зар сурталчилгаанаас бусад талаар, Мэргэжилтнүүд нь харилцаа хандлага сайтай байдаг. |
| Үйлчилгээ сайн |
| Лабораторийн ажлыг хурдан шуурхай болгомоор байна. Шинжээч нарын материал үзэж дүгнэлт гаргадаг хугацааг богино болгомоор байна. 1 сар шахуу уншина гэдэг урт хугацаа гэж ойлгож байна. |
| Мэдээллийг ил тод нээлттэй мэдээлж байх , мэргэжилтнүүдээ сургалтаар хангах мэдлэг ур чадварыг нэмэгдүүлэх |
| Онлайнаар хүсэлт өгөөд бүх бичиг баримт асуудалгүй үед дээжээ өгдөг болох. |
| Лабораторид дээж өгөхөд хэцүү байна. |
| ЭМНБ-ий холбогдох дүрэм журамтай холбоотой сайжирч байгаа гэж ойлгож байгаа. |

## 2. Ямар асуудлыг сайжруулах шаардлагатай гэж үзэж байна вэ?

Аливаа мэдээлэл болон шинээр хэрэгжиж буй журам зааврын мэдээллээр бүрэн хангах, өөрчлөлтийг цаг тухай бүрт түгээх

Эмийн бүртгэлийг цахим болон цаасаар аль алинаар давхар хийж байгаа нь маш их цаг хугацаа ажил болж байна.(боловсруулах ,архивлах, хүргэж өгөх, авах ).эсвэл цахим эсвэл цаасаар аль нэг хувилбарыг сонгомоор байна.

Шинжилгээ, бүртгэл, лиценц, мөн албаны утсаа авдаггүй, эргээд хариу өгдөггүй

Бүгд сайн

Эм шинжлэх лабортори сайжруулах, хүчин чадал муу учраас ихэнх үзүүлэлт хийж чаддаггүй, олон лабораторитой болох, эсвэл зарим үед үйлдвэрлэгчийн шинжилгээний хариугаар сунгалт хийх

Одоогоор байхгүй

Мэдээлэл илүү сайн өгөх, хурдан шуурхай ажиллах

Орон тоо нэмэгдүүлэх

ХЭЗ хурал болон ЭССЗ хурлуудыг хийх хугацааны давтамжийг нэмэгдүүлэх
Эмийн орц найрлагын чанарыг сайжруулах, дотоодын чанартай эмийн үйлдвэрлэлийг дэмжих, олон төрлөөр хөгжүүлэх/адуу бренд гм/

Эмч мэргэжилтний мэдлэг чадвар, ёс зүйн асуудлыг сайжруулах.Хэт бизнес хийхгүй байхад төрийн дэмжлэг хэрэгтэй , жорыг зөвхөн цахимд шилжүүлэх, Био нэмэлт ,болон жоргшй олгох эмийг ТВ, болон сүлжээнд сурталчилахгүй болгох. Эрх баригчид бүх шатанд хамааралтай байна.

Лабораторийн төнөг төхөөрөмжийг шинэчилэх, эмийн шиншилгээний хариуг уг эмийн шинжилгээ хийх хугацаанд нь шинжилгээгээ хийж хэвшүүлэх.

Лабораторийн үйл ажиллагааг сайжруулах маш их шаардлагатай. Шинжилгээ хийх хугацаа удаан. 6 сар болох бол хурдандаа орж байна.

Мэдээлэл, зөвлөгөөний тодорхой байдал бага байдаг үүнийгээ сайжруулвал мөн баримт бичигийн мэдээлэл ирдэггүй үүнийг байгууллагын санхүүрүү мөн илгээгдэхээр сайт дээрээ оруулж өгвөл илүү амар болно байх

Tusgai zuvshuurliin olgoltiin hyanaltiig ulam saijruulah

| |
|---|
| Бүгд сайн байгаа |
| emiig onlinaar hudaldan borluulj bgaag zogsooh |
| ЭМНБ ий бүртгэлийн хүч хүчээ нэмэх. Маааааш удаан! |
| Журамд заасан хугацаандаа үйлчилгээгээ авдаг болмоор байна. |
| Утсаар болон цахимаар мэдээлэл сайн байна. |
| Удирдлага зохион байгуулалтыг сайжруулах, хүртээмжийг нэмэгдүүлэх, чадамжийг сайжруулах. |
| ЭЭХХЗГ-н лабораторийн хүчин чадлыг нэмэгдүүлэх, шинжилгээний хариу хүлээгдэх хугацааг багасгах |
| Хүртээмжийг нэмэгдүүлмээр байна. |
| Удирдлагын тогтвортой байдал. |
| Хуулийн хугацааг мөрдөж ажиллах, эмийн бүртгэлийн шинжээч дээр бас маш удаж байгаа |
| Сургалтад хамрагдахад ширээ сандал нэмэгдүүлэх, мөн дэлгэцрүү цацадаг пректор биш шууд дэлгэцээр харуулдаг болгох |
| Дуудлага авах үйлчилгээ сайжруулах |
| Одоогоор сайжруулах шаардлагатай гэж үзэх асуудал байхгүй байна. |
| Мэдээ мэдээлэл, болон зөвлөгөө өгч байгаа ажилтнуудынхаа харилцаандаа анхаарах хяналт |
| Salbar zuwluliin hurluudiig huralddag todorhoi hugatsaatai bolgoh heregtei hzee hural ni boloh ni todorhoigui, hural hzee we hzee we geed bainga asuuh tuwugtei bdg |
| **Hurlaa sar bur togtson udurt hiimeer bn.** |
| Шинжилгээ хийх хугацааг 14-21 хоногт багтааж хариу гаргах |
| Эмийн зар сурталчилгаатай холбоотой ойлгомжгүй зүйлс их тулгардаг. Хариуцсан мэргэжилтэн харилцаа хандлагаа сайжруулах шаардлагатай. Ажлын явц маш тодорхой бус удаан. Хариуцсан мэргэжилтнийг чадавхжуулах, хуулийн хугацаандаа ажлаа хийж гүйцэтгэх. Бид дайснууд биш, хамтдаа асуудлыг шийдвэрлэх гэж ажиллаж байгаа гэдгийг ойлгоосой гэж хүсч байна. |

| |
|---|
| Эрүүл мэндийн яамны дараагаар ордог газар учир жоохон мэдээ мэдээллийг өгч ажиллах<br>1. Дээж хүлээн авах процессыг сайжруулах Дээж хүлээн авах ажлыг цагийн хуваариар төрөлжүүлэн зохион байгуулах Өндөр ачааллын үед түр нэмэлт цэг/ажилтан ажиллуулах Онлайнаар дугаарлан бүртгэх систем нэвтрүүлэх<br>2. Гацалт үүсдэг шалтгааныг тодорхойлж, тогтмол ажиллагаатай болгох Дээж авах төхөөрөмж, лабораторийн системийн хяналт, засвар үйлчилгээний давтамжийг нэмэгдүүлэх Гацалтын үед ашиглах нөөц төхөөрөмж, нөөц шугам ажиллуулах<br>3. Шинжилгээний хариуны хугацааг тогтмолжуулах Давтамжтай шинжилгээний ажлыг даралт багатай өдрүүд рүү хуваарилах Туршлагатай шинжээчдийг ачаалал ихтэй төрөл дээр төвлөрүүлэх Оролцогч байгууллагад түргэвчилсэн горим санал болгох боломж судлах<br>4. Ачаалалтай үед ажлын зохион байгуулалтыг оновчтой болгох Ажлын оргил үед нэмэлт ажиллах хүч татах Шинжилгээний шат бүр дээрх ажлын урсгалыг оновчлох (workflow optimization)<br>5. Харилцаа, мэдээллийн ил тод байдлыг нэмэгдүүлэх Дээжийн хүлээн авалт, явц, хариу гарах хугацааг онлайнаар хянах боломжтой систем нэвтрүүлэх Хариу саатах тохиолдолд урьдчилан мэдээлэх тогтолцоо бий болгох<br>6. Эмийн бүртгэл болон сунгалтын гацалтаас сэргийлэх Шинжилгээний хариуны хугацааг эмийн бүртгэлийн хууль ёсны хугацаанд багтаах тогтолцоо бүрдүүлэх Сунгалттай бүртгэлүүдэд өндөр эрсдэлийн ангилал өгч түргэвчилсэн байдлаар хүндэтгэн үзэх Эмийн бүртгэлийн тасаг болон шинжилгээний лабораторийн хоорондын шууд мэдээллийн солилцоог сайжруулах |
| Мэргэжилтний ачааллыг бууруулах |
| asuudal shiidwerleh hugatsaag hurdasgah |
| Шинжилгээний хариуг цаг тухайд гаргаж өгөх |
| Хүний нөөцөө нэмэх шаардлагатай |
| Эм ханган нийлүүлэх төвүүдийн эмийн чанарт тавих хяналтыг сайжруулах |
| бүгд сайн |
| Боломжийн байна |
| одоогоор алга |
| Нэг хүний ажлын ачаалал их. |

## 3. Нэмэлт санал, хүсэлт

Бүртгэл сунгалт дээр Тандалт судалгааны албанаас мэдээлэл өгөх, лавлагаа авсан байгаа хэр нь дахин мэдээлэл өгөх, Эм шинжилгээний лаборатори сайжруулах, тоог олон болгох өөр лабораториудтай хамтран ажиллах

Дотоодын эмийн үйлдвэрлэлийг дэмжиж тоног төхөөрөмжийг сайжруулах, үйлдвэрлэлийн нөөцийг хүрэлцээтэй болгох. Жнь: адуу брэндийн зүрх судасны биобэлдмэл хөдөө орон нутагт олдоц муу, байнга тасарч байна. Үүнээс улбаатай үнэ ханш өсөж байна

Төрийн ЭХНБ , эмийн сан байхгүй нь төрийн бодлогыг хэрэгжихэд зохицохгүй байна. Төр ХХБ нь хамтарч ажиллаж чадахгүй байна.

Эрүүл энхийн үйлсэд хамтран ажилладаг танай хамт олонд ажлын өндөр амжилт хүсэн ерөөе.

Байгууллагатай холбогдох менежерүүдийн мэдүүлэл хомс гэрээн дээр заасан хүн нь ажлаас гарсан тохиолдолд дараагийн хариуцсан хүний мэдээллийг байгууллагад мэдээлдэггүй учраас хайх шаардлага үүсдэг.

Tusgai zuvshuurul ezemshigch ni zaaval mergejliin baih, emch ezentei emch jor barigchtai emiin sanguud ajillasaar l bg, Em zuichiin litsenz tureesledeg yavdliig bur musun zogsooh sanaluud bna
eryyl mendiin daatgalaar ugch bui emiin yniin jagsaalt shinechleh asuudal ontsgoi anhaarch emiin sanguudiin yil ajillagaag demjih tal deer anhaarah

Хүн хүч нэмэх

Нэг мэргэжилтэнд хэт их ачаалал овоордог санагддаг

Лайс мэд хариуцсан хүн яаралтай томилох

Очиж үйлчилгээ авахад зүгээр байдаг

Цогцоор нь процессыг сайжруулах шаардлагатай.

Шинжилгээний дээж хүлээн авах үйл явц удааширдаг, ачаалал ихтэй. Дээж авч чадахгүй гацдаг тохиолдол үүсдэг. Шинжилгээний хариу гарах хугацаа тогтвортой бус, удаан. Үйлчилгээний явцын төлөвлөгөө, хугацааны менежмент тодорхойгүй. Ачаалал ихсэх үед нөөц ажиллах хүч, техник тоног төхөөрөмж дутмаг. Эмийн бүртгэл, сунгалтын үйл ажиллагаа хугацаандаа амжихгүй саатаж, бүртгэлээс хасагдах эрсдэл үүсдэг. Тиймээс энэ асуудлыг анхааралдаа авч сайжруулаасай гэж хүсэж байна.

| |
|---|
| Зөвлөлийн хуралаа сард 2 хийх |
| онц сайн |
| Laboratorin uil ajillagaag bogino hugatsaand shidverluulmeer bnz. Denduu achaalaltai. Emin burtgelin heltes, laboratorin ajilchdin hurteemj muu |
| Лабораторийн үйл ажиллагаагаа жигдрүүлж, шинжилгээний хугацааг тодорхой болгох, эсвэл бүртгэл сунгалт шинэ бүртгэлийн үйл ажиллагаанд шинжилгээний хариу шаардахаа болих |
| Нэг албан тушаалд 1 хүнийг олон жил томилох нь өөрөө ашиг сонирхлын зөрчил үүсгэх суурь нь болох боломжтой. Тийм учраас тодорхой хугацаанд сэлгэн ажиллуулах шаардлагатай гэж бодож байна. (Жишээ нь: эмийн зар сурталчилгаа) |
| Мэргэжилтэнүүдийн тоог нэмэх. Ялангуяа бүртгэл хариуцаж байгаа ажилтанууд |
| Baihguee |
| Мэргэжилтнүүдийн мэдлэг ур чадварт анхаарах. Харилцаа хандлагыг сайжруулах |
| санал хүсэлт байхгүй |
| Программыг нь сайжруулах саналтай байна |
| ХАБҮЛЛ микробиологи засвараас болж дээж авахгүй байсан үед эмийн бүртгэлийн хугацаа сунгалттай холбоотой хойшлогдсон бүтээгдэхүүний асуудлыг шийдвэрлэх |
| Албан хүсэлтийн хариу өгөх хугацаа нь дээрээ анхаарвал сайн байна. Нэг зүйл асуугаад ажлын 4 долоо хоногийн дараа хариу өгдөг, өгдөггүй тохиолдол ч байдаг. |
| Орон нутагт эмийн хяналт суларсан |
| Ажлын амжилт хүсье |
| Ачаалал их тул хүн нэмэх |
| Гаж нөлөө агентлагт мэдэгдсэн даруй үйлдвэрлэгч юмуу төлөөлөгчийн газарт тэр даруй мэдэгдэж, шийдвэрлэгдэхээс өмнө тодруулга хийхэд хамтран ажилладаг байвал гаж нөлөөнөөс үүссэн нөлөөг тэр даруй шийдвэрлэн бүртгэх боломжтой санагдсан<br>Licemed байна бүртгэлийн сайтад бүртгэгдсэн мэдээллийг нэгдсэн шаардлагын дагуу бүрэн, зөв болговол цаашдын ажил, үйл ажиллагаанд хялбар дөхөм болох юм шиг санагдаж байна. |

## 4. АВЛИГЫН ЭСРЭГ ҮЙЛ АЖИЛЛАГААНД ХАНДЛАГЫН ҮНЭЛГЭЭ




Үйлчлүүлэгч үйлчилгээний явц ил тод, нээлттэй байдлын талаар асуухад 3 хувь нь маш муу, 2.7 хувь нь муу, 13.5 хувь нь хэвийн 27.6 хувь нь сайн 53.2 хувь нь маш сайн гэж хариулсан байна.




Үйлчлүүлэгч ажилтнууд авлига, хүнд сурталгүй ажилласан талаар асуухад 2.7 хувь нь маш муу, 1.2 хувь нь муу, 9 хувь нь хэвийн 21 хувь нь сайн 66.1 хувь нь маш сайн гэж хариулсан байна.




Үйлчлүүлэгч үйлчилгээ авахад нэмэлт төлбөр, дарамт шахалт гараагүй талаар асуухад 2.1 хувь нь маш муу, 0.9 хувь нь муу, 5.4 хувь нь хэвийн 18.3 хувь нь сайн 73.3 хувь нь маш сайн гэж хариулсан байна.




Үйлчлүүлэгч авлигын эсрэг байгууллагын бодлого, мэдээлэл тодорхой байна талаар асуухад 1.5 хувь нь маш муу, 2.1 хувь нь муу, 9.6 хувь нь хэвийн 22.3 хувь нь сайн 64.5 хувь нь маш сайн гэж хариулсан байна.




Үйлчлүүлэгч авлигын эсрэг үйл ажиллагаанд итгэл үнэмшилтэй талаар асуухад 2.7 хувь нь маш муу, 1.8 хувь нь муу, 8.4 хувь нь хэвийн 21.1 хувь нь сайн 66 хувь нь маш сайн гэж хариулсан байна.

## ДҮГНЭЛТ

1. Судалгаанд оролцсон иргэд, хэрэглэгчийн дийлэнх буюу 37.3 хувь нь Чанарын хяналтын газар болон Эмийн бүртгэл хэлтсийн үйл ажиллагаатай холбоотой үйлчилгээ авсан байна. энэ нь иргэдэд буюу аж ахуйн нэгж нь эмийн бүртгэл шинээр бүрдүүлэх шаардлага хэрэгцээ байгааг харуулж байна. Мөн эмийн чанар болон хяналтын үйл ажиллагаатай холбоотой асуудлаар хандсан байна. 2024 онтой харьцуулахад тухайн байгууллагаар үйлчлүүлэхэд сэтгэл ханамж хангалуун байдаг үзүүлэлт 14 функцээр нэмэгдсэн байна.
2. Үйлчлүүлэгчээс байгууллагын үйлчилгээний хүртээмжийн талаар сэтгэл хангалуун байдлыг үнэлээд 10 орчим хувь нь муу, маш муу гэсэн хангалтгүй хариулт өгсөн нь үйлчилгээний хүртээмжийг цахимжуулах, угтах үйлчилгээний ажилтнаар хангах шаардлагатай байна.
3. Үйлчлүүлэгчээс мэдээлэл, зөвлөгөөний тодорхой байдал болон мэдээллийн ил тод байдлын талаар өгсөн үнэлгээг дүгнэхэд 8 орчим хувь муу, маш муу гэж үнэлсэн байна. Энэ нь хэдий бага хувиар үнэлсэн боловч ил тод, мэдээлэл, зөвлөгөө хангалтгүй байна гэж үзэж байна.
4. Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт, зохицуулалтын газрын даргын баталсан 2025 оны “Хэрэглэгчийн үнэлгээ хийх ажлын хэсэг байгуулах тухай” А/216 дугаар байгуулагдсан ажлын хэсэг Хэрэглэгчийн үнэлгээний ажлыг гүйцэтгэн Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт, зохицуулалтын газрын Хэрэглэгчийн үнэлгээ нь 2025 оны жилийн эцсийн байдлаар 94.6 хувьтай байна.

## САНАЛ ЗӨВЛӨМЖ

**Байгууллагын үйл ажиллагаа ба үйлчилгээг сайжруулах хүрээнд**

- Хэрэглэгчийн үнэлгээний судалгаанаас харахад үзүүлж буй үйлчилгээ чиг үүргийг иргэд олон нийтэд хүртээмжтэй болгох
- Тухайн байгууллагаас үзүүлж буй үйлчилгээг илүү сайжруулахад тогтолцоо, мэргэжилтний харьцаа хандлагыг сайжруулахад анхаарах, чиг үүргийн хүрээнд мэдээлэл зөвлөгөөг хугацаанд нь хүргэдэг байх
- Лабораторийн тоног төхөөрөмжийг шинэчлэн сайжруулах, эмийн шинжилгээний хариуг хугацаанд нь хийж хэвших, мөн хуулийн хугацаанд эмийн бүртгэлийг хийж бүртгэлийн хүний нөөцийн хангалтыг хийх шаардлагатай.
- Мэдээлэл, зөвлөгөөний тодорхойгүй болон эмийн зар сурталчилгаатай холбоотой ойлгомжгүй зүйлс их гардаг асуудлыг сайжруулах тал дээр байгууллагын цахим хуудас болон бусад мэдээллийн сувгуудаар түгээх үйл ажиллагааг төрөлжүүлэн нэмэгдүүлэх шаардлагатайг харуулж байна.

**Хүний нөөцийн хангалт, чадавхыг нэмэгдүүлэх хүрээнд**:

- Албан хаагчдын харилцаа хандлагаа сайжруулах, мэргэжилтнийг чадавхжуулах, иргэдэд түргэн шуурхай үйлчлэх, мэдээллийг цаг алдалгүй хүргэх, зөвлөгөө өгөх, хуулийн хугацаандаа ажлаа хийж гүйцэтгэх.
- Үйлчилгээний байгууллагын хувьд өргөдөл гомдлын механизм, шийдвэрлэх байдал, эргэх холбоог сайтар хангах, иргэдийн зүгээс гаргасан өргөдөл, гомдолд утас, интернэтээр эргэх холбоо үүсгэн түргэн шуурхай үйлчилгээ үзүүлэх, иргэдийн өргөдлийг хэрхэн шийдвэрлэснээ тухай бүрд нь мэдээлэх байдлыг анхаарах шаардлагатай байна.

## САНАЛ ЗӨВЛӨМЖ

**Авлигын эсрэг үйл ажиллагааны хүрээнд:**

- Авлигын эсрэг үйл ажиллагаанд итгэл үнэмшилтэй байдал болон ажилтнууд авлига, хүнд сурталгүй ажилласан талаар үйлчлүүлэгчийн үнэлгээгээр тодорхой хувийг эзэлж байгаа нь цаашид анхаарах асуудал болж байна. Энэ асуудлын шалтгааныг тодруулаагүй байгаа нь асуумж судалгааг нарийвчлан гаргах шаардлагатай байна.
- Үйлчлүүлэгч үйлчилгээ авахад нэмэлт төлбөр, дарамт шахалт гараагүй талаар асуухад 2.1 хувь нь маш муу, 0.9 хувь нь муу гэж хариулсан нь ямар үйлчилгэ авахад нэмэлт төлбөр авсан талаар тодруулга авах байсныг харуулж байна.
- Үйлчлүүлэгч үйлчилгээний явц ил тод, нээлттэй байдлын талаар асуухад 3 хувь нь маш муу, 2.7 хувь нь муу байгаа шалтгааныг тодруулахаар байна.

ЭМ, ЭМНЭЛГИЙН ХЭРЭГСЛИЙН ХЯНАЛТ, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗАР

# Анхаарал тавьсанд баярлалаа

Улаанбаатар
2025 он

